

**ШВЕЙЦАРИЙН ХӨГЖЛИЙН АГЕНТЛАГ
ТОГТВОРТОЙ БИЧИЛ УУРХАЙ ТӨСӨЛ**

**ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН БИГЭР СУМЫН
НИЙГЭМ ЭДИЙН ЗАСГИЙН СУУРЬ СУДАЛГААНЫ ТАЙЛАН**



ХӨГЖЛИЙН ЭЗЭД ТББ

ТАЛАРХАЛ

Энэхүү судалгааг хийхэд хамтран ажилласан П.Үржинлхүндэвээр удирдуулсан Швейцарийн Хөгжлийн Агентлагийн “Тогтвортой бичил уурхай” төслийн баг хамт олон, Говь-Алтай аймгийн ЗДТГ-ын Хөгжлийн Бодлогын хэлтсийн Байгаль орчин уул уурхайн асуудал хариуцсан мэргэжилтэн А.Мөнхтөр, Бигэр сумын засаг дарга Б.Нарангэрэл, Засаг даргын орлогч Г.Алтанхүү, ЗДТГ-ын бодлого зохицуулалт хариуцсан түшмэл, байгаль орчны хяналтын улсын байцаагч Ц.Мөнхбаяр, Газрын даамал С.Түвшин, сумын эмнэлгийн ерөнхий эмч Ц.Гиймаа, 5-р багийн засаг дарга Ганбат, “ХААН” банкны эрхлэгч Б.Мөнхбаяр, Хэсгийн төлөөлөгч Эрдэнэбат болон ЗДТГ-ын бусад ажилтан, сумын эмнэлэг, татвар, даатгал зэрэг төрийн үйлчилгээний байгууллагын ажилтан, албан хаагчид, сумын худалдаа үйлчилгээний газрууд, болон орон нутгийн бусад иргэдэд “Хөгжлийн эзэд” ТББ-ийн судалгааны багийн өмнөөс талархал илэрхийлье.

Түүнчлэн уг судалгааг гардан зохион байгуулж, аргачлал хөтөлбөр боловсруулах шатнаас үр дүнг хүлээлгэн өгөх хүртэлх ажилд цаг зав, сэтгэл гарган манай судалгааны багт зөвлөхөөр ажилласан МУИС-ийн Хүн амын сургалт судалгааны төв (ХАССТ)-ийн багш, судлаач магистр Б.Мөнхжаргал болон судалгаанд мэргэжлийн чиглэлийн дагуу баг болон мэдээ, мэдээлэл цуглуулах, компьютерт мэдээлэл оруулах, үр дүнг боловсруулах, нэгтгэх зэрэгт идэвхийлэн оролцож ажилласан бусад мэргэжил нэгт нөхөддөө чин сэтгэлийн талархал илэрхийлье.

Хөгжлийн Эзэд ТББ-ийн гүйцэтгэх захирал В. Бэрцэцэг

АГУУЛГА

	хуудас
Хүснэгтийн жагсаалт	5
Зургийн жагсаалт	7
Товчилсон үгсийн тайлбар	8
Нэр, томъёоны тайлбар	8
НЭГДСЭН ДҮГНЭЛТ	10
УДИРТГАЛ	14
БҮЛЭГ 1. СУДАЛГААНЫ ЗОРИЛГО, ЗОРИЛТ, ЗАГВАР	
1.1 Судалгааны зорилго, зорилтууд	15
1.2 Судалгааны арга	15
1.3 Судалгааны түүвэрлэлт ба чанарын судалгаанд хамрагдсан бүлгүүд	15
1.4 Судалгааны асуулга	16
1.5 Судалгааны мэдээлэл цуглуулалт ба мэдээлэл боловсруулалт	16
1.6 Судалгааны явцад тохиолдсон бэрхшээлүүд	16
БҮЛЭГ 2. ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ БА БИГЭР СУМЫН ХҮН АМ ЗҮЙ, ЭДИЙН ЗАСАГ, НИЙГЭМ, ДЭД БҮТЭЦ, АШИГТ МАЛТМАЛ ОЛБОРЛОЛТЫН БАЙДАЛ	
2.1 Говь-алтай аймгийн газар зүй, хүн ам, нийгэм, эдийн засаг, ашигт малтмал олборлолтын байдал	18
2.2 Бигэр сумын газар зүй, хүн ам, нийгэм, эдийн засгийн шинж байдал	19
2.3 Бигэр сумын ашигт малтмалын нөөц, ашигт малтмал олборлолтын байдал	21
БҮЛЭГ 3. ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН БИГЭР СУМАНД ХУВИАРАА АЛТ ОЛБОРЛОГЧДЫН ШИНЖ БАЙДАЛ	
3.1 Хүн ам зүйн шинж байдал, давхар ажил эрхлэлт	22
3.2 Орон нутгийн харьяалал, шилжилт хөдөлгөөн	22
3.3 Өрхийн ахуйн нөхцөл, амьжиргаа	27
БҮЛЭГ 4. ХУВИАРАА АЛТ ОЛБОРЛОГЧДЫН АЖИЛ ЭРХЛЭЛТ, АЖЛЫН НӨХЦӨЛ, ХӨДӨЛМӨР ХАМГААЛАЛ	
4.1 Алт олборлох ажлын түүх	31
4.2 Ажлын ачаалал	33
4.3 Ажлын нөхцөл	37
4.4 Хөдөлмөр хамгаалал	39
БҮЛЭГ 5. ХУВИАРАА АЛТ ОЛБОРЛОГЧДЫН ҮЙЛДВЭРЛЭЛ, ОРЛОГО, ЗАРЛАГА	
5.1 Алт олборлолтын хэмжээ ба орлого	43
5.2 Алт борлуулалт ба алдагдсан боломжийн өртөг	45
5.3 Алт олборлолтын зардал	49
5.4 Алт олборлолтын орлого ба татвар төлөлт	50
5.5 Алт олборлолтын ашиг ба өрхийн амьжиргаанд гарсан өөрчлөлт	52
БҮЛЭГ 6. ХУВИАРАА АЛТ ОЛБОРЛОГЧДЫН ЭРҮҮЛ МЭНД, ЭРҮҮЛ МЭНДИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХҮРТЭЭМЖ	
6.1 Хувиараа алт олборлогчдын алт олборлож эхэлснээс хойшхи эрүүл мэндийн байдал	56
6.2 Хувиараа алт олборлогчдын осол гэмтэлд өртсөн байдал	57

6.3	Эрүүл мэндийн үйлчилгээнд хамрагдалт ба хамрагдах боломж	58
БҮЛЭГ 7. ХУВИАРАА АЛТ ОЛБОРЛОГЧДЫН НИЙГМИЙН ДААТГАЛД ХАМРАГДАЛТ, НИЙГМИЙН ХАЛАМЖИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХҮРТЭЭМЖ		
7.1	Хувиараа алт олборлогчдын нийгмийн даатгалд хамрагдалтын байдал	62
7.2	Хувиараа алт олборлогчдын нийгмийн даатгал, нийгмийн халамжийн үйлчилгээний эрэлт хэрэгцээ	63
БҮЛЭГ 8. ХУВИАРАА АЛТ ОЛБОРЛОГЧДЫН ХӨДӨЛМӨРИЙН ОРЧИН		
8.1	Хувиараа алт олборлож буй газар дахь үйлчилгээнүүд	65
8.2	Хувиараа алт олборлож буй газар дахь гэмт хэрэг, зөрчлийн байдал	68
8.3	Хувиараа алт олборлогчид ба бусад талуудын хоорондын маргаан, зөрчилдөөн	69
БҮЛЭГ 9. ХУВИАРАА АЛТ ОЛБОРЛОГЧДЫН ЗОХИОН БАЙГУУЛАЛТ, ХАМТЫН АЖИЛЛАГАА		
9.1	Хувиараа алт олборлогчдын ажлын зохион байгуулалт	72
9.2	Хувиараа алт олборлогчдын эрх ашгийн хамгаалалт	74
9.3	Хувиараа ашигт малтмал олборлогч иргэдийн үйл ажиллагааг зохицуулах түр журмын талаарх мэдээлэл авсан байдал	74
БҮЛЭГ 10. ХУВИАРАА АЛТ ОЛБОРЛОГЧДЫН ЦААШДЫН ХАНДЛАГА		
10.1	Ирээдүйн ажил эрхлэлт	76
10.2	Хувиараа алт олборлогчдын нөхцөл, байдлыг сайжруулах талаарх үзэл бодол	77
БҮЛЭГ 11. ХУВИАРАА АЛТ ОЛБОРЛОЛТ БА НУТГИЙН ЗАХИРГААНЫ ОРОЛЦОО		80
БҮЛЭГ 12. ДҮГНЭЛТ, ЗӨВЛӨМЖ		84
АШИГЛАСАН МАТЕРИАЛ		90
ХАВСРАЛТ		
	Хавсралт-1: Хүснэгтүүд	91
	Хавсралт-2: Судалгааны баг	96

Хүснэгтийн жагсаалт

		хуудас
Хүснэгт 2.1	Говь-Алтай аймаг ба Бигэр сумын хүн амын хөдөлмөр эрхлэлтийн үзүүлэлтүүд	18
Хүснэгт 2.2	Бигэр сумын эмнэлэгт бүртгэгдсэн өвчлөлийн тоо	20
Хүснэгт 3.1	Судалгаанд хамрагдсан ХАМО нарын хувийн жин, хүн ам зүйн шинж байдлаар	23
Хүснэгт 3.2	Судалгаанд хамрагдагчдын хувийн жин, шилжилтийн байдал, хүйсээр	24
Хүснэгт 3.3	Бигэр суманд алт олборлож байгаа явуулын ХАМО нарын хувь, шилжих хөдөлгөөнөө бүртгүүлэх ач холбогдлын талаарх ойлголт, хүйсээр	26
Хүснэгт 3.4	Судалгаанд хамрагдагчдын хувийн жин, өрхийн ахуйн нөхцлийн үзүүлэлтүүд, хүйсээр	27
Хүснэгт 3.5	Судалгаанд хамрагдагчдын хувийн жин, өрхийн амьжиргааны үзүүлэлтүүдээр	29
Хүснэгт 4.1	Судалгаанд хамрагдагчдын хувийн жин, хувиараа алт олборлосон хугацаа, хариулагчийн шинж байдлаар	31
Хүснэгт 4.2	Судалгаанд хамрагдагчдын хувийн жин, алт олборлох ажлын ачаалал, хүйсээр	34
Хүснэгт 4.3	Тухайн улиралд ажилладаг судалгаанд хамрагдагчдын хувиараа алт олборлодог дундаж хоног, улирал ба алт олборлогчийн шинж байдлаар	35
Хүснэгт 4.4	Судалгаанд хамрагдагчдын хувь, алт олборлохдоо голдуу хийдэг ажил, хүйсээр	36
Хүснэгт 4.5	Судалгаанд хамрагдагчдын хувь, алт олборлох ажлын хүнд бэрхшээлтэй нөхцлүүдийг нэрлэсэн байдал, хүйсээр	37
Хүснэгт 4.6	Судалгаанд хамрагдагчдын хувь, түгээмэл хэрэглэдэг хөдөлмөрийн багаж, хэрэгслийг нэрлэсэн байдал, өрхийн амьжиргааны түвшнээр	38
Хүснэгт 4.7	Судалгаанд хамрагдагчдын хувийн жин, үйлдвэрлэлийн аюулгүй ажиллагааны арга барил эзэмшүүлэх сургалтад хамрагдаж байсан эсэх, хариулагчийн шинж байдлаар	39
Хүснэгт 4.8	Судалгаанд хамрагдагчдын хувь, хэрэглэдэг хөдөлмөр хамгааллын хувцас хэрэгслийг нэрлэсэн байдал, өрхийн амьжиргааны түвшингээр	40
Хүснэгт 4.9	Судалгаанд хамрагдагчдын хувь, хөдөлмөр хамгааллын хувцас хэрэгсэл олох, ашиглахтай холбоотой хүндрэлийг нэрлэсэн байдал, өрхийн амьжиргааны түвшингээр	41
Хүснэгт 5.1	Судалгаанд хамрагдагчдын хувийн жин, ажлын ердийн хоногт олборлодог алтны хэмжээ, хариулагчийн шинж байдлаар	43
Хүснэгт 5.2	Судалгаанд хамрагдагчдын олборлодог алтны дундаж хэмжээ ба алт олборлолтын дундаж орлого, улирал, жилээр	44
Хүснэгт 5.3	Судалгаанд хамрагдагчдын хувийн жин, алтаа борлуулдаг эх үүсвэр, сонгосон үзүүлэлтүүдээр	46
Хүснэгт 5.4	Судалгаанд хамрагдсан ХАМО нарын алдагдсан боломжийн өртөг, улирлаар	47
Хүснэгт 5.5	Судалгаанд хамрагдагчдын хувийн жин, алт борлуулах тохиромжтой аргын талаарх үзэл бодол, сонгосон үзүүлэлтүүдээр	48
Хүснэгт 5.6	Судалгаанд хамрагдагчдын алт олборлолтын дундаж зардал, улирал, жилээр	49
Хүснэгт 5.7	Судалгаанд хамрагдагчдын алт олборлолтоос олдог ашиг, улирлаар	52
Хүснэгт 5.8	Судалгаанд хамрагдагчдын хувийн жин, алт олборлолтоос олсон орлогоо зарцуулдаг байдал, хариулагчийн шинж байдлаар	53

Хүснэгт 5.9	Судалгаанд хамрагдагчдын хувийн жин, алт олборлож эхэлснээс хойш өрхийн амьжиргаанд гарсан өөрчлөлтөө дүгнэсэн байдал, хариулагчдын шинж байдлаар	54
Хүснэгт 6.1	Судалгаанд хамрагдагчдын хувийн жин, хувиараа алт олборлож эхэлснээс хойш эрүүл мэндийн зовиур илэрсэн эсэх, хариулагчийн шинж байдлаар	56
Хүснэгт 6.2	Алт олборлож эхэлснээс хойш эрүүл мэндийн зовиур илэрсэн хариулагчдын хувь, илэрсэн зовиур, өвчнөө нэрлэсэн байдал, хүйсээр	57
Хүснэгт 6.3	Судалгаанд хамрагдагчдын хувийн жин, хувиараа алт олборлох үедээ осол гэмтэлд өртөж байсан эсэх, сонгосон үзүүлэлтүүдээр	57
Хүснэгт 6.4	Судалгаанд хамрагдагчдын хувийн жин, эрүүл мэндийн тусламж авахад бэрхшээл тулгардаг эсэх, хариулагчийн шинж байдлаар	60
Хүснэгт 6.5	Судалгаанд хамрагдагчдын хувийн жин, эрүүл мэндийн даатгалд хамрагдсан эсэх, сонгосон үзүүлэлтүүдээр	61
Хүснэгт 7.1	Нийгмийн даатгалд хамрагдаагүй алт олборлогчдын хувийн жин, нийгмийн даатгалын шимтгэл төлдөггүй шалтгаанаа нэрлэсэн байдал, хариулагчийн шинж байдлаар	63
Хүснэгт 8.1	Судалгаанд хамрагдагчдын хувийн жин, алт олборлож буй газар дахь гэмт хэрэг, зөрчлийн талаар мэдээлсэн байдал, жилд алт олборлодог хоногоор	68
Хүснэгт 8.2	Судалгаанд хамрагдагчдын хувийн жин, алт олборлогчид болон бусад талуудын хоорондох маргаан зөрчилдөөнийг мэдээлсэн байдал, жилд алт олборлодог хоногоор	69
Хүснэгт 9.1	Судалгаанд хамрагдагчдын хувийн жин, ХАМО үйл ажиллагааг зохицуулах ЗГ-ын түр журамын талаар сонссон эсэх, хариулагчийн шинж байдлаар	74
Хүснэгт 10.1	Судалгаанд хамрагдагчдын хувийн жин, цаашид алт олборлохоо үргэлжлүүлэн хийх эсэх, хариулагчийн шинж байдлаар	76
Хүснэгт 10.2	Цаашид алт олборлохоо үргэлжлүүлэх бодолгүй хариулагчдын хувийн жин, ажиллахгүй шалтгаанаа мэдээлсэн байдал, хүйсээр	77

Зургийн жагсаалт

		хуудас
Зураг 3.1	Бигэр суманд хувиараа алт олборлогчдын тоо, нас, хүйсийн бүтцээр	22
Зураг 3.2	Бигэр суманд алт олборлож буй явуулын ХАМО нарын хувийн жин, хаанаас ирсэн эсэхээр	25
Зураг 3.3	Бигэр суманд ирсэн явуулын алт олборлогчдын хувийн жин, Бигэрт ирсэн шалтгаан, хүйсээр	25
Зураг 3.4	Судалгаанд хамрагдсан малтай нэг өрхөд ногдох малын дундаж тоо (толгой мал), малын төрлөөр	28
Зураг 3.5	Судалгаанд хамрагдсан нэг өрхийн сарын дундаж орлогын бүтэц, хувиар	30
Зураг 4.1	Судалгаанд хамрагдагчдын хувь, алт олборлох болсон шалтгаанаар	33
Зураг 4.2	Судалгаанд хамрагдагчдын хувийн жин, алт олборлоход хийдэг хамгийн хэцүү ажлаа нэрлэсэн байдал, хүйсээр	36
Зураг 4.3	Судалгаанд хамрагдагчдын хувийн жин, алт олборлоход хамгийн хэрэгцээтэй хувцас, хэрэгслээ нэрлэсэн байдал, өрхийн амьжиргааны түвшнээр	41
Зураг 5.1	Хариулагчдын хувь, алт борлуулдаг эх үүсвэрээ сонгосон шалтгаан, шилжилтийн байдлаар	46
Зураг 5.2	Алтнаас олсон орлогоос орлогын албан татвар төлдөггүй хариулагчдын хувийн жин, татвар төлдөггүй шалтгаанаар	51
Зураг 5.3	Алт олборлож эхэлснээс хойш өрхийн амьжиргаа дээшилсэн гэж үзэж буй хариулагчдын хувь, хэрхэн амьжиргаа дээшилснээ нэрлэсэн байдал, өрхийн амьжиргааны түвшнээр	55
Зураг 6.1	Ажилладаг газарт осол гардаг гэж мэдээлсэн хариулагчдын хувь, ослын төрлийг нэрлэсэн байдлаар	58
Зураг 6.2	Судалгаанд хамрагдагчдын хувь, хувиараа алт олборлох үед гардаг ослоудын шалтгааны талаарх үзэл бодлоор	58
Зураг 6.3	Судалгаанд хамрагдагчдын хувийн жин, эрүүл мэндийн хүндрэл гарахад хамгийн түрүүнд ханддаг эх үүсвэр, хүйсээр	59
Зураг 6.4	Судалгаанд хамрагдагчдын хувийн жин, алт олборлож байх үедээ шаардлагатай эм тариагаа хаанаас авдаг эсэх, хүйсээр	59
Зураг 7.1	Нийгмийн даатгал, нийгмийн халамжийн үйлчилгээ хэрэгцээтэй байгаа хариулагчдын хувь, хэрэгцээтэй үйлчилгээг нэрлэсэн байдал, өрхийн амьжиргаагаар	64
Зураг 8.1	Судалгаанд хамрагдагчдын хувь, ажилладаг газарт байдаг үйлчилгээнүүдийг нэрлэсэн байдлаар	65
Зураг 8.2	Судалгаанд хамрагдагчдын хувь, ажилладаг газарт хамгийн хэрэгцээтэй үйлчилгээг нэрлэсэн байдлаар	65
Зураг 8.3	ХАМО болон бусад талуудын хооронд маргаан гардаг гэж хариулагчдын хувь, маргаан зөрчилдөөний асуудлыг нэрлэсэн байдлаар	70
Зураг 9.1	Алт олборлохдоо бусадтай хамтардаг хариулагчдын хувийн жин, ашигаа хэрхэн хуваадгаа мэдээлсэн байдлаар	73
Зураг 9.2	Судалгаанд хамрагдагчдын хувийн жин, бусадтай хамтран ажиллахын давуу талын талаарх үзэл бодлоор	73
Зураг 10.1	Судалгаанд хамрагдагчдын хувийн жин, амьжиргаа дээшлүүлэх боломжийн мөнгөтэй болвол хэрхэн зарцуулах эсэхээр	78

Зураг 10.2 Судалгаанд хамрагдагчдын хувь, ХАМО иргэдийн байдлыг сайжруулахын тулд явуулах шаардлагатай гэж үзэж буй арга хэмжээг нэрлэсэн байдлаар

78

Товчилсон үгсийн тайлбар

АМГ	Ашигт малтмалын газар
АХБ	Азийн Хөгжлийн Банк
БОЯ	Байгаль Орчны Яам
ГХГЗЗГ	Газрын харилцаа, геодези, зураг зүйн газар
ДНБ	Дотоодын нийт бүтээгдэхүүн
ДБ	Дэлхийн банк
ЗДТГ	Засаг Даргын Тамгын Газар
МУИС	Монгол Улсын Их Сургууль
МХГ	Мэргэжлийн хяналтын газар
НХХЯ	Нийгмийн Хамгаалал, Хөдөлмөрийн яам
НҮБ	Нэгдсэн Үндэстний Байгууллага
ОБЕГ	Онцгой Байдлын Ерөнхий Газар
ХАМО	Хувиараа ашигт малтмал олборлогч
ХАОАТ	Хүн амын орлогын албан татвар
ҮСГ	Үндэсний статистикийн газар
ТоБУТ	Тогтвортой бичил уурхай төсөл
ТББ	Төрийн бус байгууллага
УИХ	Улсын их хурал
ЭБЭХЯ	Эрдэс Баялаг, Эрчим Хүчний Яам
ЭМД	Эрүүл мэндийн даатгал

Нэр, томъёоны тайлбар

<i>Ажиллах хүчний хөдөлмөр оролцооны түвшин</i>	Хөдөлмөрийн насны нийт хүн амын дунд ажил эрхэлж байгаа болон ажил идэвхтэй эрж, хайж байгаа хүн амын эзлэх хувь
<i>Алдагдсан боломж</i>	ХАМО нар олборлосон алтаа ченжүүдэд биш, банкинд борлуулах байсан боломжит хувилбар
<i>Алдагдсан боломжийн өртөг</i>	ХАМО нар олборлосон алтаа банкинд борлуулснаар олох боломжтой байсан орлого
<i>Алт борлуулах албан зах зээлийн үйл ажиллагаа</i>	Банкинд алт худалдаалах, худалдан авах үйл ажиллагаа
<i>Алт борлуулах албан бус зах зээлийн үйл ажиллагаа</i>	Хувь ченжүүдэд алт худалдаалах, худалдан авах үйл ажиллагаа

<i>Суурин алт олборлогч иргэн</i>	Говь-Алтай аймгийн Бигэр суманд 1 жилээс дээш хугацаагаар амьдран, хувиараа алт олборлож байгаа хүн
<i>Уул уурхайн том компани</i>	Хуулийн дагуу ашигт малтмалын хайгуулын болон ашиглалтын лицензтэй, ус, нөөц, газрын төлбөрөө зохих журмын дагуу төлж, уул уурхайн үйл ажиллагаа эрхэлдэг том компаниуд
<i>Харуул хамгаалалтын алба</i>	Лицензтэй талбайг хамгаалж байгаа харуул хамгаалалтын газар
<i>Явуулын алт олборлогч иргэн</i>	Монгол улсын өөр аймаг, хот, сумаас Бигэр суманд сүүлийн 1 жил хүртэлх хугацаанд ирж, буцан алт олборлож байгаа хүн
<i>Ядуу өрх</i>	Өрхийн нэг хүнд ногдох сарын орлого нь 2009 оны Баруун бүсийн 1 хүнд сард ногдох амьжиргааны доод түвшингийн үзүүлэлт болох 96100 төгрөг (ядуурлын шугам)-өөс доош байгаа өрх
<i>Нэн ядуу өрх</i>	Өрхийн нэг хүнд ногдох сарын орлого нь ядуурлын шугамын 60 хувьд хүрэхгүй байгаа өрх

НЭГДСЭН ДҮГНЭЛТ

Монгол улсын Ашигт малтмал, газрын тосны хэрэг эрхлэх газар Швейцарийн хөгжлийн агентлагтай хамтран Монгол улсад 2005 оноос хэрэгжүүлж эхэлсэн “Тогтвортой бичил уурхай” төсөл (ТоБУТ) нь *Монгол Улсад хариуцлагатай бичил уурхайг хөгжүүлэхэд холбогдох талуудтай хамтран ажиллаж, бичил уурхай эрхлэгчдийг хөдөөгийн тогтвортой хөгжилд оролцдог эдийн засгийн дэд салбарын хариуцлагатай гишүүд болоход хувь нэмэр оруулах* гол зорилготой төсөл юм. Уг төслийн хүрээнд гүйцэтгэсэн энэхүү судалгаагаар судалгааны багийнхан Говь-Алтай аймгийн Бигэр сумын нийгэм эдийн засгийн байдал, тэр дундаа тухайн нутагт хувиараа ашигт малтмал (алт) олборлож буй иргэдийн нийгэм, эдийн засгийн шинж байдал, явуулж буй үйл ажиллагаа, эдийн засагт оруулж буй хувь нэмрийг тодорхойлохыг зорьсон. Судалгааны хүрээнд сэдэвтэй холбогдох бодлогын баримт бичиг, урьд хийгдсэн судалгаануудыг уншиж танилцан, тоон болон чанарын судалгааны аргуудаар мэдээлэл цуглуулж судлан Тогтвортой Бичил Уурхай Төслийн зорилго, зорилтуудын хэрэгжилтийг үнэлэхэд хэрэг болохуйц дараах гол үр дүнгүүдийг гаргалаа.

Хүснэгт 1. Бигэр сумын нийгэм эдийн засгийн суурь нөхцлүүд

Үзүүлэлт	Хувь	Эх үүсвэр
Сумын нийт өрхийн дунд ядуу өрхийн эзлэх хувь	31.4%	Сумын багийн дарга нарын 2009 оны хүн ам зүйн судалгаа
Сумын нийт хүн амын дунд ядуу хүн амын эзлэх хувь	34%	Сумын багийн дарга нарын 2009 оны хүн ам зүйн судалгаа
Судалгаанд хамрагдсан ХАМО иргэдтэй өрхийн дунд ядуу өрхийн эзлэх хувь	60%	Судалгаанд хамрагдсан ХАМО нарын асуулгын үр дүн
Судалгаанд хамрагдсан ХАМО иргэдтэй өрхүүдэд байгаа нийт хүн амын дунд ядуу хүн амын эзлэх хувь	68%	Судалгаанд хамрагдсан ХАМО нарын асуулгын үр дүн
Ажиллах хүчний хөдөлмөр оролцооны түвшин	78%	Говь-Алтай аймгийн эдийн засаг, нийгмийн байдлын 2009 оны жилийн эцсийн мэдээлэл
Хувиараа алт олборлогч иргэдийн алт олборлох үйл ажиллагаатай холбоотой осол, гэмтэлд өртөж байсан байдал	13.7%	Судалгаанд хамрагдсан ХАМО нарын асуулгын үр дүн

ТоБУТ-ийн хүлээгдэж буй үр дүн 1: Бичил уурхайн салбарт ил тод, шударга бодлого эрх зүй, зохицуулалтын орчин бүрдүүлж, хэрэгжилтийг эхлүүлсэн байна

Хүснэгт 2. Хүлээгдэж буй үр дүн 1

Үзүүлэлт	Хувь	Эх үүсвэр
Хууль эрх зүйн зохицуулалт (МУ-ын Засгийн газрын 2008 оны 72-р тогтоолоор батлагдсан “Хувиараа ашигт малтмал олборлох үйл ажиллагааг зохицуулах түр журам”)-ын дагуу албан ёсны зөвшөөрөлтэй газар алт олборлолт хийж байгаа хувиараа алт олборлогч иргэдийн хувь	0%	Аймгийн ЗДТГ-ын Хөгжлийн Бодлогын Хэлтсийн мэдээлэл (Хавсралт хүснэгт 1)
Нийгмийн даатгалд хамрагдсан хувиараа алт олборлогч иргэдийн хувь	1%	Судалгаанд хамрагдсан ХАМО нарын асуулгын үр дүн
Эрүүл мэндийн даатгалд хамрагдан, сүүлийн 1 жилийн хураамжаа төлсөн хувиараа алт олборлогч иргэдийн хувь	54.3%	Судалгаанд хамрагдсан ХАМО нарын асуулгын үр дүн
ХАОАТ төлдөг хувиараа алт олборлогч иргэдийн хувь	0%	Судалгаанд хамрагдсан ХАМО нарын асуулгын үр дүн

ТоБУТ-ийн хүлээгдэж буй үр дүн 2: Бүхий л түвшинд бичил уурхайн салбарын бүтцийг бий болгож, зохион байгуулалтыг боловсронгуй болгож бэхжүүлсэн байна.

Хүснэгт 3. Хүлээгдэж буй үр дүн 2

Үзүүлэлт	Хувь	Эх үүсвэр
Хувиараа ашигт малтмал олборлогч иргэдийн үйл ажиллагааг зохицуулах Түр журам (МУ-ын ЗГ-ын 2008 оны 72-р тогтоол)-ын дагуу зохион байгуулалтад орж ажиллаж байгаа хувиараа алт олборлогч иргэдийн хувь	0%	Судалгаанд хамрагдсан ХАМО нарын асуулгын үр дүн (Сумын ЗДТГ-ын н мэдээллээр, хувиараа алт олборлогчдыг албан ёсны буюу бүртгэгдээгүй нөхөрлөлийн зохион байгуулалтад оруулах бэлтгэл ажил, тухайлбал нөхөрлөл байгуулах тухай хурлын тэмдэглэл, нөхөрлөлд орох гишүүдийн жагсаалтыг гаргах гэх мэт, хийгдэж байгаа)

ТоБУТ-ийн хүлээгдэж буй үр дүн 3: Бичил уурхай эрхлэгчдийг үр ашигтай хариуцлагатай бичил уурхай болон бусад бизнесийн үйл ажиллагааг эрхлэх чадвартай болоход нь туслах

Хүснэгт 4. Хүлээгдэж буй үр дүн 3

Үзүүлэлт	Хоногт		Сард		Жилд (2009 оны 2-р сараас 2010 оны 2-р сарын хооронд алт олборлосон нийт хоногт)
	Ажлын нэг хоногт	Жилийн ердийн нэг хоногт	Ажлын нэг сард	Жилийн ердийн нэг сард	
Нэг алт олборлогчийн хувиараа алт олборлосон дундаж хоног	-	-	-	-	61.5 хоног
Нэг алт олборлогчийн олборлосон алтны дундаж хэмжээ (грамм)	1.19	0.2	19.35	6.15	73.77
Нэг алт олборлогчийн алт олборлолтын орлогын дундаж хэмжээ (төгрөг)	47,009.7	8,102.5	770,982.3	246,452.5	2,957,430.1
Нэг алт олборлогчийн алт олборлолтын урсгал зардлын дундаж хэмжээ (төгрөг)	10,626.1	1,686.5	172,007.2	51,295.1	615,541.3
Нэг алт олборлогчийн алт олборлолтын капитал зардлын дундаж хэмжээ (төгрөг)	5,179.9	371.5	59,182.7	11,302.4	135,628.3
Нэг алт олборлогчийн алт олборлолтын нийт зардлын дундаж хэмжээ (төгрөг)	15,806.0	2,058.0	231,189.9	62,597.5	751,169.6
Нэг алт олборлогчийн алт олборлолтоос олдог ашгийн дундаж хэмжээ (төгрөг)	31,315.9	6,062.3	540,671.5	184,395.0	2,212,740.0

Эх үүсвэр: Судалгаанд хамрагдсан ХАМО нарын асуулгын үр дүн

ТоБУТ-ийн хүлээгдэж буй үр дүн 4: Бичил уурхай эрхлэгчид ба бусад нөөц ашиглагчдыг байгаль экологи, нийгмийн асуудалд хариуцлагатай хандаж, гарч буй зөрчлүүдээ шийдэж чаддаг чадвартай болгох

Хүснэгт 5. Хүлээгдэж буй үр дүн 4

Үзүүлэлт	Хувь	Эх үүсвэр
Хувиараа алт олборлож буй газарт гэмт хэрэг, зөрчил гардаг (байнга, заримдаа, ховор) гэж мэдээлсэн алт олборлогчдын хувь	96.7%	Судалгаанд хамрагдсан ХАМО нарын асуулгын үр дүн (Сумын цагдаагийн хэлтсийн бүртгэлд ХАМО нарын дунд гарч буй гэмт хэргийг тусгайлан бүртгэсэн мэдээлэл байгаагүй)
Хувиараа алт олборлогчид ба бусад талуудын хооронд маргаан, зөрчил гардаг (байнга, заримдаа, ховор) гэж мэдээлсэн алт олборлогчдын хувь	95.0%	Судалгаанд хамрагдсан ХАМО нарын асуулгын үр дүн
Байгаль орчин, хүний биед сөрөг нөлөө бүхий химийн хорт бодис (цианит, мөнгөн ус) хэрэглэн алт боловсруулж байгаа байдал	0%	Судалгаанд хамрагдсан ХАМО нарын асуулгын үр дүн; Говь-Алтай аймгийн ЗДТГ-ын Хөгжлийн Бодлогын хэлтсийн мэдээлэл
Хувиараа алт олборлох үйл ажиллагааны байгаль орчинд үзүүлж буй сөрөг нөлөөлөл	Их ¹	ХАМО нарын үйл ажиллагаанаас үүдэлтэй газрын эвдрэл, ахуйн хог хаягдал, малын бэлчээр, нөхөн сэргээлт, байгаль орчны сүйдэл, гэх мэт) бусад сөрөг үр дагаврууд

¹ Оролцооны аргаар цуглуулсан мэдээллүүдэд их, дунд, бага гэсэн чанарын хэмжигдэхүүнийг ашиглан тодорхойлов.

УДИРТГАЛ

Монгол улсын геологи, уул уурхайн салбар нь аж үйлдвэрийн салбартаа төдийгүй нийт эдийн засагт зонхилох байр суурийг эзэлдэг салбаруудын нэг юм. Тус салбарын Монгол улсын ДНБ-д эзлэх хувь 2002 онд 10.1 хувь байсан бол 2009 онд 28.2 хувь, аж үйлдвэрийн нийт бүтээгдэхүүнд 2002 онд 47.3 хувь байсан бол 2009 онд 65.4 хувь, нийт экспортын бүтээгдэхүүнд 2002 онд 56.7 хувь байснаа 2009 онд 84.6 хувь болж өссөн үзүүлэлттэй байна². Уул уурхайн салбарт харьяалагдах алтны үйлдвэрлэлийн салбар Монгол улсад өнгөрсөн 17 жилийн дотор асар хурдацтай өссөн бөгөөд бараг 30 дахин нэмэгдсэн. 1990-ээд оны дунд үеэс хэрэгжиж эхэлсэн “Алт” хөтөлбөр энэхүү үсрэнгүй хөгжилд жинтэй хувь нэмэр оруулснаас гадна гадаадын хөрөнгө оруулалтын дүнд 2008 онд алт үйлдвэрлэлийн хэмжээ 15.2 тоннд хүрсэн байна³.

Сүүлийн жилүүдэд улс орныг бүхэлд нь хамарсан ган, зуд, байгалийн гамшиг Монгол улсад олноор тохиолдож, олон мянган малчин өрх амьжиргааны эх үүсвэр болсон малнаасаа салж, газар тариалангийн үйлдвэрлэлд хүндрэл учирсны улмаас ядуу иргэдийн тоо огцом өсч, тэдгээр иргэд амьжиргаагаа залгуулахын тулд хөдөлмөр эрхлэлтийн “шинэ” хэлбэр болох хувиараа алт олборлох үйл ажиллагааг эрхлэх нь нэмэгдэх болсон. 2003 онд Дэлхийн банкнаас хийсэн судалгаагаар², Монгол улсад 100,000 орчим гар аргаар алт олборлогч иргэд байдаг, тэд жилд дунджаар 100 сая долларын алт зарж борлуулдаг гэсэн тооцоо гарчээ. Харин АМГ-аас гаргасан мэдээллээс³ харахад, 2008 онд манай улсын 18 аймгийн 100 гаруй цэгт 54 мянган хувиараа ашигт малтмал олборлогч иргэд үйл ажиллагаа явуулж байгаагаас 90 хувь нь алтны үндсэн ба шороон ордод ажиллаж байгаа ба 2009 онд хувиараа алт олборлогч иргэдийн тоо 34570 байна гэсэн тооцоо гарсан байна.

Дээрх тоо мэдээллээс харахад, 2003 оноос хойшхи 6 жилд хувиараа алт олборлогч иргэдийн тоо буурсан мэт харагдаж байгаа боловч энэ нь олон хүнд итгэл үнэмшил төрүүлэхүйц тоо байж чадахгүй байна. Учир нь Монголын, ялангуяа хөдөөгийн хүн амын өнөөгийн амьдралаас харахад хувиараа алт олборлолтын гол шалтгаан болж буй ядуурал дээрх хугацаанд багасаагүй, харин ч нэмэгдсэн⁴ ба хувиараа ашигт малтмал олборлогч иргэдийн тооны талаарх мэдээлэл эх үүсвэрүүдээр хэт зөрүүтэй, тэдний бодит тоо, нөхцөл байдлыг судалсан сүүлийн үеийн судалгаанууд ч хомс байна. Монгол дахь хувиараа ашигт малтмал олборлогч иргэдийн дотор дийлэнх хувийг эзэлж байгаа алт олборлогчдын үйл ажиллагаатай шууд болон шууд бусаар холбоотой, эерэг, сөрөг олон үр дагаврууд манай нийгэм, экологид тулгарч байгаа ба түүнийг нарийвчлан судалж, зохих арга хэмжээг авснаар хувиараа алт олборлогчдын нийгэм, эдийн засгийн хөгжилд оруулах хувь нэмрийг нэмэгдүүлэх боломжтой юм.

Эдгээр нөхцлийг харгалзан, Швейцарийн Хөгжлийн Агентлаг, МУ-ын Засгийн газартай хамтран хэрэгжүүлж буй ТоБУТ-ийн саналаар бид энэхүү судалгаанд МУ дахь хувиараа алт олборлогчдын төлөөлөл болсон Говь-Алтай аймгийн Бигэр суманд хувиараа алт олборлож буй иргэдийг хамруулан тэдний нөхцөл байдал, нийгэм, эдийн засагт оруулж буй хувь нэмрийг тодорхойлохыг зорьлоо.

²“Монгол орны геологи ба ашигт малтмал 2010” Монголын Үйлдвэрлэлийн Геологчдын холбоо

³ АМ-Уул уурхайн салбарын үйл ажиллагааны тайлан 2008 он, 2009 он

⁴ УСГ-ын мэдээллээр, 2006 онд хөдөөгийн ядуурлын хамралт 37 хувь, ядуурлын гүнзгийрэлт 11.9 байсан бол 2008 онд ядуурлын хамралт 46.6 хувь, гүнзгийрэлт 13.4 болж нэмэгджээ.

БҮЛЭГ 1. СУДАЛГААНЫ ЗОРИЛГО, ЗОРИЛТ, ЗАГВАР

1.1 Судалгааны зорилго, зорилтууд

Энэхүү судалгааны гол зорилго нь Говь-Алтай аймгийн Бигэр сумын нийгэм, эдийн засгийн нөхцөл байдлыг тодорхойлох, тэр дундаа тус суманд хувиараа алт олборлож буй иргэдийн нийгэм, эдийн засгийн нөхцөл байдал, явуулж буй үйл ажиллагаа, орон нутгийн эдийн засгийн хөгжилд оруулж буй хувь нэмэр болон үйл ажиллагаатай нь холбогдон гарч буй асуудлуудыг тодорхойлох явдал байв.

Судалгааны зорилтууд нь:

1. Хувиараа алт олборлогч иргэдийн хүн ам зүй, нийгэм, эдийн засгийн шинж байдлыг тодорхойлох
2. Хувиараа алт олборлогч иргэдийн алт олборлолт, ажлын нөхцөл, хөдөлмөр хамгааллын байдлыг тодорхойлох
3. Хувиараа алт олборлож буй иргэдийн алт олборлолтын хэмжээ, алт борлуулалтын зах зээл, орлого ба зарлагыг судалснаар тэдний орон нутгийн нийгэм, эдийн засгийн хөгжилд оруулж буй хувь нэмрийг тодорхойлох
4. Хувиараа алт олборлогч иргэдийн эрүүл мэндийн байдал, нийгмийн хамгаалалд хамрагдалтад дүн шинжилгээ хийх
5. Хувиараа алт олборлогч иргэдийн хөдөлмөрийн орчин, ажлын зохион байгуулалт, хамтын ажиллагаа, цаашдын ажил эрхлэлтийн хандлагыг судлах
6. Хувиараа алт олборлогч иргэдийн байгаль орчин, нийгэм, эдийн засагт үзүүлж буй нөлөөллийн талаархи олон нийтийн ойлголт хандлагыг тодорхойлох зэрэг байв.

1.2 Судалгааны арга

Судалгааг ТоБУТөслийн саналаар Хөгжлийн Эзэд ТББ-ын судлаач нараас бүрдсэн судалгааны баг тоон болон чанарын судалгаа, хоёрдогч мэдээллийн эх үүсвэрийг шинжлэх зэрэг аргуудыг хослуулан гүйцэтгэсэн.

Тоон судалгаагаар нийт 9 бүлэг бүхий урьдчилан кодлосон асуултуудтай асуулгын хуудас боловсруулж хувиараа алт олборлогчдоос асуусан ба чанарын судалгаагаар гүнзгийрүүлсэн ярилцлага, кейс судлал, ажиглалт, орон нутагтай танилцах аялал зэрэг аргуудыг ашигласан.

1.3 Судалгааны түүвэрлэлт ба чанарын судалгаанд хамрагдсан бүлгүүд

Тоон судалгаанд Бигэр сумын Гангат, Улаан чулуут, Дөрөлж, Агуйт, Олон булаг, Олстой, Хойт Зост гэх мэт газруудад хувиараа алт олборлож буй 300 ХАМО иргэдийг энгийн санамсаргүй түүврийн аргаар түүвэрлэн хамруулсан ба энэ нь эх олонлогийг 95 хувийн үнэний магадлал, 5 хувийн алдааны магадлалтайгаар төлөөлж чадахуйц түүврийн хэмжээ байсан. Чанарын судалгаанд дараах бүлэг, хүмүүсийг хамруулав. Үүнд:

- ХАМО
- Аймгийн байгаль орчны улсын байцаагч
- Аймгийн онцгой байдлын газар

- Аймгийн цагдаагийн хэлтэс
- Сумын Засаг даргын тамгын газар
- Нийгмийн халамж үйлчилгээний байгууллага
- Сумын хүн эмнэлэг
- Сумын цагдаагийн хэлтсийн албан хаагчид
- Байгаль орчны байцаагч
- Газрын даамал
- Мэргэжлийн хяналтын байцаагч
- Монгол шуудан банк, ХААН банк
- Хувиараа алт олборлогч иргэд
- Малчид
- Худалдаа, үйлчилгээний газрууд

1.4 Судалгааны асуулга

Тоон судалгааны асуулга дараах бүтэцтэй байв:

- Хариулагчийн шинж байдал (Бүлэг 1)
- Орон нутгийн харъяалал, шилжилт хөдөлгөөн (Бүлэг 2)
- Өрхийн ахуйн нөхцөл, амьжиргаа (Бүлэг 3)
- Алт олборлолт, ажлын нөхцөл, хөдөлмөр хамгаалал (Бүлэг 4)
- Хувиараа алт олборлогч иргэдийн үйлдвэрлэл, орлого, зарлага (Бүлэг 5)
- Хувиараа алт олборлогч иргэдийн эрүүл мэндийн байдал ба эрүүл мэндийн үйлчилгээ (Бүлэг 6)
- Нийгмийн даатгалд хамрагдалт ба нийгмийн халамж үйлчилгээ (Бүлэг 7)
- Хувиараа алт олборлогч иргэдийн хөдөлмөрийн орчин (Бүлэг 8)
- Хувиараа алт олборлогч иргэдийн зохион байгуулалт ба цаашдын хандлага (Бүлэг 9)

1.5 Судалгааны мэдээлэл цуглуулалт ба мэдээлэл боловсруулалт

Тоон судалгааны мэдээллээр мэдээллийн бааз үүсгэн, мэдээлэл боловсруулж, үр дүнгийн шинжилгээ хийхэд SPSS–11 программ хангамжийг ашиглав. Чанарын судалгааны мэдээлэл боловсруулалтад үр дүнгийн агуулгын дагуу мэдээллийг бүлэглэн матриц үүсгэх аргыг хэрэглэж дүгнэлт хийв.

1.6 Судалгааны явцад тохиолдсон бэрхшээлүүд

- Хоёрдогч мэдээлэл өгөгч байгууллагууд нь хувиараа алт олборлогчдын нийт тооны талаар хоорондоо зөрүүтэй мэдээлэл өгч байсан нь мэдээлэл боловсруулах, баталгаажуулах, дүгнэлт хийх явцад хүндрэлтэй байлаа
- Бигэр суманд хувиараа алт олборлогчид нь албан ёсны газрын зөвшөөрөлгүй, “Маркополо” компаний хайгуулын лицензтэй талбайд алт олборлож байгаа бөгөөд тухайн газрыг хамгаалж байгаа харуул хамгаалалтын албаны ажилчидтай байнга зөрчил тэмцэлтэй байдгаас ХАМО нар хамгаалалтын ажилчдаас айх, зугтах, сандрах зэрэг хүчин зүйлүүдээс шалтгаалж судалгаа авахад хүндрэл гарч байлаа.

- Судалгаа авч байх явцад зарим нэг оролцогч нар харуул хамгаалалтын албанаас хэдэн өдөр сунгаж алт олборлох зөвшөөрөл авч өгөхийг шаардаж мэдээлэл өгөхөөс татгалзах зэрэг хандлага гаргаж байснаас хүйтэн өвлийн улиралд тэднийг хүлээж зогсох, өөрсдийн зорилгоо зөв тайлбарлаж ойлгуулахад цаг их орж байв.
- Хувиараа алт олборлогч иргэдийн дунд өрхийн орлого зарлагаа урьд нь тооцож үзээгүйн улмаас орлого зарлагаа тодорхойлоход нилээд цаг хугацаа зарцуулж байсан.
- Улаанбаатар хотоос Говь-Алтай аймгийн Бигэр сум руу явах замд цаг агаарын хүндрэлтэй байдал үүсч зам даваа хаагдаж, машин цасанд суух зэрэг бэрхшээлүүд гарч байлаа

БҮЛЭГ 2. ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ БОЛОН БИГЭР СУМЫН ХҮН АМ ЗҮЙ, ЭДИЙН ЗАСАГ, НИЙГЭМ, ДЭД БҮТЭЦ, АШИГТ МАЛТМАЛ ОЛБОРЛОЛТЫН БАЙДАЛ

2.1 Говь-алтай аймгийн газар зүй, хүн ам, нийгэм, эдийн засаг, ашигт малтмал олборлолтын байдал

Говь-Алтай аймаг нь 141.7 мянган хавтгай дөрвөлжин километр нутгийг эзлэн Монгол улсын баруун өмнөд хэсэгт Улаанбаатар хотоос 1037 км зайд оршдог. Хойд талаараа Завхан аймаг, зүүн талаараа Баянхонгор аймаг, өмнө талаараа БНХАУ, баруун талаараа Ховд аймагтай хиллэж, нутаг дэвсгэрийн хэмжээгээрээ улсад 2 дугаар байранд орж, Монгол улсын газар нутгийн 10 хувийг эзэлж байна.

2009 оны байдлаар Говь-Алтай аймгийн 15540 мянган өрхөд 55426 хүн амьдарч байгаагийн 49.2 хувь буюу 27.3 мянга нь эрэгтэйчүүд, 50.8 хувь буюу 28.1 мянга нь эмэгтэйчүүд байна. Нийт хүн амын 56 хувь нь хөдөөд, 28.0 хувь нь аймгийн төвд, 14.0 хувь нь сумын төвд, 2.0 хувь нь тосгонд амьдарч байна (ИТХ 2009, Статистикийн хэлтэс 2010).

Аймгийн дүнгээр бүтэн өнчин 136, хагас өнчин 1.2 мянган хүүхэд, хүүхэдтэй гэр бүлгүй хүн 1.2 мянга, ганц бие өндөр настай өрх 0.9 мянга, өрх толгойлсон хүн 2.7 мянга хөгжлийн бэрхшээлтэй 1.6 мянган хүн байна.

Ерөнхий боловсролын 28 сургууль, 28 цэцэрлэгт 12.7 мянган суралцагсад байгаагийн 3.7 мянган хүүхэд нь цэцэрлэгт хүмүүжиж байна. Мөн анагаах ухааны коллеж, мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвүүд үйл ажиллагаагаа явуулж байна.

Говь-Алтай аймгийн хэмжээнд 2009 оны байдлаар 33.9 мянган хөдөлмөрийн насны хүн ам байгаагийн 74 хувь буюу 25.1 мянга нь хөдөлмөрийн чадвартай ажиллах хүч буюу эдийн засгийн хувьд идэвхтэй хүн ам байна (Хүснэгт 2.1). Ажиллах хүчний дийлэнх (96 хувь) нь ямар нэгэн ажил эрхэлж байгаа ажиллагсад байхад, үлдсэн 4.0 хувь нь хөдөлмөр эрхлэлтийн албанд бүртгэлтэй ажилгүйчүүд байна. Хэдийгээр ажил эрхлэлтийн албан ёсны үзүүлэлт тус аймагт өндөр гарсан ч ажил эрхэлж байгаа хүн амын тоог хөдөлмөрийн насны хүн амд харьцуулж харахад хөдөлмөрийн зах зээл дэх хүний нөөцийн потенциалын ашиглалт тус аймагт тийм ч өндөр биш байна.

Хүснэгт 2.1. Говь-Алтай аймаг ба Бигэр сумын хүн амын хөдөлмөр эрхлэлтийн үзүүлэлтүүд, 2009 он⁵

Үзүүлэлт	Аймаг	Бигэр сум
Хөдөлмөрийн насны хүн ам	33856	1306
Ажиллах хүч	25057	1072
Үүнээс: Ажиллагсад	24061	1052
Бүртгэлтэй ажилгүйчүүд	996	20
Ажиллах хүчинд тооцсон ажил эрхлэлтийн түвшин	96.0	99.0
Ажиллах хүчинд тооцсон ажилгүйдлийн түвшин	4.0	1.0

Эх үүсвэр: Засаг даргын дэргэдэх Статистикийн хэлтэс 2010. Говь-Алтай аймгийн эдийн засаг, нийгмийн байдлын 2009 оны жилийн эцсийн мэдээлэл, Алтай хот

⁵ Говь-Алтай аймгийн статистик мэдээлэл 2010 он

2005 онд Говь-Алтай аймгийн нийт төсөв 8.1 тэрбум төгрөг байсан бол 2006 онд 10.2 тэрбум, 2007 онд 14.1 тэрбум, 2008 онд 20.5 тэрбум төгрөг болж өмнөх оноос 45 хувиар өссөн. Сүүлийн жилүүдэд улсын төсвийн орлогын төлөвлөгөөг 101-116.5 хувиар, орон нутгийн төсвийн орлогын төлөвлөгөөг 100.2-135.6 хувиар давуулан биелүүлсэн байна (*Говь-Алтай аймгийн ЗДТГ, 2008*).

МУ-ын Ашигт малтмалын газрын Геологи уул уурхайн кадастрын хэлтсийн мэдээгээр, 2009 оны 2 дугаар сарын 25-ны байдлаар Говь-Алтай аймгийн 18 суманд нийт 3916636,61 га газрыг хамарсан 293 ашигт малтмалын тусгай зөвшөөрөл олгогдсон байна. Үүнээс, 282 нь хайгуулын, 11 нь ашиглалтын лиценз байв. 2010 оны 1 дүгээр сарын байдлаар тус аймгийн ЗДТГ-ын Хөгжлийн Бодлогын Хэлтсийн гаргасан мэдээ (Хавсралт Хүснэгт 1)-ээс үзэхэд аймгийн 11 сумын 22 газрын нийт 615 га талбайд 29047 иргэд хувиараа алт олборлох үйл ажиллагаа явуулж байна. Тус аймагт иргэдийн хувиараа алт олборлох ажиллагаа эрс идэвхжсэн 2009 оны 7-11 сарын хооронд алт олборлогчдын тоо хамгийн их болсон гэсэн тооцоо байгаа ба давхардсан тоогоор 65 мянга гаруй иргэд алт олборлох үйл ажиллагаанд оролцсон байна⁶.

2.2 Бигэр сумын газар зүй, хүн ам, нийгэм, эдийн засгийн шинж байдал

Бигэр сум нь Монгол улсын баруун хязгаар Алтайн нурууны урд хэсэг говийн бүсэд багтдаг, Дэлгэр, Чандмань, Цогт, Халиун сумдын дунд дөрвөн талаараа өндөр уулсаар хүрээлэгдсэн, говь хоолой, бэл тал нуруу, тал хөндий, булаг шанд хосолсон нутаг юм. Нийт 382623 га бүхий нутагтайгаас 351301 га нь бэлчээр, 760 га нь хот тосгоны, 66 га-д тариалангийн талбай, 161 га-д атаршсан талбай, 1771 га-д ой сангийн эзлэх талбай, 935 га-д нуур голын ай сав байна. Нутгийн уулархаг болон говь аль ч хэсэгт жилийн дөрвөн улиралд хур тунадасны хэмжээ бага, цаг агаарын огцом өөрчлөлт багатай, хуурайшилт ихтэй, байнгын салхилдаг, тэнгэр цэлмэг нартай өдрүүд зонхилно.

Сумын төв нь нийслэлээс 1050 км зайд алслагдсан, төвийн эрчим хүчний шугамд холбогдоогүй, жижиг, дунд үйлдвэрлэл сул хөгжсөн, дэд бүтэц, ахуйн үйлчилгээний салбар хөгжөөгүй, барилга, бүтээн байгуулалтад хөрөнгө оруулалт хийгдээгүй (ИТХ, 2009) учир хүмүүсийнх нь амьжиргаа, мэдээлэл авах байдал харьцангуй хязгаарлагдмал байна.

Бигэр суманд нийт 635 өрхийн 2197 хүн ам амьдарч байгаагаас 49.7 хувь нь эрэгтэйчүүд, 52.3 хувь нь эмэгтэйчүүд байна (ИТХ 2009, Статистикийн хэлтэс 2010). Сумын хэмжээнд 3 бүтэн өнчин, 27 хагас өнчин хүүхэд, 119 өрх толгойлсон эмэгтэйчүүд байна.

Бигэр сумын хүн амын хөдөлмөр эрхлэлтийн үзүүлэлтүүдийг авч үзэхэд, 2009 оны байдлаар сумын хүн амын 58 хувь нь хөдөлмөрийн насны хүмүүс байна. Эдгээр хөдөлмөрийн насны хүн амаас 82.1 хувь нь хөдөлмөрийн чадвартай ажиллах хүч байгаа нь аймгийн дундаж (74 хувь)-аас өндөр үзүүлэлт байв (Хүснэгт 2.1). Сумын хэмжээнд ажил хөдөлмөр эрхэлдэг хүмүүс нь мал аж ахуйн салбар, хувийн компани, төрийн байгууллага, төрийн бус байгууллага гэх мэт хэдхэн салбаруудад ажилладаг байна. Эндээс харахад хүмүүсийн ажил эрхлэлтийн салбар Бигэр суманд харьцангуй хязгаарлагдмал байна.

⁶ Говь-Алтай аймгийн ЗДТГ-ын Хөгжлийн Бодлогын Хэлтэс

Суманд үйл ажиллагаа явуулж байгаа үйлчилгээний цэг, салбаруудыг авч үзвэл төрийн байгууллага 5, нөхөрлөл 3, хоршоо 2, хязгаарлагдмал хариуцлагатай компани 4, шашны байгууллага 1, төрийн өмчит аж ахуйн нэгж 1 (бөөрний сувилал) байгаа нь мөн л тус суманд эдийн засаг хязгаарлагдмал бүтэцтэй болохыг баталж байна.

Бигэр суманд ХААН банк, Монгол шуудан банкны салбарууд үйл ажиллагаа явуулж байгаа бөгөөд сумын хэмжээнд алтны олборлолтын оргил үе болох 2009 оны 8-10 сард зээлийн эргэн төлөлт нэмэгдэж, 322 зээлдэгчээс 56 зээлдэгч зээлээ төлсөн ба хугацаа хэтэрсэн зээлдэгч байхгүй байгаа тухай банкны ажилтнууд гүнзгийрүүлсэн ярилцлагаар мэдээлсэн.

Бигэр сумын хэмжээгээр 2009 онд 615 сая төгрөгийн төсөвтэй байсан ба 80 саяыг сумын орлогоос бүрдүүлсэн (малын хөлийн татвар, газар тариалан, ТҮЦ, НӨТ г.м) байна. 2009 оны 1-сард гаргасан Бигэр сумын ЗДТГ-ын дүн мэдээнээс харвал нийт 2483 мал хорогдсоноос адуу 167, үхэр 214, хонь 716, ямаа 1351 тэмээ 35 тус тус хорогджээ. 2010 онд зуд болж өвөлжилт хүндэрснээс малын хорогдол улам нэмэгдэж 2 сарын байдлаар 2352 мал хорогдож үүнээс адуу 85, үхэр 99, хонь 680, ямаа 1477, тэмээ 11 тус тус хорогджээ. Эдгээрээс харахад тус сумын оршин суугчдын хувьд амьжиргааны гол эх үүсвэр болсон мал аж ахуйд ихээхэн хүндрэл учирч байгаа нь иргэдийг албан бусаар алт олборлох ажил руу түлхэх нэг эх үүсвэр болж байж болзошгүй. Сумын хэмжээнд 2009 онд 165 га талбайд төмс, хүнсний ногоо, арвай, тэжээлийн ургац, жимс жимсгэнэ, байгалийн хадлан зэрэг тариалалт хийснээс 307 тонн ургац хураасан (*Аймгийн ЗДТГ, 2010*) байна.

Тус сумын төвд 75 хүүхдийн багтаамжтай 1 цэцэрлэг 1965 оноос хойш үйл ажиллагаа явуулж эхэлсэн бөгөөд 2009 оны байдлаар нийт 16 багш ажилчид ажиллаж байна. Сумын хэмжээгээр 2-6 насны нийт 127 хүүхэд байдгаас дөнгөж 75 нь сургуулийн өмнөх боловсролд хамрагдаж байгаа (*Аймгийн ЗДТГ, 2010*) нь ихээхэн хангалтгүй үзүүлэлт байв.

Сумын төв нэг эмнэлэгтэй, 4 их эмч, 7 бага эмч, 6 сувилагч, 4 үйлчлэгч, болон бусад 12 туслах ажилчдаас бүрдсэн баг сумын нийт хүн амд эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг хүргэдэг (*Аймгийн ЗДТГ, 2010*) байна. Сумын төвийн иргэдийн өвчлөлийг нь авч үзвэл (Хүснэгт 2.2), үе мөчний болон зүрх судасны өвчлөл түгээмэл байгаа нь харагдлаа.

Хүснэгт 2.2 Бигэр сумын эмнэлэгт бүртгэгдсэн өвчлөлийн тоо, 2009

Үзүүлэлт	Өвчилсөн хүний тоо
Гепатит А	1
Үе мөчний өвчин	96
Зүрх судасны өвчин	79
Хавдар	6
Чих хамар хоолойн өвчин	13
Суулгалт	20
Цус багадалт	15
Төрөлхийн хөгжлийн бэрхшээлтэй	12
Олдмол хөгжлийн бэрхшээлтэй	56
Хөгжлийн бэрхшээлтэй насанд хүрэгчдийн тоо	95
Төрөлхийн хөгжлийн бэрхшээлтэй	39
Нийт	432

2009 оны 12-р сард гаргасан Бигэр сумын ЗДТГ-ын цагдаагийн хэлтсийн дүн мэдээнээс харахад тус сард нийт 6 хэрэг бүртгэгдсэн байна. Үүнд:автын осол 1,танхай 3, хулгай 2.Энэ нь сумын төвд гэмт хэрэг зөрчил бага байгаа мэт харагдаж байгаа боловч иргэд ямар нэгэн гэмт хэргийг албан ёсоор хууль хяналтын байгууллагад мэдэгддэггүй, нуун дарагдуулах явдал цөөнгүй байдаг нь бүлгийн ярилцлага болон бичиг баримтуудаас анализ хийж үзэхэд илэрхий байсан.

Сумын багийн дарга нарын тодорхойлсноор сумын дүнгээр, нийгмийн халамж, тэтгэвэр тэтгэмж, асрамжийн үйлчилгээнд 2006-2009 онд давхардсан тоогоор нийт 295 хүн хамрагджээ. Түүнчлэн, 2009 онд амьжиргааны доод түвшнээс доогуур орлоготой 205 өрхөд 765 хүн амьдарч байгаа нь нийт өрхийн 31.4 хувь, нийт хүн амын 34.0 хувийг эзэлж байна. Амьжиргааны доод түвшнээс доогуур орлоготой өрхийн 5.3 хувь нь нэн ядуу өрх байна.

2.3 Бигэр сумын ашигт малтмалын нөөц, ашигт малтмал олборлолтын байдал

2009 онд Бигэр сумын ИТХ-ийн дарга, Засаг дарга, засаг даргын орлогч, Байгаль орчны байцаагч болон нутгийн зөвлөлийн гишүүдээс бүрдсэн баг ажиллаж тус сумын нийгэм эдийн засгийг хөгжүүлэх дунд шатны мастер төлөвлөгөө боловсруулсан байна. Энэхүү ажлын хүрээнд тус сумын нутаг дэвсгэрт доорхи ашигт малтмалуудыг албан ёсоор бүртгэсэн байна. Үүнд:

1. Бигэр нуурын давс
2. Цалуугийн цагаан толгойн гүний цагаан алтны орд
3. Алтан хадны цагаан алтны орд
4. Сүүжийн нүүрсний орд
5. Битүүтийн хотгорын зэс молибдены орд
6. Будагтын бараан толгойн шороон будагны орд
7. Зост, Цагаан хаалганы зосны орд
8. Тавинтай альвастерийн орд
9. Барилгын материалын орд, элс шавар зэрэг орж байна.

Бигэр суман дахь ашигт малтмалын нөөцүүдийг урьд нь Орос, Герман, Япон, Хятад, Монголын геологчид судалж байсан ба тэдний судалгаагаар тус сумын нутагт 0.005-2гр/тн агуулгатай алт, цагаан алтны бүлэг илэрц, 1-2м зузаантай элс, цэсийн эрдэсжилт бүхий хүдрийн бүс, 0,8-100гр/тн агуулгатай зэс мөнгөний илэрц, 0.5-0.8 хувь агуулгатай зэс молибдений илэрц, 2-3 хувь агуулгатай зэс-цайрын эрдэсжсэн цэг, 0.5-2м зузаантай 0.2-0.5м өргөнтэй нүүрсний гарцууд байгаа ажээ.

Говь-Алтай аймгийн ЗДТГ-ын Хөгжлийн Бодлогын Хэлтсийн гаргасан мэдээгээр, 2009 оны эцсийн байдлаар Бигэр сумын алтны нөөц бүхий газруудад ашиглалтын лиценз олгогдоогүй, хайгуулын 17 лиценз 6 аж ахуйн нэгжид олгогдсон байгаа ба тус сумын нутаг дэвсгэрт хувиараа алт олборлож байгаа иргэдийн тоо 20 мянга гаруй, эдгээрээс сумын уугуул оршин суугч 1556 байна. (Хавсралт Хүснэгт 3). Бигэр суманд хувиараа алт олборлож байгаа иргэд нь одоогоор тус сумын нутаг дэвсгэр дэх Сэрхийн нурууг тойрсон амууд болох Агуйт, Олстой, Гангат, Дөрөлж, Олон булаг, Өргөдөг, Улаан чулуут зэрэг амуудад голлон алт олборлож байгаа бөгөөд тэдгээр амууд нь сумын төвөөс 40-90 км зайд оршдог байна.


БҮЛЭГ 3. ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН БИГЭР СУМАНД ХУВИАРАА АЛТ ОЛБОРЛОГЧДЫН ШИНЖ БАЙДАЛ

Энэхүү бүлэгт Говь-Алтай аймгийн Бигэр суманд хувиараа алт олборлож буй иргэдээс түүвэрлэгдэн судалгаанд хамрагдсан 300 алт олборлогчийн ерөнхий шинж байдлыг авч үзнэ. Хүн ам зүй, орон нутгийн харьяалал ба шилжилт хөдөлгөөн, өрхийн ахуйн нөхцөл, амьжиргааны байдал зэргээрээ ямар шинж байдалтай хүмүүс хувиараа алт олборлох ажил хийж байгааг тодорхойлсноор цаашид албан бусаар алт олборлолтыг зохицуулах бодлого, арга хэмжээнүүдийг ямар хүмүүс, бүлэгт чиглүүлэх асуудал илүү тодорхой болох ач холбогдолтой юм.

3.1 Хүн ам зүйн шинж байдал

Бигэр суманд хувиараа алт олборлож байгаа иргэдийн хүн ам зүйн шинж байдлын үзүүлэлтүүдийг Зураг 3.1 ба Хүснэгт 3.1-д үзүүлэв. Судалгаанд хамрагдагчдын нас, хүйсийн бүтцийг авч үзвэл (Зураг 3.1), дийлэнх нь залуу насны хүмүүс байгаа бөгөөд хүйсийн хувьд эрэгтэйчүүд (230) эмэгтэйчүүдээс 3.3 дахин их байна.

Зураг 3.1. Бигэр суманд хувиараа алт олборлогчдын тоо, нас, хүйсийн бүтцээр



Хүснэгт 3.1-д гаргасан голч насны үзүүлэлтээс харахад нийт судалгаанд хамрагдагчдын 50 хувь нь 36 хүртэл настай, үлдсэн 50 хувь нь түүнээс дээш настай (дээд тал нь 60 хүртэлх настай) ХАМО нар байна. Насыг хүйсээр ялган харвал, Бигэр суманд хувиараа алт олборлож буй эрэгтэйчүүдийн дундаж нас (36.5) эмэгтэйчүүдийнхээс 1.4 насаар залуу байна.

Гэрлэлтийн байдлыг авч үзвэл, Бигэр суманд алт олборлогчдын дийлэнх (77 хувь) гэр бүлтэй хүмүүс байгаа ба 15.3 хувь нь огт гэрлээгүй, 7.7 хувь нь салсан, тусгаарласан, бэлэвсэн гэх мэт ганц бие хүмүүс байв. Хүйсээр ялган харахад, гэр бүлтэй эмэгтэйчүүдийн алт олборлоход оролцдог байдал (84.3 хувь) мөн адил эрэгтэйчүүдийнхээс 9.5 пунктээр илүү байгаа нь гэр бүлтэй эмэгтэйчүүдийн өрхийн амьжиргаандаа анхаарал тавьж орлого олох санаачлага мөн адил эрэгтэйчүүдийнхээс илүү байгааг харуулж байж болох юм.

Хүснэгт 3.1 Судалгаанд хамрагдсан ХАМО нарын хувийн жин, хүн ам зүйн шинж байдлаар

Хүн ам зүйн шинж байдал	Хүйс		Нийт
	эрэгтэй	эмэгтэй	
Насны бүлэг			
18-30	31.3	22.9	29.3
31-40	36.5	42.8	38.0
41-60	32.2	34.3	32.7
Дундаж нас	36.5	37.9	36.8
Голч нас	35.0	38.0	36.0
Гэрлэлтийн байдал			
Огт гэрлээгүй	18.3	5.7	15.3
Гэр бүлтэй	74.8	84.3	77.0
Салсан/тусгаарласан/бэлэвсэн	6.9	10.0	7.7
Боловсролын түвшин			
Боловсролгүй	1.7	1.4	1.7
Бага	17.8	5.7	15.0
Бүрэн бус дунд	24.8	25.7	25.0
Бүрэн дунд	40.4	50.0	42.7
Тусгай мэргэжлийн/дээд	15.3	17.2	15.7
Өрхийн ам бүлийн тоо			
1-3 гишүүн	29.1	21.4	27.3
4 гишүүн	35.7	38.6	36.3
5-8 гишүүн	35.2	40.0	36.3
Ам бүлийн дундаж тоо	4.3	4.5	4.35
Өрх дэх 0-16 насны хүүхдийн тоо			
Байхгүй	23.5	5.7	19.3
1 хүүхэдтэй	23.9	32.9	26.0
2 хүүхэдтэй	35.2	45.7	37.7
3-6 хүүхэдтэй	17.4	15.7	17.0
0-16 насны хүүхдийн дундаж тоо	1.55	1.79	1.61
Давхар ажил эрхлэлтийн байдал			
Алт олборлохоос өөр ажил эрхэлдэг:	(70.0)	(61.4)	(68.0)
Төрийн байгууллагад ажилладаг	13.0	15.7	13.4
Төрийн бус байгууллагад ажилладаг	2.1	0.0	1.7
Хувийн компанид ажилладаг	7.7	0.0	6.0
Малчин	30.8	28.6	30.3
Хувиараа ажил, наймаа хийдэг	13.4	17.1	14.3
Суралцдаг	3.0	0.0	2.3
Алт олборлохоос өөр ажил эрхэлдэггүй	30.0	38.6	32.0
Бүгд	100.0	100.0	100.0
ХАМО нарын тоо	230	70	300

Судалгаанд хамрагдсан ХАМО нарын гуравны хоёр буюу 67.7 хувь нь бүрэн бус дунд буюу бүрэн дунд боловсролтой байсан ба ямар нэг мэргэжил эзэмшсэн, дээд болон тусгай мэргэжлийн боловсролтой хүмүүс 15.7 хувийг эзэлж байв. Харин үлдсэн 16.7 хувь нь бага боловсролтой эсвэл албан ёсны боловсролгүй боловч бичиг үсэгт тайлагдсан хүмүүс байна. Хүйсийн хувьд алт олборлож буй эмэгтэйчүүдийн боловсролын түвшин эрэгтэйчүүдийнхээс бага зэрэг өндөр байгаа нь харагдлаа.

Бигэр суманд хувиараа алт олборлож буй ХАМО нарын гэр бүл дунджаар 4-5 гишүүнтэй (4.35) байгаа нь Говь-Алтай аймгийн дундаж (3.9), улсын дундаж (4.0)-аас тус тус өндөр үзүүлэлт байв. Хүйсээр нь харахад 4 буюу түүнээс олон ам бүлтэй өрхөөс хувиараа алт

олборлож буй эмэгтэйчүүд (78.6 хувь) мөн адил эрэгтэйчүүд (70.9 хувь) -ээс илүү байна. Түүнчлэн алт олборлогч 1 өрхөд дунджаар 1.61 буюу 2 орчим 0-16 насны хүүхэд байгаа ба хүүхэдтэй эмэгтэй алт олборлогчид (94.3 хувь) хүүхэдтэй эрэгтэй алт олборлогчдоос 20 орчим пунктээр илүү байна. Эдгээрээс харахад хувиараа алт олборлох ажилд оролцож байгаа эмэгтэйчүүд мөн адил эрэгтэйчүүдийг бодвол олон ам бүл, хүүхэдтэй өрхийн хүмүүс байгаа нь анхаарал татаж байна.

Алт олборлохоос өөр ажил давхар эрхэлдэг/сурдаг эсэхийг асуухад ХАМО нарын гуравны хоёр хувь нь “тийм” гэж хариулсан ба тэдгээрийн дунд малчин (30.3 хувь), хувиараа ажил, наймаа хийдэг (14.3 хувь), төрийн ямар нэг байгууллагад ажилладаг (13.4 хувь) хүмүүс бусад төрлийн ажил эрхэлдэг хүмүүсээс илүүтэй байлаа. Ийнхүү хэдийгээр алт олборлогчдын олонх нь давхар ажил эрхэлдэг гэсэн хэдий ч тэдний зонхилон эрхэлдэг малчин, хувиараа ажил наймаа хийх зэрэг ажлууд нь байгаль, цаг уур болон бусад хүчин зүйлээс ихээхэн хараат, мөнгөн орлого тогтворгүй байдаг ажлууд байна. Үүнээс гадна, судалгаанд хамрагдсан ХАМО нар хэдийгээр бүгд хөдөлмөрийн насны байсан ч тэдний гуравны нэг нь алт олборлохоос өөр давхар ажил эрхэлж, сурдаггүй байгаа нь орон нутгуудад албан салбарт ажил эрхлэх боломж хязгаарлагдмал буюу ажлын байр хангалтгүй байгааг харуулж байна. Ялангуяа алт олборлохоос өөр давхар ажил эрхэлдэггүй эмэгтэйчүүдийн хувь (38.6 хувь) эрэгтэйчүүд (30.0 хувь)-ийнхээс илүү байгаагаас харахад албан салбарт эмэгтэйчүүдийн ажилгүйдэл эрэгтэйчүүдийнхээс илүү байна гэж дүгнэж болохоор байна.

3.2 Орон нутгийн харьяалал, шилжилт хөдөлгөөн

Сүүлийн жилүүдэд алт олборлох ажил хүмүүсийн анхаарлыг татан, хөдөө орон нутаг, хот суурин газруудаас хүмүүс алтны нөөц бүхий газар руу ихээр ирж ажиллах болжээ. Энэхүү судалгаанд Монгол улсын өөр аймаг, хот, сумаас Бигэр суманд сүүлийн 1 жилийн хугацаанд ирж, буцан алт олборлож буй хариулагчдыг *явуулын алт олборлогчид*, харин 1-ээс дээш жил амьдран алт олборлож буй хариулагчдыг *суурин алт олборлогчид* гэж тодорхойлсон.


Дээрх тодорхойлолтоор авч үзэхэд, судалгаанд хамрагдсан нийт ХАМО нарын 27.7 хувь (эрэгтэйчүүдийн 30.0 хувь, эмэгтэйчүүдийн 20.0 хувь) нь явуулын алт олборлогчид байсан (Хүснэгт 3.2) ба тэднийг Бигэр суманд ирж буцан өнгөрөөсөн хугацаагаар нь нарийвчлан харвал 9.7 хувь нь 1-2 сарын өмнөөс, 8.7 хувь нь 3-4 сарын өмнөөс, 9.3 хувь нь 5-12 сарын өмнөөс өөр аймаг, хот, сумаас Бигэр суманд ирж алт олборлох болсон хүмүүс байв.

Хүснэгт 3.2 Судалгаанд хамрагдагчдын хувийн жин, шилжилтийн байдал, хүйсээр


Шилжилтийн байдал	Хүйс		Нийт
	эрэгтэй	эмэгтэй	
Явуулын	(30.0)	(20.0)	(27.7)
Үүнээс: 1-2 сарын өмнө ирсэн	11.7	2.8	9.7
3-4 сарын өмнө ирсэн	10.0	4.3	8.7
5-12 сарын өмнө ирсэн	8.3	12.9	9.3
<i>Бигэрт ирээд өнгөрөөсөн дундаж хугацаа (сараар)</i>	3.3	5.0	3.6
Суурин	70.0	80.0	72.3
Бүгд	100.0	100.0	100.0
ХАМО нарын тоо	230	70	300

Бигэр суманд хувиараа алт олборлож буй явуулын иргэдийн хаанаас ирснийг авч үзвэл (Зураг 3.2), Баянхонгор (34.9 хувь), Говь-Алтай аймгийн Бигэрээс бусад сум (26.5 хувь), Завхан (20.5 хувь), Өвөрхангай (9.6 хувь), Ховд (3.6 хувь), Архангай (2.4 хувь), Дундговь (1.2 хувь), Говьсүмбэр (1.2 хувь), зэрэг газрууд байгаа нь тус нутагтай хил залгаа болон ойролцоох нутаг орнууд байна.

Зураг 3.2 Бигэр суманд алт олборлож буй явуулын ХАМО нарын хувийн жин, хаанаас ирсэн эсэхээр



Дээрх явуулын алт олборлогчдын Бигэрт ирсэн шалтгааныг Зураг 5.3-т харуулав. Сүүлийн 1 жилийн хугацаанд өөр орон нутгаас ирсэн гэж мэдээлсэн хүмүүсийн дийлэнх (эрэгтэй явуулын ХАМО нарын 94.2 хувь, эмэгтэй явуулын ХАМО нарын 78.6 хувь) нь Бигэр сум руу ирэхдээ алт олборлох гол зорилготой байсан ба үлдсэн хувь нь алт олборлох шууд зорилгогүйгээр амьжиргаагаа дээшлүүлэх боломж хайж ирээд алт олборлох болсон, эсвэл гэр бүлийнхэн, хамаатнаа дагаж ирсэн хүмүүс байна.



Нутгийн иргэд болон ХАМО нарын яриагаар, Бигэрт ирж алт олборлох болсон явуулын ХАМО нарын тоо сүүлийн үед ихээхэн нэмэгдэж байгаа бөгөөд тус суманд зөвшөөрөлгүй алт олборлох явдалтай нутгийн засаг захиргаа болон бусад холбогдох байгууллагууд багагүй хүч гарган тэмцэж байгаа тул тэд олонх тохиолдолд нутгийн айл, өрхүүдэд хэдэн сараар суурьшин амьдарч, алт олборлох ажлыг хийдэг болжээ (Шигтгээ 3.1).

Шигтгээ 3.1

Алт олборлоход туршлага их хэрэгтэй юм билээ. Манай суманд алт гараад удаагүй болохоор туршлага бага, багаж хэрэгслүүд дутмаг байдаг. Олон жил алт олборлосон иргэд, ялангуяа Баянхонгорын нинжа нар бидний туршилагагүй байдлыг ашиглан алтны гарцтай хэсгийг нь мэдэж бидний ухааж байгаа газрыг “наад нүхээ зарчих 50 мянгаар авъя” гэдэг. Бид юм олохгүй дэмий ухааж байхаар гээд зардаг, гэтэл тэр нүхнээс зөндөө алт гарсан байдаг. Тийм учраас манай нутгийн иргэд өөр нутгийн туршилагатай нинжа нартай танилцан, гэртээ байлгах, аль эсвэл гэртээ түрээсээр суулгах тохиолдол их байгаа. Шалгалт хийж янз бүрийн хүмүүс ирэхэд тэднийг өөрсдийн хамаатан гээд хэлчихдэг. Хөдөө малчин айлуудаар явахад бараг айл бүрт гадны нинжа байх болсон.

Ч, эрэгтэй 40 настай алт олборлогч

Монгол улсад мөрдөгдөж буй “Иргэдийн шилжин суурьших хөдөлгөөнийг бүртгэх, мэдээлэх журам”-д иргэн хүн шилжих хөдөлгөөнд оролцсон шалтгаанаасаа хамааралгүйгээр 30 хоногоос дээш хугацаагаар амьдарч буй нутаг дэвсгэрээ өөрчилбөл, шилжилт хөдөлгөөнөө 7 хоногийн дотор бүртгүүлэх шаардлагатай тухай заасан байдаг. Аливаа шилжих хөдөлгөөнд оролцогсод шилжин очсон нутаг дэвсгэртээ албан ёсоор бүртгүүлснээр нийгмийн үйлчилгээнээс хүртэх, өөрсдийн эрх ашгийг хамгаалах боломжууд нь баталгааждаг. Тэгвэл, явуулын ХАМО нар шилжилт, хөдөлгөөнөө засаг захиргаанд бүртгүүлэх ач холбогдлын талаар ямар ойлголттой байдгийг бид судалгаагаараа асуусан ба үр дүнг Хүснэгт 3.3-т харуулав.

Хүснэгт 3.3 Бигэр суманд алт олборлож байгаа явуулын ХАМО нарын хувь, шилжих хөдөлгөөнөө бүртгүүлэх ач холбогдлын талаарх ойлголт, хүйсээр

Шилжих хөдөлгөөнөө бүртгүүлэх ач холбогдлын талаарх ойлголт	Хүйс		Нийт
	эрэгтэй	эмэгтэй	
Бүртгүүлэхийн ач холбогдлыг мэдэхгүй	52.2	14.3	45.8
Хэрэг болохгүй	27.5	35.7	28.9
Эрүүл мэндийн тусламж авахад хэрэгтэй	13.0	50.0	19.3
Нийгмийн халамжийн үйлчилгээ авахад хэрэгтэй	10.1	35.7	14.5
Ажил эрхлэхэд хэрэгтэй	2.9	7.1	3.6
Хүүхдээ сургууль цэцэрлэгт оруулахад	5.8	28.6	9.6
Явуулын ХАМО нарын тоо *	69	14	83

* Хариулт олон сонголттой тул хувийн жингийн нийлбэр 100%-аас илүү

Судалгаанд хамрагдсан явуулын ХАМО нарын дунд шилжих хөдөлгөөнөө бүртгүүлэхийн ач холбогдлыг зөв ойлгодог хүмүүс харьцангуй бага байна. Тухайлбал, давхардсан тоогоор тэдний дөнгөж 19.3 хувь нь эрүүл мэндийн тусламж авахад, 14.5 хувь нь нийгмийн халамжийн үйлчилгээ авахад, 9.6 хувь нь хүүхдээ сургууль цэцэрлэгт оруулахад очсон газартаа бүртгүүлэх нь хэрэг болно гэж хариулж байв. Шилжих хөдөлгөөнөө

бүртгүүлэхийн ач холбогдлын талаар мэдэхгүй гэсэн хариултыг нийт явуулын ХАМО нарын 45.8 хувь нь өгсөн ба 28.9 хувь нь бүртгүүлэх нь ямар ч хэрэг болохгүй гэж үзэж байв.

Бигэрт ажиллаж буй явуулын ХАМО нарын шилжих хөдөлгөөний бүртгэлийн байдал ямар байгааг авч үзвэл, 96.4 хувь (эрэгтэйчүүдийн 98.6 хувь, эмэгтэйчүүдийн 85.7 хувь) нь засаг захиргаанд албан ёсоор бүртгүүлээгүй байгаа бөгөөд бүртгүүлээгүй гол шалтгаанаа тус суманд түр ирсэн, бүртгүүлэх шаардлагагүй гэж бодсон (96.3 хувь), эсвэл хэрхэн бүртгүүлэх талаар мэдэхгүй (3.8 хувь) гэж тайлбарлажээ. Эдгээрээс, иргэдийн дунд шилжих хөдөлгөөний бүртгэлийн талаарх зөв ойлголт, мэдээллийг нэмэгдүүлэх хэрэгцээ байгаа нь харагдаж байна.

3.3 Өрхийн ахуйн нөхцөл, амьжиргаа

Хүмүүсийн албан бусаар алт олборлох үйл ажиллагаа нь тэдний өрх гэрийн эдийн засгийн амьдралын нөхцөл байдлаас шууд хамааралтай гэдгийг өмнө хийгдсэн олон төстэй судалгаанууд баталсан байдаг. Энэ хамаарал Бигэр суман дахь ХАМО нарын хувьд байгаа эсэхийг харах үүднээс бид судалгаандаа хувиараа алт олборлогчийн эдийн засгийн амьдралыг илэрхийлж болох өрхийн амьдардаг ахуйн нөхцөл, хөрөнгө, орлогын байдал ба орлого бүрдүүлэлт зэрэгтэй холбоотой асуултуудыг оруулсан. Хүснэгт 3.4-т судалгаанд хамрагдагчдын өрхийн ахуйн нөхцөл, хөрөнгийн зарим үзүүлэлтүүдийг харуулав.

Хүснэгт 3.4 Судалгаанд хамрагдагчдын хувийн жин, өрхийн ахуйн нөхцөлийн үзүүлэлтүүд, хүйсээр

Өрхийн ахуйн нөхцөлийн үзүүлэлтүүд	Хүйс		Нийт ХАМО нар
	эрэгтэй	эмэгтэй	
Сууцны төрөл			
Гэр	86.5	91.4	87.7
Хашаа, байшин	9.1	8.6	9.0
Сууцны өмчлөлийн хэлбэр			
Хувийн	92.6	98.6	94.0
Түрээсийн	6.5	1.4	5.3
Бусдын сууцанд үнэгүй	0.9	0.0	0.7
Тээврийн хэрэгсэлтэй эсэх			
Тийм	78.7	55.7	73.3
Үгүй	21.3	44.3	26.7
Газар тариалан эрхэлдэг эсэх			
Тийм	7.4	8.6	7.7
Үгүй	92.6	91.4	92.3
Хувийн мал, тэжээвэр амьтантай эсэх			
Тийм	70.0	58.6	67.3
Үгүй	30.0	41.4	32.7
Бүгд	100.0	100.0	100.0
ХАМО нарын тоо	230	70	300

Бигэр суманд хувиараа алт олборлогчдын дийлэнх буюу 87.7 хувь нь өөрсдийн өрхийг гэр сууцанд, 9.0 хувь нь хашаа байшинд амьдардаг гэж мэдээллээ. Сууцны өмчлөлийн хувьд тухайн амьдарч буй сууц нь өөрсдийн хувийнх нь өмч гэж хариулагчид нийт судалгаанд хамрагдсан ХАМО нарын 94.0 хувийг эзэлж байсан ба 5.3 хувь нь түрээсийн сууцанд, 0.7 хувь нь өөрсдийн сууцгүй, бусдын сууцанд үнэгүй түр сууж байгаа өрхийн иргэд байв.

Ийнхүү ХАМО нарын өрхийн тодорхой хувь нь өөрийн гэсэн сууцгүй байгаа нь тэдний амьдралын нөхцөл хэцүү гэдгийг баталж байна.

Орчин үед хүмүүсийн өдөр тутмын амьдралд цаг, хөдөлмөр хэмнэх, тэр хэрээрээ орлого нэмэгдүүлэхэд тусалдаг тээврийн хэрэгслийн гүйцэтгэх үүрэг ач холбогдол улам нэмэгдэж байна. Судалгаанд хамрагдсан ХАМО нарын өрхийн 73.3 хувь нь хувьдаа ямар нэгэн өөрөө явагч тээврийн хэрэгсэлтэй гэж хариулсан ба тэдгээр хэрэгслүүд нь мотоцикль (60 хувь), машин (14.3 хувь), ачааны машин (5.0 хувь), жижиг трактор буюу ярианы хэлээр “пад пад” (1.7 хувь) зэрэг байна.

Судалгаанд хамрагдсан хувиараа алт олборлож байгаа өрхүүдийн 7.7 хувь нь өрхийн аж ахуйн хүрээнд чацаргана, төмс, хүнсний ногоо тариалах зэргээр газар тариалан эрхэлж, өрхийн амьжиргаандаа нэмэр болгодог байна. Ийм төрлийн газар тариалан эрхэлж байгаа өрхүүд дунджаар 1.91 га газарт тариалан эрхэлж байгаа нь тэдний аж ахуй харьцангуй жижиг хэмжээтэй болохыг харуулж байна.

Монголын хөдөөгийн ард иргэдийн амьжиргааны гол эх үүсвэрүүдийн нэг нь мал аж ахуй байдаг. Энэ судалгаанд хамрагдагдсан ХАМО нарын өрхийн 67.3 хувь нь хувийн мал аж ахуй эрхэлдэг гэжээ. Ийнхүү олонх ХАМО нарын өрх мал гэсэн үндсэн хөрөнгөтэй байгаа ч тэдний эрхэлдэг нүүдлийн мал аж ахуй нь байгаль цаг уурын нөхцлөөс ихээхэн хараат, нэг л ган, зуд болоход мал олон тоогоороо хорогддог гэдэг утгаараа тогтворгүй орлогын эх үүсвэрт орж болохоор юм.

Хувиараа алт олборлогч гишүүнтэй судалгаанд хамрагдсан өрхүүдэд байгаа малын дундаж тоог нэр төрлөөр нь Зураг 3.4-т харууллаа.



Жич: Малын тоог нэгтгэн тоолохдоо бог малыг бодод шилжүүлэх коэффициентийг ашиглав. Эдгээр нь: 1 бод = 1 адуу = 1 үхэр = 0.67 тэмээ = 6 хонь = 8 ямаа

Хувийн малтай гэж хариулсан алт олборлогч нэг өрхөд ногдох нийт малын тоо нь дунджаар 22.9 толгой бод байгаа ба малын нэр төрлөөр нь авч үзвэл, ямаа (70.2 толгой), хонь (32.3 толгой) зэрэг малыг бусад малаас илүү тоогоор өсгөж, үржүүлэн аж ахуйдаа хэрэглэдэг байна. Ямааны тоо ийнхүү бусад малаас их байгаа нь нэг талаас ямаа тухайн орон нутгийн байгаль, цаг уурын нөхцөлд өсгөж үржүүлэхэд тохирдог, нөгөө талаас

ноолуураар дамжуулан өрхийн амьжиргаанд мөнгөн орлого оруулах нь их байдагтай холбоотой болов уу.

Бигэр суманд хувиараа алт олборлож байгаа иргэдийн өрхийн амьжиргаатай холбоотой зарим гол үзүүлэлтүүдийг Хүснэгт 3.5-д харуулав.

Хүснэгт 3.5 Судалгаанд хамрагдагчдын хувийн жин, өрхийн амьжиргааны үзүүлэлтүүдээр

Өрхийн амьжиргааны үзүүлэлтүүд	ХАМО нарын хувь
Өрхөд байгаа орлого олох ажил эрхэлдэг хүний тоо	
1 хүн	61.3
2 хүн	35.4
3 хүн	3.3
<i>Нэг өрхөд байгаа ажил эрхэлдэг хүний дундаж тоо</i>	<i>1.42</i>
Өрхийн сарын нийт орлого (төгрөг)	
262 850-аас доош	25.0
262 850-358 499	25.0
358 500- 482 999	24.7
483 000 буюу түүнээс дээш	25.3
<i>Хувиараа алт олборлогчтой 1 өрхийн сарын нийт орлогын дундаж хэмжээ (төгрөг)</i>	<i>396 262.49</i>
<i>Хувиараа алт олборлогчтой 1 өрхийн нэг хүнд ногдох сарын дундаж орлого (төгрөг)</i>	<i>103 255.77</i>
<i>Хувиараа алт олборлогчтой 1 өрхийн нэг хүнд ногдох сарын голч (медиан) орлого (төгрөг)</i>	<i>86 733.33</i>
Өрхийн амьжиргааны түвшин	
Ядуу бус	40.0
Ядуу*	60.0
Үүнээс: Нэн ядуу**	(23.0)
<i>Бүх өрх дэх нийт хүн амд ядуу хүн амын эзлэх хувь</i>	<i>68.0</i>
Өрх мөнгөн хадгаламжтай эсэх	
Тийм	11.7
Үгүй	88.3
Бүгд	100.0
ХАМО нарын тоо	300

* өрхийн нэг хүнд ногдох сарын орлого нь 2009 оны Баруун бүсийн 1 хүнд сард ногдох амьжиргааны доод түвшингийн үзүүлэлт (ядуурлын шугам) болох 96100 төгрөгөөс доош байгаа өрх

** өрхийн нэг хүнд ногдох сарын орлого нь ядуурлын шугамын 60 хувьд хүрэхгүй байгаа өрх

ХАМО нарын өрхөд нь орлого олох ямар нэгэн ажил (албан, албан бус секторын аль ч болно) эрхэлдэг хүний тоо цөөн байх тусам тухайн өрхийн эдийн засгийн чадавхи доогуур байх магадлалтай. Энэ судалгаагаар ХАМО нарын 61.3 хувь нь өөрийн өрхдөө орлого олох ямар нэгэн ажил эрхэлдэг хүн 1 байдаг гэж хариулсан ба 2 хүн ажилладаг гэж хариулагсад 35.4 хувь, 3 хүн ажилладаг гэж хариулагсад дөнгөж 3.3 хувийг эзэлж байв. Дунджаар, хувиараа алт олборлогч 1 өрхөд 1.4 буюу 1-2 хүн л орлого олох ямар нэгэн ажил эрхэлдэг гэж гарсныг ам бүлийн дундаж тоо болох 4.4 –тэй харьцуулбал нэлээд бага байна. Өөрөөр хэлбэл, Бигэр суманд ажиллаж буй ХАМО нарын үндсэн өрхүүдэд ажил хийдэг 1 хүн дунджаар өөрөөсөө гадна 3 хүнийг “тэжээж” байна гэсэн үг юм.


Өрхийн сарын нийт орлогын байдлыг авч үзвэл, судалгаанд хамрагдсан алт олборлогчтой 1 өрхийн сарын нийт орлого дунджаар 396 262.5 төгрөг, нэг хүнд ногдох сарын дундаж орлого нь 103 255 төгрөг байна. Гэхдээ судалгаанд хамрагдсан өрхүүдийн хувьд сарын

орлогын түвшингийн дээд, доод хязгаарын ялгаа нэлээд их байсан тул дээрх дундаж үзүүлэлтүүдээр өрхийн амьжиргааны түвшинг шууд дүгнэх нь өрөөсгөл болох талтай. Үүнийг өрхийн нэг хүнд ногдох сарын голч орлогын хэмжээ баталж байгаа ба энэ үзүүлэлт 86733.33 төгрөг гарсан нь судалгаанд хамрагдсан хувиараа алт олборлогчдын өрхүүдийн 50 хувь нь сард 86 733.33 төгрөг хүртэл нэг хүнд ногдох орлоготой, үлдсэн 50 хувь нь сард түүнээс дээгүүр нэг хүнд ногдох орлоготой байгааг харуулж байна.

Өрхийн нэг хүнд ногдох сарын орлогын мэдээлэл нь тухайн өрхийн амьжиргааны түвшнийг ерөнхийлөн хэмжих гол үзүүлэлт байдаг ба үүний тусламжтайгаар өрхүүдийг амьжиргаагаар нь ядуу болон ядуу бус гэж ангилж болно. Говь-Алтай аймаг нь Монгол улсын эдийн засгийн бүсчлэлээр баруун бүсэд харъяалагддаг бөгөөд 2009 оны байдлаар Баруун бүсийн 1 хүнд сард ногдох амьжиргааны доод түвшингийн үзүүлэлт (ядуурлын шугам) 96100 төгрөг байв. Энэ шалгуур үзүүлэлтээр судалгаанд хамрагдсан хувиараа алт олборлож буй иргэдийн өрхийн амьжиргааг ангилбал, тавны гурав буюу 60 хувь нь ядуу өрх, үлдсэн 40 хувь нь ядуу бус өрх байна. Ядуурлын байдлыг нарийвчлан харвал, нэн ядуу буюу 1 хүнд сард ногдох орлого нь ядуурлын шугамын 60 хувьд хүрэхгүй байгаа өрхүүд нийт судалгаанд хамрагдсан ХАМО нарын өрхүүдийн 23 хувийг эзэлж байв. Хүн амын тоогоор нь авч үзэхэд судалгаанд хамрагдсан 300 өрхөд байгаа нийт 1305 хүн амын 68 хувь нь сард ядуурлын шугамаас доош орлоготой амьдардаг болох нь харагдлаа. Эдгээр баримтууд ядуурал бол хувиараа алт олборлолтын нэг үндсэн шалтгаан гэдгийг тодхон баталж байна.

Мөнгөн хадгаламж нь өрх ба хувь хүмүүсийн амьжиргаа эрсдэлд орсон үед хэрэг болдог чухал амьжиргааны эх үүсвэрүүдийн нэг.ХАМО нарын 11.7 хувь өрхийн мөнгөн хадгаламжтай гэсэн ба тэд жилд дунджаар 113 714 төгрөг (12 сард хуваавал 9476 төгрөг)-ийг хадгалж чаддаг гэж мэдээлжээ.

Судалгаанд хамрагдсан ХАМО нарын өрхийн сарын орлого бүрдэлтийг эх үүсвэрүүдээр нь задлан харвал (Зураг 3.5), алт олборлолт хамгийн өндөр буюу 55.4 хувийг бүрдүүлж байгаа ба үүний дараа цалин (24.95 хувь), хувийн мал аж ахуй, газар тариалангийн бүтээгдэхүүнүүд (9.03 хувь) орж байна. Эдгээрээс харахад эдийн засгийн албан салбараас орлого бага олдог, эсвэл албан салбарт орлогын эх үүсвэр цөөтэй өрхүүд алт олборлолтод илүүтэй оролцож байгаа ба үндсэндээ ХАМО нарын өрхийн амьжиргаа алт олборлолтоос ихээхэн хараат байна гэсэн үг юм.



БҮЛЭГ 4. ХУВИАРАА АЛТ ОЛБОРЛОГЧДЫН АЖИЛ ЭРХЛЭЛТ, АЖЛЫН НӨХЦӨЛ, ХӨДӨЛМӨР ХАМГААЛАЛ

Судалгааны энэ бүлэг нь ХАМО нарын алт олборлох ажилд оролцож эхэлсэн түүх, одоогийн алт олборлох ажлын ачаалал, ажлын нөхцөл, хөдөлмөр хамгааллын асуудлуудыг алт олборлогчдын шинж байдлаар нь дэлгэрэнгүй авч үзэх болно.

4.1 Алт олборлох ажлын түүх

Бигэр суманд хувиараа алт олборлож буй судалгаанд оролцогчдын 38.7 хувь нь 1-2 сар, 61.3 хувь нь 3 буюу түүнээс олон сар алт олборлох ажил хийж байгаа хүмүүс байв (Хүснэгт 4.1). Хувиараа алт олборлосон хугацааны дунджийг нь авч үзвэл 7-8 сарын туршлагатай байсан ба тэд Говь-Алтай аймгийн Бигэр суман дахь алттай газруудад харьцангуй сүүл үеэс ажиллаж эхлэн дунджаар 2-3 сар болж байгаа хүмүүс байна. Судалгаанд хамрагдагчдад хувиараа алт олборлох ажлыг хамгийн богинодоо 1 сар, хамгийн ихдээ 5 жил хийсэн туршлагатай хүмүүс багтаж байсан бөгөөд Бигэр суманд ажилласан туршлагын хувьд хамгийн богинодоо 1 сар, хамгийн удаандаа 12 сар ажилласан хүмүүс байлаа.

Хүснэгт 4.1 Судалгаанд хамрагдагчдын хувийн жин, хувиараа алт олборлосон хугацаа, хариулагчийн шинж байдлаар

Сонгосон үзүүлэлтүүд	Хувиараа алт олборлосон хугацаа (сар)			Бигэр суманд алт олборлосон дундаж сар	Бүгд	ХАМО нарын тоо
	1-2 сар	3+ сар	Дундаж хугацаа			
Насны бүлэг						
18-30	38.6	61.4	7.0	3.0	100.0	88
31-40	31.6	68.4	10.3	3.0	100.0	114
41-60	46.9	53.1	5.4	2.5	100.0	98
Хүйс						
Эрэгтэй	36.1	63.9	8.0	2.9	100.0	230
Эмэгтэй	47.1	52.9	6.9	2.8	100.0	70
Боловсролын түвшин						
Бага/боловсролгүй	20.0	80.0	7.6	3.4	100.0	50
Бүрэн бус дунд	42.7	57.3	10.7	2.6	100.0	75
Бүрэн дунд	38.3	61.7	7.6	2.8	100.0	128
Тусгай мэргэжлийн/дээд	53.2	46.8	3.6	2.8	100.0	47
Давхар ажил эрхлэлтийн байдал						
Давхар ажил эрхэлдэг/сурдаг	40.1	59.9	7.0	2.9	100.0	207
Давхар ажил эрхэлдэггүй	35.5	64.5	9.4	2.7	100.0	93
Шилжих хөдөлгөөний байдал						
Явуулын	12.0	88.0	18.9	3.2	100.0	83
Суурин	48.8	51.2	3.4	2.7	100.0	217
Өрх дэх 0-16 насны хүүхдийн тоо						
Байхгүй	44.8	55.2	6.4	2.9	100.0	58
1 хүүхэдтэй	39.7	60.3	8.7	3.1	100.0	78
2 хүүхэдтэй	37.2	62.8	7.4	2.8	100.0	113
3-6 хүүхэдтэй	33.3	66.7	8.4	2.5	100.0	51
Өрхийн амьжиргааны түвшин						
Ядуу	34.4	65.6	8.1	2.7	100.0	180
Ядуу бус	45.0	55.0	7.1	3.0	100.0	120
Нийт алт олборлогчид	38.7	61.3	7.7	2.8	100.0	300

Хувиараа алт олборлох ажил хэр удаан хийсэн туршлагыг алт олборлогчдын шинж байдлаар нь авч үзвэл, удаан хугацаагаар буюу 3-аас олон сар ажиллаж байгаа хүмүүсийн хувь 31-40 насны, эрэгтэй, боловсрол доогуур, давхар ажил эрхэлдэггүй хүмүүсийн дунд бусад бүлгийн хүмүүсийнхээс өндөр байв. Энэ нь, тэд эдийн засгийн албан салбарт ажиллаж орлого олох боломж нь илүү хязгаарлагдмал байдгаас хувиараа алт олборлох ажилд эртнээс оролцох болсоныг харуулж байгаа болов уу.

Шигтгээ 4.1

30-аас дээш насныхныг төр засаг хаясан шүү дээ. Орон нутагт ажлын байр ховор, хот сууринд очиж ажиллая гэхээр мэргэжил боловсрол гологдоно. Дээр нь сүүлийн хэдэн жилд зуд турхан болж хэдэн малаа алдлаа. Амь зуухын тулд энд амь насаараа дэнчин тавьж хаа холоос эхнэр хүүхдүүдээ орхин ирж байна. Гэтэл хамгаалалтынхнаас байнга зугтан 4-5 км хөөгдөн ирүпээ ч ухааж амжихгүй буцаад хөөгдөж явна.... Энд холоос ирээд буцах зардлаа ч олж чадаагүй хүн байна. Алт олборлодог гэхээр л муу хүмүүс байдаггүй шүү дээ, амьдрахын эрхэнд аргагүйдээ л зовж явна.

Б, эрэгтэй 35 настай ХАМО

Шилжих хөдөлгөөний байдлаар нь авч үзвэл, хувиараа алт олборлох ажлыг удаан хийсэн хандлага Бигэр сумын суурин иргэд (51.2 хувь)-ийг бодвол явуулын ХАМО нар (88.0 хувь)-ын дунд илүүтэй байв. Энэ нь Бигэр суманд хувиараа алт олборлох ажил бусад аймаг, сумуудыг бодвол харьцангуй сүүлд эхэлсэнтэй холбоотойгоор тайлбарлагдаж болох юм.

Алт олборлогчийн өрх дэх насанд хүрээгүй буюу 0-16 насны хүүхдийн тоо олон байх тусам тухайн хүмүүсийн хувиараа алт олборлох ажлыг хийсэн хугацаа урт байна. Тухайлбал, 3 сар буюу түүнээс дээш хугацаагаар хувиараа алт олборлох ажлыг хийсэн хүмүүсийн хувийн жин насанд хүрээгүй 3-6 хүүхэдтэй өрхийн хүмүүсийн хувьд 66.7 хувь байгаа нь хүүхэдгүй өрхийн алт олборлогчдынхоос 11.5 пунктээр, 1хүүхэдтэй өрхийн алт олборлогчдынхоос 6.4 пунктээр, 2 хүүхэдтэй өрхийн алт олборлогчдынхоос 3.9 пунктээр тус тус өндөр байлаа. Мөн ядуу өрхийн алт олборлогчдын алт олборлох ажлыг удаан хийсэн байдал (65.6 хувь) нь ядуу бус өрхийн алт олборлогчийнхоос 15.6 пунктээр илүү байна. Эдгээр баримтууд нь орон нутгуудад ажлын байр дутагдалтай нөхцөлд орлого бага болон орлогын эх үүсвэр цөөтэй, олон хүүхэдтэй, ядуу айлууд ам бүлээ тэжээхийн тулд албан бусаар алт олборлох ажилд илүүтэй оролцох болсныг баталж байна.

Судалгаанд хамрагдсан ХАМО нараас тухайн газарт яагаад алт олборлох болсон шалтгааныг асууж, үр дүнг Зураг 4.1-д харуулав. Судалгаанд хамрагдагчдын хувиараа алт олборлох болсон шалтгаанууд дотор өрхдөө нэмэлт орлого олох (50.0 хувь), өөр ажил олдохгүй байсан (43.0 хувь), амьжиргаагаа залгуулах (42.7 хувь) зэрэг хүмүүсийн амьдралын наад захын хэрэгцээ, ядууралтай шууд холбоотой шалтгаанууд хамгийн өндөр хувь эзэлж байна. Эдгээрээс гадна сүүлийн жилүүдэд гар дээрээ бэлэн мөнгө багатай байдаг хөдөөгийн хүмүүсийн амьжиргаанд мэдэгдэхүйцээр нөлөө үзүүлэх болсон их, дээд сургуулийн хүүхдүүдийн сургалтын төлбөр (15.7 хувь), банкны болон бусад өр зээлийн дарамтууд (14.7 хувь) нь мөн хүмүүсийг албан бусаар алт олборлох ажил руу түлхэх болсон нь харагдаж байна. ХАМО нарын өгсөн эдгээр мэдээлэл нь орон нутгийн банкны ажилтнуудтай ярилцаж, мэдээлэл цуглуулах үед мөн батлагдсан юм.



* Хариулт олон сонголттой тул хувийн жингийн нийлбэр 100%-аас илүү

4.2 Ажлын ачаалал

Бигэр сумын нутаг дэвсгэрт алт олборлож буй хүмүүсийн дийлэнх нь Сэрхийн нуруу орчмоор ажилладаг тухай нутгийн засаг захиргааны ажилтнууд мэдээлсэн ба энэхүү судалгаанд хамрагдагчид мөн Сэрхийн нурууг тойрсон алтны гарц бүхий Гангат, Улаанчулуут, Дөрөлж, Олонбулаг, Зост зэрэг амуудад ажиллаж буй хүмүүс байв. Судалгаанд хамрагдсан бүх хүмүүс тэдгээр газруудад алт олборлох албан ёсны зөвшөөрөл авалгүйгээр ажиллаж байгаагаа хүлээн зөвшөөрсөн.

Бигэр суманд ажиллаж буй ХАМО нарын алт олборлох ажлын ачааллыг харуулах гол үзүүлэлтүүдийг Хүснэгт 4.2-т харууллаа. Судалгаанд хамрагдагчдын дийлэнх нь намар, зуны дулаан улирлуудад алт олборлох ажил хийдэг хүмүүс байна. Ялангуяа намрын улиралд ажилладаг гэж хариулагчид нийт алт олборлогчдын 88.0 хувийг эзэлж байгаа нь Бигэр суманд хувиараа алт олборлох ажил 2009 оны 7, 8 сараас идэвхжиж, олон тооны хүмүүсийг хамрах болсонтой холбоотой болов уу. Хүйсээр нь авч үзэхэд, энэ хандлагад онцын ялгаа байхгүй байгаа (намар ажилладаг эрэгтэйчүүд 88.7 хувь, эмэгтэйчүүд 85.7 хувь) боловч өвөл, хаврын улиралд алт олборлох ажилд оролцдог эмэгтэйчүүдийн хувь (тус тус 8.6 хувь) адил эрэгтэйчүүдийнхээс бараг хоёр дахин цөөн байна.

Судалгаанд хамрагдагчдын 57.0 хувь нь өнгөрсөн жилийн зөвхөн нэг л улиралд хувиараа алт олборлох ажил хийсэн хүмүүс байсан ба 2-3 улиралд ажиллагчид 32.7 хувь, жилийн бүх улиралд ажиллагчид 10.3 хувийг тус тус эзэлж байв. Олон буюу жилийн 4 улиралд ажилласан эрэгтэйчүүдийн хувь (11.7 хувь) эмэгтэйчүүдийнхээс 2 дахин өндөр байгаа нь эрэгтэйчүүд эмэгтэйчүүдийг бодвол илүүтэйгээр хувиараа алт олборлох ажлыг байгаль, цаг уурын нөхцөл харгалзахгүйгээр, удаан хугацаагаар хийдэг болохыг харуулж байна.

Алт олборлогчдын улирал тус бүрд ажилладаг хоногуудыг нийлүүлэн, жилийн яг хэдэн хоногт хувиараа алт олборлох ажил хийдгийг авч үзэхэд судалгаанд хамрагдсан эрэгтэйчүүд дунджаар 64-65 хоног, эмэгтэйчүүд дунджаар 52-53 хоног ажилладаг гэж гарлаа. Гэхдээ судалгаанд хамрагдагчдын жилийн ажлын хоног нэлээд хэлбэлзэл ихтэй байсан ба эрэгтэйчүүдийн хувьд хамгийн олондоо 286 хоног, хамгийн цөөндөө 4-5 хоног,

эмэгтэйчүүдийн хувьд хамгийн олондоо жилд 256 хоног, хамгийн цөөндөө 4-5 хоног ажиллах тохиолдлууд байсныг дурьдах нь зүйтэй.

Хүснэгт 4.2 Судалгаанд хамрагдагчдын хувийн жин, алт олборлох ажлын ачаалал, хүйсээр

Алт олборлох ажлын ачаалал	Хүйс		Нийт алт олборлогчид
	эрэгтэй	эмэгтэй	
Хувиараа алт олборлодог улирал*			
Өвөл	18.3	8.6	16.0
Хавар	14.8	8.6	13.3
Зун	48.7	47.1	48.3
Намар	88.7	85.7	88.0
Жилд хувиараа алт олборлосон улирлын тоо			
1 улирал	55.2	62.9	57.0
2-3 улирал	33.1	31.4	32.7
4 улирал	11.7	5.7	10.3
Жилд хувиараа алт олборлосон хоног			
25 хүртэл хоног	32.6	34.3	33.0
26-61 хоног	30.9	37.1	32.3
62, түүнээс олон хоног	36.5	28.6	34.7
<i>1 алт олборлогчийн өнгөрсөн жилд алт олборлосон дундаж хоног</i>	64.4	52.2	61.5
<i>Жилд ажилласан хамгийн цөөн хоног</i>	4.3	4.3	4.3
<i>Жилд ажилласан хамгийн олон хоног</i>	286.0	255.7	286.0
Ажлын нэг хоногт ажилладаг цаг			
Өвөл: ажиллаагүй	81.7	91.4	84.0
1-8 цаг	11.7	7.1	10.7
9 ба түүнээс дээш	6.6	1.5	5.3
<i>Өвөл ажиллагчдын хоногт ажилладаг дундаж цаг</i>	7.7	7.3	7.6
Хавар: ажиллаагүй	85.2	91.4	86.7
1-8 цаг	5.2	1.4	4.3
9 ба түүнээс дээш	9.6	7.2	9.0
<i>Хавар ажиллагчдын хоногт ажилладаг дундаж цаг</i>	9.7	10.7	9.8
Зун: ажиллаагүй	51.3	52.8	51.7
1-8 цаг	6.1	2.9	5.3
9 ба түүнээс дээш	42.6	44.3	43.0
<i>Зун ажиллагчдын хоногт ажилладаг дундаж цаг</i>	12.7	12.2	12.6
Намар: ажиллаагүй	11.3	14.2	12.0
1-8 цаг	13.5	12.9	13.3
9 ба түүнээс дээш	75.2	72.9	74.7
<i>Намар ажиллагчдын хоногт ажилладаг дундаж цаг</i>	12.1	12.5	12.2
Бүгд	100.0	100.0	100.0
ХАМО нарын тоо	230	70	300

* Хариулт олон сонголттой тул хувийн жингийн нийлбэр 100%-аас илүү

Ажлын ачааллын үзүүлэлтийг нарийвчлан, хувиараа алт олборлогчид ажлын нэг хоногт хэдэн цаг ажилладгийг улирал тус бүрээр ялгаж харвал нэлээд ялгаатай дүр зураг харагдаж байна. Тухайлбал, өвөл алт олборлогчид хоногт дунджаар 7.6 цаг ажилладаг нь бусад улирлуудад ажиллагчдын хоногийн ажлын цагууд (хавар 9.8 цаг, зун 12.6 цаг, намар 12.2 цаг)-аас хамгийн богино байна. Түүнчлэн өвлөөс бусад бүх улирлуудад хоногт 9 ба түүнээс дээш цаг ажиллаж байгаа хүмүүсийн хувь (хавар 9.0 хувь, зун 43.0 хувь, намар 74.7 хувь) 8 хүртэлх цаг ажилладаг хүмүүсийнхээс 2.1-8.1 дахин их байгаа нь ХАМО нар орлого олохын тулд МУ-ын Хөдөлмөрийн тухай хуулинд заагдсан хоногийн ажлын цагийн заалттай холбоотой эрхээ үл хамааран олон цагаар ажилладгийг харуулж байна.

Ийнхүү Хөдөлмөрийн тухай хуулинд заагдсан эрхээ эдэлж чадахгүй байгаа байдал эмэгтэйчүүдийн хувьд эрэгтэйчүүдийнхээс бүр илүү байна. Тухайлбал, хавар хоногт 9

цагаас дээш цагаар ажилладаг эмэгтэйчүүдийн хувь 8 хүртэл цаг ажилладаг эмэгтэйчүүдийнхээс 5.1 дахин их байхад эрэгтэйчүүдийн хувьд энэ зөрүү 1.8 дахин, зун олон цаг ажилладаг эмэгтэйчүүдийн хувь цөөн цаг ажилладагаасаа 15.3 дахин их байхад, эрэгтэйчүүдийн ийм үзүүлэлт 7.0 дахин зөрүүтэй байна. Эдгээрээс харахад хувиараа алт олборлогчид нь хэдийгээр хууль бус үйл ажиллагаа явуулж байгаа ч нөгөө өнцгөөс нь харахад өрх, ам бүлээ тэжээхийн тулд олон цагаар хүнд хүчир хөдөлмөр хийж орлого олон амь зууж байгаа нь харагдаж байна.

Хүснэгт 4.3-т судалгаанд оролцогчдын хувиараа алт олборлодог дундаж хоногийн үзүүлэлтийг улирал болон хариулагчийн шинж байдлаар нь задлан харуулав.

Хүснэгт 4.3 Тухайн улиралд ажилладаг судалгаанд хамрагдагчдын хувиараа алт олборлодог дундаж хоног, улирал ба алт олборлогчийн шинж байдлаар

Алт олборлогчийн шинж байдал	Улирал			
	Өвөл	Хавар	Зун	Намар
Насны бүлэг				
18-30	20.2	34.7	42.6	34.3
31-40	27.3	42.9	40.6	39.1
41-60	27.9	63.9	41.5	32.4
Хүйс				
Эрэгтэй	26.5	41.4	42.7	36.7
Эмэгтэй	19.5	67.2	37.4	31.6
Шилжих хөдөлгөөний байдал				
Явуулын	25.6	46.0	58.5	55.4
Суурин	26.0	41.2	28.8	28.7
Өрхийн амьжиргааны түвшин				
Ядуу	25.0	48.8	41.3	35.6
Ядуу бус	26.4	40.9	41.9	35.5
Тухайн улиралд ажилладаг нийт ХАМО нарын дунджаар*	25.6	45.3	41.5	35.6
Тухайн улиралд ажилладаг ХАМО нарын тоо	48	40	145	264

* судалгаанд хамрагдсан ХАМО нарын өнгөрсөн жилд алт олборлосон нийт хоногийн тоо 61.5 хоног (Хүснэгт 4.1) гэж гарсан ба энэ нь улирал тус бүрт ажилласан дундаж хоногийн тооны нийлбэртэй тэнцэхгүй. Учир нь зарим ХАМО жилийн зөвхөн нэг улиралд ажилласан байхад зарим нь 1-ээс олон улиралд ажилласан.

Өвлийн улиралд алт олборлогчид улирлын туршид нийтдээ дунджаар 25-26 хоног ажилладаг гэсэн бөгөөд ахимаг насны хүмүүсийн ажлын дундаж хоног (27.9 хоног) нь залуу хүмүүсийнхээсээ 0.6-7.7 хоногоор илүү, эрэгтэйчүүдийнх (26.5 хоног) нь эмэгтэйчүүдийнхээс 7 хоногоор илүү, суурин хүмүүсийнх (26.0 хоног) нь явуулын хүмүүсийнхээс 0.4 хоногоор тус тус илүү байв. Дулааны улирлуудыг авч үзвэл ХАМО нарын ажилласан нийт хоногийн тоо (хавар 45.3 хоног, Зун 41.5 хоног, намар 35.6 хоног) өвөл ажиллагчдынхаас 10-20 хоногоор урт байна.

Судалгаанд хамрагдсан ХАМО нар алт олборлохдоо голдуу хийдэг ажлыг хүйсээр нь ялган Хүснэгт 4.4-т харуулав. Судалгаанд хамрагдсан нийт ХАМО нарын алт олборлохдоо хамгийн түгээмэл хийдэг ажлууд нь шороо зөөх, шигших (76.3 хувь), нүх ухах (68.0 хувь), нүхнээс сул шороо өргөж гаргах (48.0 хувь), шороо хүрздэж өгөх (34.7 хувь) зэрэг хүнд хүчир ажлууд байв. Говь-Алтай аймгийн Бигэр суман дахь хувиараа алт олборлогчдын ажиллаж буй газар нь алтны шороон ордын төрөлд хамаарах бөгөөд дээрх ажлууд нь бүгд тоосжилт, агааргүйдэлт их нөхцөлд хийгддэг зэрэг шороон орд дахь хөдөлмөрийн хамгийн

хүнд нөхцөлтэй ажлууд юм. ХАМО нарын хамгийн түгээмэл хийдэг эдгээр 4 гол ажлыг эрэгтэйчүүд, эмэгтэйчүүд хэрхэн ялгаатайгаар хийж байгааг харахад, шороо зөөх, шигших ажил хийдэг эмэгтэйчүүдийн хувь 81.4 хувь байгаа нь эрэгтэйчүүдийнхээс 6.6 пунктээр өндөр, бусад 3 ажлын хувьд эрэгтэйчүүд нь эмэгтэйчүүдээсээ илүүгээр хийдэг ажлууд байв. Дээрхээс бусад хийдэг ажлуудыг хамруулан ерөнхийд нь харахад, алт олборлох үед хийгддэг шороо зөөх, шигшихээс бусад үндсэн, хүч шаардсан ажлуудыг эрэгтэйчүүд голдуу үүрч, эмэгтэйчүүд нь “туслах” хэлбэрийн ажлуудад тулхүү оролцдог нь харагдлаа.

Хүснэгт 4.4 Судалгаанд хамрагдагчдын хувь, алт олборлохдоо голдуу хийдэг ажил, хүйсээр

Алт олборлоход голдуу хийдэг ажил	Хүйс		Нийт алт олборлогчид
	эрэгтэй	эмэгтэй	
Шороо зөөх, шигших	74.8	81.4	76.3
Нүх ухах	73.9	48.6	68.0
Нүхнээс сул шороо өргөж гаргах	53.0	31.4	48.0
Шороо хүрдэж өгөх	40.9	14.3	34.7
Алт угаах/резиндэх	35.7	22.9	32.7
Ус зөөх	32.2	17.1	28.7
Чулуу бутлах, хайраглах	12.2	1.4	9.7
Шороо буудуудах мотор ажиллуулах	1.7	8.6	3.3
Мэдрэгч барих	1.7	2.9	2.0
ХАМО нарын тоо	230	70	300

* Хариулт олон сонголттой тул хувийн жингийн нийлбэр 100%-аас илүү

Хувиараа алт олборлоход хийгддэг дээрх ажлуудаас хамгийн хэцүү гэж үзэж буй ажлыг нь нэрлүүлэхэд (Зураг 4.2) судалгаанд хамрагдагчид нүх ухах ажлыг хамгийн хүнд гэж хэлсэн (эрэгтэйчүүдийн 77.8 хувь, эмэгтэйчүүдийн 67.1 хувь) байна. Үүний дараа шороо зөөх, шигших (эрэгтэйчүүдийн 8.3 хувь, эмэгтэйчүүдийн 15.7 хувь), нүхнээс сул шороо өргөж гаргах (эрэгтэйчүүдийн 7.8 хувь, эмэгтэйчүүдийн 11.4 хувь) зэрэг мөн л тоосжилт ихтэй, биеийн хүч ихээр шаардсан, эрүүл мэндэд үзүүлэх эрсдэл ихтэй ажлууд орж байна.



4.3 Ажлын нөхцөл

Хувиараа алт олборлогчид дээрх төрлийн ажлуудыг ямархуу хүнд нөхцөлд гүйцэтгэдгийг нарийвчлан гаргаж, Хүснэгт 4.5-д харуулав. Хувиараа алт олборлох ажлын хамгийн хүнд бэрхшээлтэй нөхцлүүдэд алт олборлогчид тоос ихтэй (72.0 хувь), ил задгай гадаа ажилладаг (55.0 хувь), байгаль, цаг агаарын хэт халуун, хүйтэн үе, эсвэл ширүүн бороо, цас, шороон шуурга тааралдах (49.3 хувь) зэрэг нөхцлүүдийг хамгийн түгээмэл нэрлэсэн байна. Дээрх нөхцлүүдээс гадна ажлын багаж хэрэгсэл хангалтгүй байх нь тэдэнд ажлын хүнд нөхцөлд орж байгаа бөгөөд, хувиараа алт олборлолт явагдаж буй орчинд ариун цэвэр муу, дуу чимээ зөвшөөрөгдөх хэмжээнээс их, осол аваар их гардаг, харанхуй, гэрэлтүүлэг муу, давчуу зайтай, агааржуулалтгүй орчинд ажилладаг зэрэг олон нөхцлүүд хувиараа алт олборлогчдын хувьд ажлын хүнд бэрхшээлтэй нөхцөлд орж байна.

Хүснэгт 4.5 Судалгаанд хамрагдагчдын хувь, алт олборлох ажлын хүнд бэрхшээлтэй нөхцлүүдийг нэрлэсэн байдал, хүйсээр

Ажлын хүнд, бэрхшээлтэй нөхцөл	Хүйс		Нийт алт олборлогчид
	эрэгтэй	эмэгтэй	
Тоос ихтэй	74.3	64.3	72.0
Ихэвчлэн гадаа ажилладаг	57.4	47.1	55.0
Хэт халуун, хүйтэн, ширүүн бороо, цас, шороон шуурга	47.8	54.3	49.3
Багаж хэрэгсэл хангалтгүй	45.2	28.6	41.3
Ариун цэвэр муу	44.8	20.0	39.0
Дуу чимээ ихтэй	37.0	38.6	37.3
Осол, аваарь ихтэй	33.5	14.3	29.0
Харанхуй, гэрэлтүүлэг муу	33.0	11.4	28.0
Давчуу зай, нүхэнд ажилладаг	24.8	4.3	20.0
Агааржуулалтгүй	20.0	2.9	16.0
Бусад алт олборлогчид шахаж дарамталдаг	16.5	1.4	13.0
Чийглэг ихтэй	9.6	4.3	8.3
Хяналтын байгууллагын ажилтнуудад хөөгдөх	2.2	1.4	2.0
ХАМО нарын тоо	230	70	300

* Хариулт олон сонголттой тул хувийн жингийн нийлбэр 100%-аас илүү

Ажлын хүнд, бэрхшээлтэй нөхцлүүдийг нэрлэсэн байдалд хүйсийн ялгаа байгаа эсэхийг харахад, эмэгтэйчүүдийн хувьд эрэгтэйчүүдээсээ илүүтэйгээр хүнд гэж үзэж буй нөхцлүүд нь цаг агаарын хэт халуун, хүйтэн, ширүүн бороо, цас, шороон шуурга (54.3 хувь), дуу чимээ их (38.6 хувь) гэсэн нөхцлүүд байгаа ба бусад бүх хүнд нөхцлийг эрэгтэйчүүд эмэгтэйчүүдээс илүүтэйгээр нэрлэсэн байна.

Тоон судалгааны мэдээллээс, нүхэнд/газар доор ажилладаг ХАМО нар өдөрт дунджаар 6.3 цаг буюу 6-7 цаг нүхэнд олборлолтын аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн наад захын шаардлагууд бүрэн хангагдаагүй нөхцөлд (тухайлбал нүхний ам орчимд нуралт гулсалт үүсэхээс хамгаалсан найдвартай хамгаалалт бэхэлгээгүй, хувийн хамгаалах хэрэгсэл дутмаг гэх мэт) ажилладаг болох нь тогтоогдсон ба ярилцлага авах явцад бидэнтэй хоногт 12-14 цаг нүхэнд ажилладаг гэх тохиолдол 1 бус удаа тааралдаж байсан.

Бигэр суманд хувиараа алт олборлогчдын дунд харин бусад алт олборлох газруудад, ялангуяа алтны үндсэн орд бүхий газруудад байдаг алт олборлох ажиллагаандаа мөнгөн ус хэрэглэдэг тохиолдол байгаагүй нь сайшаалтай. Энэ нь нутгийн засаг захиргааны

ажилтнууд, байгаль орчны улсын байцаагч, цагдаа зэрэг хүмүүсээс авсан мэдээллээр мөн нотлогдсон болно.

Хувиараа алт олборлогчид алт олборлох ажиллагаандаа хөдөлмөрийн ямар багаж, хэрэгслүүдийг түгээмэл ашигладгийг өрхийн амьжиргааны түвшингээр ялган, Хүснэгт 4.6-д харуулав.

Хүснэгт 4.6 Судалгаанд хамрагдагчдын хувь, түгээмэл хэрэглэдэг хөдөлмөрийн багаж, хэрэгслийг нэрлэсэн байдал, өрхийн амьжиргааны түвшинээр

Хэрэглэдэг хөдөлмөрийн багаж, хэрэгсэл	Өрхийн амьжиргаа		Нийт алт олборлогчид
	Ядуу	Ядуу бус	
Хүрз	91.7	83.3	88.3
Түмпэн	60.0	53.3	57.3
Хувин	57.2	54.2	56.0
Жоотуу	50.6	55.0	52.3
Шигшүүр	56.1	45.8	52.0
Шуудай	46.7	37.5	43.0
Лоом	38.9	28.3	34.7
Хуурай угаагч/паажуур буюу паажгар	13.3	15.8	14.3
Сков	10.6	18.3	13.7
Мотор	12.8	12.5	12.7
Компрессор	7.2	3.3	5.7
Олс	3.3	0.8	2.3
Ус шавхагч (помп)	1.1	1.7	1.3
Усан буу	1.1	0.8	1.0
Шлюз	0.6	0.0	0.3
Бусад	10.0	9.2	9.7
ХАМО нарын тоо	180	120	300

* Хариулт олон сонголттой тул хувийн жингийн нийлбэр 100%-аас илүү

Алт олборлох ажиллагаандаа хэрэглэдэг хөдөлмөрийн багаж хэрэгслүүд нь хариулагчийн өрхийн амьжиргааны түвшингээр төдийлөн ялгаагүй байна. Хамгийн өргөн хэрэглэгддэг багаж хэрэгслүүдэд алт олборлогчид хүрз (88.3 хувь), түмпэн (57.3 хувь), хувин (56.0 хувь), жоотуу (52.3 хувь), шигшүүр (52.0 хувь), шуудай (43.0 хувь), лоом (34.7 хувь) зэргийг оруулсан байгаа нь тэдний хамгийн их хийдэг ажлуудтай шууд холбоотой байна.

Эдгээр хамгийн өргөн хэрэглэгддэг багаж хэрэгслүүд нь хэдийгээр хөдөлмөр хөнгөвчлөх боловч механикжуулсан хөдөлмөр хөнгөвчлөх хэрэгслүүд биш, гар ажиллагааных учраас алт олборлогчдын хөдөлмөрийн бүтээмжид төдийлөн дорвитой нөлөө үзүүлж чаддаггүй болов уу. Хувиараа алт олборлогчдын хэрэглэдэг багаж, хэрэгслүүд дотор техникийн дэвшилтэй, механикжуулсан багаж хэрэгсэл харьцангуй цөөн, мотор, компрессор, ус шавхагч помп гэх мэт зарим нэг хагас механикжуулсан хэрэгслүүд л цөөн тоогоор хэрэглэгдэж байгаа нь алт олборлогчдын тухайн багаж хэрэгслийг олж авах санхүүгийн боломж нөөц хязгаарлагдмал, эсвэл тохирох зориулалтын, техникийн дэвшилтэт хэрэгслүүд зах зээлд ховор байдагтай холбоотой болов уу.

4.4 Хөдөлмөр хамгаалал

Алт олборлох ажиллагааны үед хийгддэг бүх ажлууд нь хөдөлмөр хамгааллын нарийн дэглэм, зааврыг дагаж байж ажил гүйцэтгэгчийн эрүүл мэндэд сөрөг нөлөө бага үзүүлнэ. Ялангуяа хувиараа алт олборлож буй үед үйлдвэрлэлийн аюулгүй ажиллагааны дүрэм, зааврыг мэддэг байх, мөрдөж ажиллах, тохирох хөдөлмөр хамгааллын хувцас, хэрэгслүүдийг бүрэн зөв хэрэглэхгүй бол осол аваарьт өртөх, эрүүл мэндээрээ хохирох явдал элбэг тохиолдох эрсдэлтэй.

Бигэр суманд алт олборлож буй судалгаанд хамрагдсан иргэдээс ажиллах үеийн аюулгүй ажиллагааны талаарх мэдлэгийг зохих сургалтад хамрагдан авсан эсэхийг асуусан ба үр дүнг Хүснэгт 4.7-д харууллаа.

Хүснэгт 4.7 Судалгаанд хамрагдагчдын хувийн жин, үйлдвэрлэлийн аюулгүй ажиллагааны арга барил эзэмшүүлэх сургалтад хамрагдаж байсан эсэх, хариулагчийн шинж байдлаар

Алт олборлогчийн шинж байдал	үйлдвэрлэлийн аюулгүй ажиллагааны арга барил эзэмшүүлэх талаар мэдээлэл авч байсан эсэх		Бүгд	ХАМО нарын тоо
	тийм	үгүй		
Насны бүлэг				
18-30	2.3	97.7	100.0	88
31-40	5.3	94.7	100.0	114
41-60	6.1	93.9	100.0	98
Хүйс				
Эрэгтэй	3.0	97.0	100.0	230
Эмэгтэй	10.0	90.0	100.0	70
Шилжих хөдөлгөөний байдал				
Явуулын	4.8	95.2	100.0	83
Суурин	4.6	95.4	100.0	217
Нийт алт олборлогчид	4.7	95.3	100.0	300

Судалгаанд хамрагдсан хувиараа алт олборлож буй нийт иргэдийн зөвхөн 4.7 хувь буюу 14 иргэн урьд нь ямар нэг байдлаар үйлдвэрлэлийн аюулгүй ажиллагааны арга барилын талаар мэдээлэл авч, сонсож байсан гэж хариулж байсан бөгөөд хаанаас уг мэдээлэлийг авсныг тодруулахад хамаатан/найзуудаас (9 тохиолдол), өмнө ажиллаж байсан уул уурхайн компаниас (5 тохиолдол) зэрэг хариултыг өгчээ.

Дээрх төрлийн мэдлэг, мэдээлэл авсан хүмүүсийн хувь 40-өөс дээш насны, эмэгтэй, явуулын ХАМО нарын дунд бусад ХАМО нарынхаас өндөр байна.

Судалгаанд хамрагдсан ХАМО нарын алт олборлохдоо хэрэглэдэг хөдөлмөр хамгааллын хувцас, хэрэгслүүдийг өрхийн амьжиргаагаар ялган Хүснэгт 4.8-д үзүүлэв. Хүснэгтэд бичсэн хувцас, хэрэгслүүдийн дийлэнх нь уурхайд ажиллах үеийн аюулгүй ажиллагаа ба эрүүл ахуйтай холбоотой албан ёсны стандартад заагдсан хувцас, хэрэгслүүд бөгөөд эдгээрийг хэрэглэдэг эсэхийг ярилцагчаас нэг бүрээр нь дурьдаж асуусан болно.

Хүснэгт 4.8 Судалгаанд хамрагдагчдын хувь, хэрэглэдэг хөдөлмөр хамгааллын хувцас хэрэгслийг нэрлэсэн байдал, өрхийн амьжиргааны түвшингээр

Алт олборлоход хэрэглэдэг хөдөлмөр хамгааллын хувцас, хэрэгслүүд	Өрхийн амьжиргаа		Нийт алт олборлогчид
	Ядуу	Ядуу бус	
Бээлий	99.4	96.7	98.3
Маск	80.0	79.2	79.7
Гар чийдэн/духны гэрэл	35.0	23.3	30.3
Каск	10.0	10.0	10.0
Ханцуйвч	11.1	6.7	9.3
Ажлын энгийн комбинзон	5.0	12.5	8.0
Хамгаалах нүдний шил	11.1	1.7	7.3
Хошуувч	5.0	1.7	3.7
Бэхлэгч бүс	4.4	1.7	3.3
Бэхэлгээний оле	3.3	3.3	3.3
Ажлын гутал	5.0	0.8	3.3
Чихний хамгаалалт	1.1	0.8	1.0
Хормогч	0.6	0.0	0.3
Усны комбинзон	0.0	0.0	0.0
Агааржуулагч	0.0	0.0	0.0
Бусад	2.2	0.8	1.7
ХАМО нарын тоо	180	120	300

* Хариулт олон сонголттой тул хувийн жингийн нийлбэр 100%-аас илүү

Хөдөлмөр хамгааллын хувцас, хэрэгслүүдээс боломжийн хэмжээнд буюу өндөр хувьтайгаар хэрэглэгддэг нь бээлий (98.3 хувь), нүүрний маск (79.7 хувь) төдийгөөр хязгаарлагдаж байна. Дээрх хоёроос гадна духны гэрэл юмуу гар чийдэнг алт олборлогчдын 30.3 хувь, каск буюу хамгаалалтын малгайг 10.0 хувь нь тус тус тогтмол хэрэглэдэг гэдгийг эс тооцвол, бусад бүх төрлийн хөдөлмөр хамгааллын хувцас хэрэгслүүдийг хэрэглэдэг байдал 10 хувьд ч хүрэхгүй байна. Ялангуяа Бигэр дэх шороон орд бүхий газарт алт олборлогчид ажлын хамгийн хүнд нөхцлөө “тоосжилт ихтэй” гэж тодорхойлсон хэдий ч түүнээс өөрсдийгөө хамгаалахын тулд маск төдийхөн зүйл хэрэглэн, бусад хэрэгслийг, тухайлбал, хамгаалах нүдний шил, хошуувч зэргийг хангалттай тоогоор хэрэглэж чаддаггүй байна.

Судалгаанд хамрагдагчдын хэрэглэж байгаа хөдөлмөр хамгааллын гол хувцас, хэрэгслүүдийн хэрэглээнд өрхийн амьжиргааны түвшин онцын нөлөөгүй буюу ядуу, ядуу бус өрхийн алт олборлогчид ойролцоо хэрэглээтэй байна. Өрхийн амьжиргааны түвшингээр мэдэгдэхүйц ялгаатай байгаа хувцас, хэрэгслүүд нь ажлын энгийн комбинзон ядуу бус өрхийн алт олборлогчид ядуу өрхийнхөөс илүү хэрэглээтэй), нүдний шил (ядуу өрхийн алт олборлогчид ядуу бус өрхийнхөөс илүү хэрэглээтэй) зэрэг байв.

ХАМО нараас алт олборлоход хэрэглэдэг хамгийн хэрэгцээтэй хувцас хэрэгслийг нь асуухад (Зураг 4.3) ядуу өрхийн алт олборлогчид ажлын комбинзон (32.3 хувь)-ийг хамгийн их, дараа нь нүүрний маск (24.4 хувь), бээлийг (23.3 хувь) нэрлэсэн бол ядуу бус өрхийн алт олборлогчид бээлий (42.5 хувь), комбинзон (21.6 хувь), нүүрний маск (20.0 хувь) зэргийг хамгийн ихээр нэрлэсэн байна.



Судалгаанд хамрагдсан ХАМО нарын хөдөлмөр хамгааллын хувцас, хэрэгслийн хэрэглээ ийнхүү хангалтгүй байгаа нь юутай холбоотой болохыг тодруулах үүднээс тэднээс хөдөлмөр хамгааллын хувцас, хэрэгсэл олох, ашиглахтай холбоотой ямар хүндрэл байдгийг асуусан ба үр дүнг Хүснэгт 4.9-д харуулав.

Хүснэгт 4.9 Судалгаанд хамрагдагчдын хувь, хөдөлмөр хамгааллын хувцас хэрэгсэл олох, ашиглахтай холбоотой хүндрэлийг нэрлэсэн байдал, өрхийн амьжиргааны түвшингээр

Хөдөлмөр хамгааллын хувцас хэрэгсэл олох, ашиглахтай холбоотой хүндрэл	Өрхийн амьжиргаа		Нийт алт олборлогчид
	Ядуу	Ядуу бус	
Хүндрэл гардаггүй	7.8	18.3	12.0
Хүндрэл гардаг:	(92.2)	(81.7)	(88.0)
Зориулалтын ямар хувцас, хэрэгсэл байдгийг мэдэхгүй	49.4	49.2	49.3
Хаанаас олж авахаа мэддэггүй	46.7	23.3	37.3
Олдоц муу/олддоггүй	21.7	23.3	22.3
Үнэ өндөр	19.4	10.8	16.0
Зориулалтаар нь хэрэглэж мэддэггүй	12.8	15.8	14.0
ХАМО нарын тоо	180	120	300

* Хариулт олон сонголттой тул хувийн жингийн нийлбэр 100%-аас илүү

Бигэр суманд хувиараа алт олборлож буй нийт иргэдийн 88 хувь нь хөдөлмөр хамгааллын хувцас хэрэгсэл олох, ашиглахад ямар нэг бэрхшээл гардаг гэж хариулсан ба хамгийн их тохиолддог бэрхшээл нь зориулалтын ямар хувцас хэрэгсэл байдгийг мэддэггүй (49.3 хувь), хаанаас олж авахаа мэддэггүй (37.3 хувь), олдоц муу (22.3 хувь) явдал гэжээ. Эдгээр бэрхшээлийг өрхийн амьжиргааны түвшингээр нь ялган харвал ядуу өрхийн алт олборлогчдын хүндрэл тохиолддог гэж хариулсан хувь (92.2 хувь) ядуу бус өрхийнхөөс 10 гаруй пунктээр илүү байв. Ядуу бус өрхийн алт олборлогчтой харьцуулахад ядуу өрхийн

алт олборлогчдод илүүтэй тохиолддог бэрхшээлүүд нь хувцас, хэрэгслийг хаанаас олж авахаа мэддэггүй (46.7 хувь), эсвэл үнэ өндөр (19.4) зэрэг байна.

Дээрхээс харахад ХАМО нарт хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны арга барил эзэмшүүлэх, хөдөлмөр хамгааллын хувцас хэрэгслийг таниулах, хэрэглүүлж сургах сургалтууд, мөн хувийн хөдөлмөр хамгааллын хувцас, хэрэгслийг нийлүүлдэг тохиромжтой эх үүсвэр нэн шаардлагатай байгаа нь харагдаж байна.

БҮЛЭГ 5. ХУВИАРАА АЛТ ОЛБОРЛОГЧДЫН ҮЙЛДВЭРЛЭЛ, ОРЛОГО, ЗАРЛАГА

Монголын эдийн засгийн албан сектор дахь ажлын байрны нийлүүлэлт нь хөдөлмөрийн зах зээл дэх ажиллах хүчнийг ажлын байраар бүрэн хангахад хангалтгүй, түүнчлэн ядуурлын түвшин дорвитой буурахгүй байгаа энэ цаг үед олон хүмүүс эдийн засгийн албан бус салбарт үйл ажиллагаа явуулж орлого олон, амьжиргаагаа залгуулж байгаа иргэдийн нэг хэсэг нь хувиараа алт олборлогчид билээ. Энэхүү судалгааны гол зорилтуудын нэг нь хувиараа алт олборлогчдын үйлдвэрлэл, орлого, зарлагын байдлыг нарийвчлан судалж, хувиараа алт олборлолт нь хувь хүн, өрх, цаашилбал орон нутаг болон улсын эдийн засагт ямар хувь нэмэр оруулж байгааг тодорхойлох явдал байсан. Иймд, энэхүү бүлэгт Бигэр суманд хувиараа алт олборлогчдын үйлдвэрлэл, орлого, зарлагын байдлыг дэлгэрэнгүй авч үзэх болно.

5.1 Алт олборлолтын хэмжээ ба орлого

Судалгаанд хамрагдсан хувиараа алт олборлогчдын хөдөлмөрийн бүтээмж буюу ажлын хоногт олборлодог алтны хэмжээний талаарх мэдээллийг хариулагчдын шинж байдлаар задлан Хүснэгт 5.1-д үзүүлэв.

Хүснэгт 5.1 Судалгаанд хамрагдагчдын хувийн жин, ажлын ердийн хоногт олборлодог алтны хэмжээ, хариулагчийн шинж байдлаар

Сонгосон үзүүлэлтүүд	Ажлын нэг хоногт олборлодог алтны хэмжээ (грамм)			Бүгд	ХАМО нарын тоо
	0.143-0.667	0.667-1.000	1.001+		
Насны бүлэг					
18-30	25.0	31.8	43.2	100.0	88
31-40	31.6	37.7	30.7	100.0	114
41-60	43.8	28.6	27.6	100.0	98
Алт олборлосон хугацаа					
1-3 сар	31.8	35.2	33.0	100.0	179
4, түүнээс олон сар	36.3	29.8	33.9	100.0	121
Хүйс					
Эрэгтэй	33.0	32.7	34.3	100.0	230
Эмэгтэй	35.7	34.3	30.0	100.0	70
Нийт алт олборлогчид	33.7	33.0	33.3	100.0	300

Хүснэгтээс харахад Бигэр суманд хувиараа алт олборлож буй иргэдийн гуравны хоёр нь ажлын нэг хоногт 1.0 граммаас доош хэмжээний алт олборлодог ба үлдсэн гуравны нэг хувь нь түүнээс дээш хэмжээний алт олборлодог хөдөлмөрийн бүтээмжтэй гэж гарчээ. Хариулагчийн шинж байдлаар нь ялган харвал, ажлын хоногт бага буюу 0.143-0.667 грамм алт олборлодог иргэд бусадтайгаа харьцуулахад ахимаг насны, алт олборлох ажил хийсэн туршлага багатай буюу нийтдээ 1-3 сарын турш л алт олборлох ажил хийж үзсэн хүмүүс байна. Харин хоногт их буюу 1.001 граммаас дээш хэмжээтэй алт олборлодог хүмүүс нь залуу, эрэгтэй, удаан хугацаанд алт олборлох ажил хийсэн туршлагатай хүмүүс байв.

Хувиараа алт олборлогчдын нэг хоногт олборлодог алтны хэмжээ ажилладаг улирлаасаа хамааран харилцан адилгүй байсан ба түүнээс шалтгаалан улирал, жилд олдог нийт алтны хэмжээ, алт олборлолтын орлогын хэмжээнүүд нь мөн хэлбэлзэлтэй байв.

Энэ талаарх дэлгэрэнгүй үр дүнг Хүснэгт 5.2-г харууллаа. Хүснэгтэд нэг алт олборлогчийн хөдөлмөрийн бүтээмж буюу хоног, сард олборлосон алтны дундаж хэмжээг *ажилласан нэг хоног эсвэл сард ногдох; улирал/жилийн ердийн нэг хоног эсвэл сард ногдох* гэсэн 2 хэлбэрээр тооцон үзүүлэв. ХАМО иргэний *ажилласан нэг хоногт олборлосон алтны дундаж хэмжээ*-г бид судалгааны асуулга дахь “Та ажлын нэг хоногт дунджаар хэдэн грамм алт олборлодог вэ?” гэсэн асуултын дагуу мэдээлэл цуглуулж гаргасан ба *улирал/жилийн ердийн нэг хоногт олборлосон алтны хэмжээ*-г тооцохдоо улирал/жилд олборлосон нийт алтны хэмжээг улирал болон жил дэх нийт хоногийн тоо (өвлийн 90 хоног, хаврын 92 хоног, зуны 92 хоног, намрын 92 хоног, жилийн 365 хоног)-нд харьцуулан; *улирал/жилийн ердийн нэг сард олборлосон алтны хэмжээ*-г тооцохдоо улирал/жилд олборлосон нийт алтны хэмжээг улирал болон жил дэх нийт саруудын тоо (улирал бүрт 3 сар, жилд 12 сар)-нд харьцуулан гаргасан.

Хүснэгт 5.2 Судалгаанд хамрагдагчдын олборлодог алтны дундаж хэмжээ ба алт олборлолтын дундаж орлого, улирал, жилээр

Тухайн улиралд ажилладаг нэг ХАМО-ийн олборлодог алтны дундаж хэмжээ ба алт олборлолтын дундаж орлого	Улирал				Жилийн дундаж (2009 оны 2-р сараас 2010 оны 2-р сарын хооронд ажилласан нийт хоногт)
	өвөл	хавар	зун	намар	
Хоногт олборлодог алтны дундаж хэмжээ (грамм)					
Ажилласан нэг хоногт	0.86	0.95	1.34	1.23	1.19¹
Улирал/жилийн ердийн нэг хоногт	0.23	0.44	0.60	0.48	0.20²
Сард олборлодог алтны дундаж хэмжээ (грамм)					
Ажилласан нэг сард	12.94	18.05	24.09	20.04	19.35¹
Улирал/жилийн ердийн нэг сард	7.0	13.64	18.46	14.46	6.15³
Улирал/жилд олборлосон нийт алтны дундаж хэмжээ (грамм)	21.11	40.93	55.38	43.37	73.8
Нэг грамм алтаа борлуулсан дундаж үнэ (төгрөг)	40 395.8	40 800.0	38 479.9	39 870.8	39 368.9*
Хоногт алт олборлолтоос олдог дундаж орлого (төгрөг)					
Ажилласан нэг хоногт	35 103.5	39 207.1	51 788.7	49 492.8	47 009.7⁴
Улирал/жилийн ердийн нэг хоногт	9 294.6	18 251.0	23 397.9	19 471.6	8 102.5²
Сард алт олборлолтоос олдог дундаж орлого (төгрөг)					
Ажилласан нэг сард	516 298.6	739 667.5	938 859.7	814 647.8	770 982.3⁴
Улирал/жилийн ердийн нэг сард	278 838.0	559 689.7	717 536.3	590 638.0	246 452.5³
Улирал/жилд алт олборлолтоос олсон нийт орлогын дундаж хэмжээ (төгрөг)	836 513.9	1 679 096.2	2 152 609.0	1 771 914.0	2 957 430.1
Тухайн улиралд ажилласан ХАМО нарын тоо	48	40	145	264	300

* олборлосон алтны хэмжээгээр жигнэсэн дундаж

¹ улирал бүрт ажилласан хоногийн тоогоор жигнэсэн дундаж

² жилийн 365 хоногт харьцуулсан дундаж

³ жилийн 12 сард харьцуулсан дундаж

⁴ улирал бүрт олборлосон алтны хэмжээгээр жигнэсэн дундаж

Хүснэгт 5.2-оос харахад Бигэр суманд хувиараа алт олборлож буй нэг иргэн ажилласан нэг хоногт дунджаар 1.19 грамм, ажилласан нэг сард дунджаар 19.35 грамм алт олборлосон ба

үүнийг жилийн ердийн нэг хоног, сард шилжүүлэн харвал тус тус хоногт 0.2 грамм, сард 6.15 грамм алт олборлодог гэсэн үр дүн гарчээ. Бигэрт ажиллаж буй ХАМО иргэдийн хоногийн болон сарын хөдөлмөрийн бүтээмж өвлийн улиралд хамгийн бага, харин зуны улиралд хамгийн өндөр байгаа ба үүнийгээ даган улирал, жилд олборлосон нийт алтны дундаж хэмжээ нь ч өвөл хамгийн бага (21.11 грамм), зуны улиралд хамгийн өндөр (55.38 грамм) байна. ХАМО нарыг ажлын нэг хоногт болон улирал/жилд олборлосон алтны хэмжээгээр нь бүлэглэн харвал (Хавсралт 5.1), дээрх дүгнэлтүүд мөн батлагдаж байв. Ийнхүү ХАМО нарын хөдөлмөрийн бүтээмж өвөл бага, зун их байгаа нь хувиараа алт олборлох ажил байгаль, цаг уурын нөхцлөөс ихээхэн хамаардаг болохыг харуулж байна.

Өнгөрсөн нэг жилийн хугацаанд ХАМО нарын 1 грамм алтаа борлуулсан дундаж үнийг авч үзвэл, жилийн дунджаар 39,368.9 төгрөг байсан ба тэдний алт борлуулсан ханш судалгааны мэдээлэл цуглуулах үеэс өмнөх 1 жилийн хугацаанд хаврын улиралд хамгийн өндөр буюу дунджаар 40800 төгрөг, харин зуны улиралд хамгийн доогуур буюу 38479.9 төгрөг байжээ.

Судалгаанд хамрагдсан ХАМО нарын *алт олборлолтоос олдог мөнгөн орлого*-ыг олборлосон алтны хэмжээ болон алтаа борлуулсан үнийн мэдээлэл дээр нь үндэслэн тооцож үзвэл, ажилласан нэг хоногт дунджаар 47,009.7 төгрөг, ажилласан нэг сард дунджаар 770,982.3 төгрөг байна. Үүнийг жилийн ердийн нэг хоног, сард шилжүүлэн харвал, хоногт дунджаар 8,102.5 төгрөг, сард дунджаар 246,452.5 төгрөгийн орлоготой байдаг нь харагдаж байна. Хоног, сард олсон орлогын хэмжээг улирлаар нь задлан харвал өвлийн улиралд хамгийн бага, зуны улиралд хамгийн их байв. Хэдийгээр алт олборлогчдын алт борлуулсан үнэ зун хамгийн хямд байсан ч ханшийн алдагдлыг хөдөлмөрийн өндөр бүтээмжээрээ нөхсөнөөр, тэдний зуны ажлын нэг хоног, сард олох орлого бусад улирлаас өндөр байдаг байна.

Ажлын нэг хоногт олдог орлого болон ажилласан хоногийн мэдээлэлд үндэслэн нэг алт олборлогчийн өнгөрсөн жилд ажилласан нийт хоногт олсон алт олборлолтын орлогыг тооцож үзвэл, дунджаар 2,957,430.1 төгрөг байна. Улирлаар нь харвал, ХАМО нарын улирлын турш олдог алтны нийт орлого өвөл хамгийн бага (дунджаар 836,513.9 төгрөг), зун хамгийн их (дунджаар 2,771,914.0 төгрөг) байна.

Бигэр сумын хувьд ХАМО нар ихээр цуглан алт олборлож байгаа бусад аймаг, нутгуудтай харьцуулахад алтны гарц хожуу илэрсэн ба тус газарт уул уурхайн компани, аж ахуйн нэгжүүд олборлолт хийж эхлээгүй байгаа тул алтны гарц их байгаа тухай нутгийн уугуул иргэд болон ХАМО нар ярьж байлаа.


5.2 Алт борлуулалт ба алдагдсан боломжийн өртөг

Хувиараа алт олборлогчдын зах зээл дээр ямархуу цар хүрээтэй эдийн засгийн үйл ажиллагаанууд явагдаж байгаа, түүнчлэн олборлосон алт хаана очиж байгаа зэргийг мэдэж болох нэг арга зам нь алт борлуулалтын системийг судлах явдал юм. Судалгаанд хамрагдсан ХАМО нараас ямар сувгаар алтаа борлуулдаг, тухайн сувгийг яагаад сонгож хэрэглэдэг зэргийг асуусан үр дүнг Хүснэгт 5.3 болон Зураг 5.1-д харуулав.

Хүснэгт 5.3 Судалгаанд хамрагдагчдын хувийн жин, алтаа борлуулдаг эх үүсвэр, сонгосон үзүүлэлтүүдээр

Сонгосон үзүүлэлтүүд	Алтаа борлуулдаг эх үүсвэр			Бүгд	ХАМО нарын тоо
	Явуулын ченжүүд	Нутгийн ченжүүд	Аймаг/хотын хувь хүн		
Насны бүлэг					
18-30	95.5	3.4	1.1	100.0	88
31-40	90.4	8.8	0.9	100.0	114
41-60	85.7	14.3	0.0	100.0	98
Хүйс					
Эрэгтэй	90.4	9.1	0.4	100.0	230
Эмэгтэй	90.0	8.6	1.4	100.0	70
Шилжилтийн байдал					
Явуулын	96.4	2.4	1.2	100.0	83
Суурин	88.0	11.5	0.5	100.0	217
Нийт алт олборлогчид	90.3	9.0	0.7	100.0	300

Судалгаанд хамрагдсан нийт хувиараа алт олборлогчдын ихэнх буюу 90.3 хувь нь олборлосон алтаа явуулын ченжүүдэд, 9.0 хувь нь нутгийн ченжүүдэд тушааж борлуулдаг гэсэн ба үлдсэн 0.7 хувь нь хот юмуу аймаг руу явж, алт авдаг хувь хүнд тушаадаг гэжээ. Хариулагчдын шинж байдлаар нь авч үзэхэд, нас ахимаг байх тусам явуулын ченжүүдэд алтаа тушаадаг алт олборлогчдын хувь багасаж, нутгийн ченжүүдэд тушаах хандлага нэмэгдэж байсан ба суурин хүмүүс мөн явуулын хүмүүсээс илүүтэйгээр нутгийнхаа ченжүүдэд алтаа тушаадаг хандлага байна. Гэсэн хэдий ч чанарын хувьд явуулынх байна уу, нутгийнх байна уу хамаагүй, алтны ченжүүд нь бүгд албан бус эх үүсвэр бөгөөд хувиараа алт олборлогчдын олборлосон алт 100 хувь албан бус, хэн нь тодорхойгүй эх үүсвэрүүд рүү урсдаг нь харагдаж байна.



*Хариулт олон сонголттой тул хувийн жингийн нийлбэр 100%-аас илүү

Албан ёсоор бол хүмүүс алтаа банкинд тушааж борлуулж болох боловч хөдөө орон нутгуудад ийм үйл ажиллагаа явуулдаг банкны салбар хомс, байсан ч хувиараа алт олборлогчид мэддэггүй, эсвэл алтаа албан бусаар үйл ажиллагаа явуулж олсон учраас борлуулахдаа албан эх үүсвэр рүү төдийлөн ханддаггүй бололтой. Чухам яагаад дээрх

албан бус эх үүсвэрт хандаж алтаа борлуулдаг талаарх өөрсдийнх нь хэлсэн шалтгааныг харвал (Зураг 5.1), суманд алт авдаг өөр эх үүсвэр байхгүй (явуулын ХАМО нарын 56.6 хувь, суурин ХАМО нарын 66.8 хувь), ченжүүд алтыг нь бусдаас өндөр үнээр авдаг (явуулын ХАМО нарын 42.2 хувь, суурин ХАМО нарын 26.3 хувь), ченжүүдэд тушаахад явдал чирэгдэл багатай (явуулын ХАМО нарын 30.1 хувь, суурин хариулагчдын 30.9 хувь) зэрэг шалтгаанууд өндөр хувь эзэлж байв. Алт борлуулах албан бус сувгийн давуу тал болж байгаа эдгээр нөхцлүүдийг өөр өнцгөөс нь харвал алт худалдан авдаг албан салбарт дутагддаг зүйлс гэж ойлгож болох юм.

Эцэст нь хэлэхэд, практикт, алт борлуулах албан бус зах зээлийн үйл ажиллагаа (хувь ченжүүдэд алт худалдаалах, худалдан авах)-ны цаана хувь хүн хөдөлмөрөө дутуу үнэлүүлэх, эсвэл орлогын албан татвар тооцогдохгүй үлдэх, алт олборлогчдын үйлдвэрлэл эдийн засагт тооцогдохгүй хоцрох, ашигт малтмалын нөөц зүй бусаар ашиглагдах зэрэг микро болон макро түвшний олон сөрөг асуудлууд оршиж байдаг тул цаашид хувиараа алт олборлогчдын асуудлыг бодлогоор зохицуулахдаа энэхүү алт борлуулалтын асуудлыг хамтад нь анхаарч зохих арга хэмжээ авах нь зүйтэй юм.

Судлаач бид алт борлуулах албан зах зээлийн үйл ажиллагаа (банкинд алт худалдаалах, худалдан авах)-г дэмжиж, санал болгож буйн хувьд түүний давуу талыг харуулах тооцоог энэ удаагийн судалгааны мэдээлэлд үндэслэн хийлээ. Энэ нь, ХАМО нарын олборлосон алт хэрэв албан зах зээлд (банкинд) борлогдсон бол орлогын байдал ямар байх байсныг тооцсон тооцоо юм. ХАМО нарын хувьд олборлосон алтаа ченжүүдэд биш, албан зах зээлд тушааж борлуулах байсан боломжит хувилбар нь эдийн засгийн нэр томъёогоор *алдагдсан боломж* бөгөөд, алтаа банкинд борлуулснаар олох боломжтой байсан орлого нь *алдагдсан боломжийн өртөг* юм. Судалгаанд хамрагдсан ХАМО нарын алдагдсан боломжийн өртгийг тооцож, Хүснэгт 5.4-т харуулав.

Хүснэгт 5.4 Судалгаанд хамрагдсан ХАМО нарын алдагдсан боломжийн өртөг, улирлаар

Алдагдсан боломжийн өртөг (төгрөг)	Улирал				жилийн дундаж (2009 оны 2-р сараас 2010 оны 2-р сарын хооронд ажилласан нийт хоногт)
	өвөл	хавар	зун	намар	
Монгол банкны 1 грамм алт худалдан авсан дундаж үнэ**	53 262.6	40 483.3	42 801.9	48 831.7	43 499.4
Тухайн улиралд ажилладаг нэг ХАМО-ийн ажилласан 1 хоногийн алдагдсан боломжийн өртөг	45 851.1	38 712.2	57 675.7	60 124.2	56 061.3*
Тухайн улиралд ажилладаг нэг ХАМО-ийн улирал/жилийн алдагдсан боломжийн өртөг	124451.4	1 656 914.0	2 370 497.7	2 117 942.2	3 410 363.8
Тухайн улиралд ажилласан ХАМО нарын тоо	48	40	145	264	300

* ажилласан хугацаагаар жигнэсэн дундаж

** 2009.03.01-ээс 2010.03.01 хүртэлх хугацааг алт олборлогчийн ажлын нэг жил гэж үзсэн ба монгол банкны тухайн улирал/жилийн дундаж ханшийг гаргахдаа хуанли дээрх улирлын болон жилийн дунд үеийн ханшуудаар төлөөлүүлсэн. Эдгээр нь: 2010.01.15, 2009.04.15, 2009.07.15, 2009.10.15, 2009.09.01-ний өдрүүдийн алт худалдан авах ханш болно.

Эх үүсвэр: <http://www.mongolbank.mn/web/guest/statistics/gold-silver-price/rate-history?>

Судалгаагаар алт олборлогчдын ажлын нэг жилийг 2009 оны 03 сарын 01-ээс 2010 оны 03 сарын 01 хүртэлх хугацаагаар тооцож авсан ба энэ хугацааны албан зах зээлийн алт худалдан авах ханшийг бид монгол банкны хуанлийн дээрх хугацаанд алт худалдан авч байсан үнээр төлөөлүүлсэн.

Хүснэгт 5.4-өөс харахад, өнгөрсөн жилд хавраас бусад бүх улирлуудад алт борлуулах албан зах зээл дээр алт худалдан авч байсан үнэ нь алтны ченжүүдийн ХАМО нараас алт худалдан авсан ханш (Хүснэгт 5.3)-аас өндөр үнэлгээтэй байжээ. Тухайлбал, алт олборлогчид өнгөрсөн жил олборлосон алтаа банкинд худалдсан бол өвөл 1 граммыг нь дунджаар 53,262.6 төгрөгөөр (ченжүүдэд худалдсанаас 12,866.8 төгрөгөөр илүү), хавар 1 граммыг нь дунджаар 40,483.3 төгрөгөөр (ченжүүдэд худалдсанаас 316.7 төгрөгөөр доогуур), зун 1 граммыг нь дунджаар 42,801.9 төгрөгөөр (ченжүүдэд худалдсанаас 4,322.1 төгрөгөөр илүү), намар 1 граммыг нь дунджаар 48,831.7 төгрөгөөр (ченжүүдэд худалдсанаас 8,960.8 төгрөгөөр илүү) тус тус худалдах байсан байна.

Дээрх албан зах зээлийн алт худалдан авах ханшаар тооцвол, хувиараа алт олборлож буй нэг хүн алт олборлолтоос ажлын нэг хоногт дунджаар 56,061.3 төгрөг, жилд ажилласан бүх хоногуудад нийтдээ дунджаар 3,410,363.8 төгрөгийг тус тус олох боломжтой байсан ба эдгээр нь ченжийн захын ханшаар тооцсон одоогийн орлогоос харгалзан 9,051.6 төгрөг, 452,933.7 төгрөгөөр илүү байгаа юм. Ийнхүү ХАМО нарын хувьд алдагдсан боломжийн өртөг одоогийн орлогоос өндөр байгаа нь хувиараа алт олборлогчдод алтаа борлуулах зөв зохистой суваг, зах зээл байхгүй байгаагаас тэд багагүй хэмжээний орлогоо алдаж, хөдөлмөр нь дутуу үнэлэгдэж байгааг харуулж байна.

Тэгвэл, алтаа борлуулах тохиромжтой арга юу байж болох талаар бид судалгаагаараа ХАМО нараас өөрсдөөс нь асуусан ба үр дүнг хариулагчдын шинж байдлаар ялган Хүснэгт 5.5-д харуулав.

Хүснэгт 5.5 Судалгаанд хамрагдагчдын хувийн жин, алт борлуулах тохиромжтой аргын талаарх үзэл бодол, сонгосон үзүүлэлтүүдээр

Сонгосон үзүүлэлтүүд	Алт борлуулах тохиромжтой цэгийн талаарх үзэл бодол			Бүгд	ХАМО нарын тоо
	Орон нутгийн банк	Ченжүүд	Бусад		
Насны бүлэг					
18-30	45.4	52.3	2.3	100.0	88
31-40	64.9	29.8	5.3	100.0	114
41-60	68.4	29.6	2.0	100.0	98
Шилжилтийн байдал					
Явуулын	47.0	49.4	3.6	100.0	83
Суурин	65.4	31.3	3.2	100.0	217
Нийт алт олборлогчид	60.3	36.3	3.3	100.0	300

ХАМО нарын үзэж байгаагаар алт борлуулах хамгийн тохиромжтой аргууд дотор орон нутгийн банк (60.3 хувь) гэсэн хариулт хамгийн өндөр хувь эзэлж байна. Үүний дараа, ченжүүд (36.3 хувь), алтны газарт ойр, өндөр үнээр авдаг ямар нэгэн цэг гэх мэт бусад хариултууд (3.3 хувь) орж байв. Эдгээрээс дүгнэхэд, нөхцөл нь бүрдвэл хувиараа алт олборлогчид алтаа борлуулахдаа албан зах зээлийг сонгоход бэлэн байгаа нь харагдаж байна.

5.3 Алт олборлолтын зардал

Хувиараа алт олборлох үйл ажиллагааг алт олборлогчид тодорхой хэмжээний зардлаар хийдэг. Тэдний гаргадаг нийт зардлыг дотор нь *урсгал зардал*, *капитал зардал* гэж ерөнхийгөөр ангилж болох ба *урсгал зардал*-д бид алт олборлогчийн богино хугацаанд хэрэглэгдээд дуусах зүйлсэд зарцуулсан зардлыг, тухайлбал, хоол, унаа, түлш гэх мэт өдөр тутмын хэрэглээний зардлыг оруулсан. Харин *капитал зардал*-д алт олборлогчийн урт хугацаанд хэрэглэгдэх зүйлд зарцуулсан зардлыг, тухайлбал, хөдөлмөрийн багаж, тоног төхөөрөмж, хөдөлмөр хамгааллын хувцас, хэрэгслийн зардал зэргийг оруулсан. Ингээд, алт олборлох явцдаа *ажлын* болон *ердийн* хоног, сар, улирал, жилд нэг алт олборлогч ямар хэмжээний зардлууд гаргадгийг тооцож, дэлгэрэнгүй үр дүнг Хүснэгт 5.6-д харуулав.

Хүснэгт 5.6 Судалгаанд хамрагдагчдын алт олборлолтын дундаж зардал, улирал, жилээр

Тухайн улиралд ажилладаг нэг ХАМО-ийн алт олборлолтын зардал (төгрөгөөр)	Улирал				Жилийн дундаж (2009 оны 2-р сараас 2010 оны 2-р сарын хооронд ажилласан нийт хоногт)
	өвөл	хавар	зун	намар	
Ажилласан нэг хоногт:					
урсгал зардлын дундаж хэмжээ	13 645.7	10 575.0	9 607.6	10 697.4	10 626.1¹
капитал зардлын дундаж хэмжээ*	2 017.0	1 938.7	3 495.3	4 983.2	5 179.9
нийт зардлын дундаж хэмжээ	15 683.7	12 563.7	13 102.9	15 699.6	15 806.0¹
Улирал/жилийн ердийн нэг хоногт:					
урсгал зардлын дундаж хэмжээ	3 711.4	4 912.7	4 154.3	3 959.9	1 686.4²
капитал зардлын дундаж хэмжээ*	385.4	615.5	860.6	1 052.2	371.5²
нийт зардлын дундаж хэмжээ	4 096.9	5 528.1	5 014.0	5 012.1	2 058.0²
Ажилласан нэг сард:					
урсгал зардлын дундаж хэмжээ	215 673.6	200 308.3	165 467.6	174 464.3	172 007.2³
капитал зардлын дундаж хэмжээ*	24 566.2	29 330.4	42 101.6	59 739.5	59 182.7³
нийт зардлын дундаж хэмжээ	240 239.8	229 638.7	207 569.2	234 203.8	231 189.9³
Улирал/жилийн ердийн нэг сард:					
урсгал зардлын дундаж хэмжээ	111 342.6	150 655.6	127 399.0	120 115.9	51 295.1⁴
капитал зардлын дундаж хэмжээ*	11 563.1	18 874.4	26 391.3	31 917.1	11 302.4⁴
нийт зардлын дундаж хэмжээ	122 905.7	169 530.0	153 790.3	152 033.0	62 597.5⁴
Улирал/жилд:					
урсгал зардлын дундаж хэмжээ	334 027.8	451 966.7	382 197.0	360 347.8	615 541.3
капитал зардлын дундаж хэмжээ *	34 689.2	56 623.3	79 173.9	95 751.1	135 628.3
нийт зардлын дундаж хэмжээ	368 717.0	508 590.0	461 370.9	456 098.9	751 169.6
Тухайн улиралд ажилласан ХАМО нарын тоо					
	48	40	145	264	300

* улирал тус бүрийн капитал зардлын хэмжээг жилээр өгөгдсөн капитал зардлын мэдээлэл ба ажилласан хоногийн тоонд үндэслэн тооцсон

¹ улирал бүрт ажилласан хоногийн тоонуудаар жигнэсэн дундаж

² жилийн 365 хоногт харьцуулсан дундаж

³ улирал бүрт ажилласан сарын тоонуудаар жигнэсэн дундаж

⁴ жилийн 12 сард харьцуулсан дундаж

ХАМО иргэний *ажилласан нэг хоногт гаргасан урсгал зардлын хэмжээ*-г бид судалгааны асуулга дахь “Та ажлын нэг хоногт дунджаар хэдэн төгрөгийн урсгал зардал гаргадаг вэ?” гэсэн асуултын дагуу мэдээлэл цуглуулж гаргасан. *Ердийн нэг хоногт гаргасан урсгал*

зардал-г тооцохдоо улирал/жилд гаргасан нийт урсгал зардлын хэмжээг улирал болон жил дэх нийт хоногийн тоо (өвлийн 90 хоног, хаврын 92 хоног, зуны 92 хоног, намрын 92 хоног, жилийн 365 хоног)-нд харьцуулан, *ердийн нэг сард гаргасан урсгал зардал* –ыг тооцохдоо, улирал/жилд гаргасан нийт урсгал зардлын хэмжээг улирал болон жил дэх нийт сарын тоо (улирал бүрт 3 сар, жилд 12 сар)-нд харьцуулан гаргасан. Энэхүү аргачлалыг бусад төрлийн зардлуудыг тооцоход мөн ашигласан.

Бигэр сумын алтны шороон орд бүхий газарт хувиараа алт олборлож байгаа нэг ХАМО иргэн ажилласан нэг хоногт дунджаар 10,626.1 төгрөгийн урсгал зардал, 5,179.9 төгрөгийн капитал зардал, нийтдээ 15,806.0 төгрөгийн зардал гарган алт олборлох ажил хийдэг байна. ХАМО нарын гаргадаг зардлыг ердийн нэг хоногт ногдох байдлаар тооцож үзвэл, нэг ХАМО жилийн ердийн нэг хоногт дунджаар 1,686.4 төгрөгийн урсгал зардал, 371.5 төгрөгийн капитал зардал, нийтдээ 2,058.0 төгрөгийн зардлыг алт олборлоход гаргадаг гэсэн үр дүн гарчээ. Алт олборлолтын зардлыг сараар тооцож үзвэл, ажлын нэг сард нийтдээ дунджаар 231,189.9 төгрөг, ердийн нэг сард дунджаар 62,597.5 төгрөг зарцуулдаг болох нь харагдлаа.

ХАМО нарын ажлын нэг хоног болон нэг сард гаргадаг зардлыг улирлаар ялган харвал өвөл, намрын улиралд арай өндөр, харин хавар, зуны улирлуудад арай бага байна. Өвлийн зардал өндөр байгаа нь алт олборлогчид хөлдүү, мөстсөн газрыг гал түлж гэсгээхэд зориулсан зардал, мөн өөрсдөө дулаацах гэх мэтийн нэмэлт зардлуудыг нэмж гаргадагтай холбоотой болов уу. Харин намар ХАМО нарын урсгал зардал тийм өндөр биш ч гэсэн олон хоног ажилладаг тул капиталын элэгдлийн зардал их болж, нийт зардал нь өндөр тусдаг байна.

ХАМО нарын алт олборлохдоо өнгөрсөн жилд гаргасан урсгал, капитал, нийт зардлуудыг тооцож үзвэл, дунджаар 615,541.33 төгрөгийн урсгал зардал, 135,628.33 төгрөгийн капитал зардал, нийтдээ дунджаар 751,169.6 төгрөгийн зардал гаргажээ. Энд нэг зүйлийг тэмдэглэхэд, зарим алт олборлогч жилийн ганц улиралд ажилладаг байхад, зарим нь хэд хэдэн улиралд ажилладаг тул алт олборлогч тус бүрийн жилд гаргасан нийт зардал нэлээд хэлбэлзэлтэй байсан ба дээрх дүн нь тэдгээрийн ерөнхий дунджийг л илэрхийлж байгаа болно.

Дээрх зардлуудаас гадна алт олборлох ажлыг хийхийн тулд ХАМО нар ямар нэгэн зээлийн дарамт үүрсэн эсэхийг бид судалгаагаараа тодруулан асуусан юм. Энэ асуултаар, судалгаанд хамрагдсан хувиараа алт олборлогчдын 10.7 хувь нь алт олборлож эхэлснээс хойш 200,000 төгрөгөөс 2,000,000 төгрөг хүртэлх зээл авсан гэж мэдээлсэн ба зээл авагчдаас зээлийн зорилгыг тодруулахад алт олборлохтой холбоотой зээл авсан хүмүүс 6.2 хувийг эзэлж байв. Тэд алт олборлох багаж тоног төхөөрөмж авах болон алт олборлох ажлаа эхлүүлэх гарааны мөнгөтэй болохын тулд зээл авсан гэсэн ба энэ судалгааг авах үед тухайн зээлээ төлж дуусаагүй, дунджаар 1,250,000 төгрөгийн зээлийн үлдэгдэлтэй байв.

5.4 Алт олборлолтын орлого ба татвар төлөлт

Судалгаанд хамрагдагчдын орон нутгийн захиргаанд ашигт малтмалын нөөц ашигласны болон газрын нөхөн сэргээлтийн төлбөр төлдөг эсэхийг авч үзэхэд шилжих хөдөлгөөнд оролцоогүй, суурин 3 хариулагч (нийт хариулагчдын 1.0 хувь) ашигт малтмалын нөөц


ашигласны төлбөрт тус тус 22000, 40000, 64000 төгрөгүүдийг төлсөн гэжээ. Хэдийгээр Бигэр суманд хувиараа алт олборлолтыг албан ёсны зохион байгуулалтад оруулаагүй байгаа ч тухайн суманд хүмүүс анх хувиараа алт олборлож эхэлсэн эхэн үед нэг хэсэг сумын захиргаанаас ийм төрлийн төлбөрийг авч байгаад больсон тухай судалгааны мэдээлэл цуглуулах үед холбогдох ажилтан ярьж байсан юм.

Шигтгээ 5.1:

... Манай сумын захиргаанаас алт олборлолтын эхэн үед ХАМО иргэдээс газрын нөөц ашигласны татвар хураамж нийтдээ 6 сая орчим төгрөгийг төсөвт төвлөрүүлсэн боловч үүнийг орон нутгийн хэрэгцээтэй байгаа үйл ажиллагаанд зарцуулж чадаагүй. Суманд өөр орон нутгаас олон тооны алт олборлогчид бөөнөөр ирэх болсоноор бид тэднийг бүртгэж, хянаж байсан тоогоо алдаж, бас тэдний зүгээс эсэргүүцэлтэй тулгарч, дахин хураах боломжгүй болсон. Алт олборлогчдын тоо эрс нэмэгдсэнээр бид харин ч төвлөрүүлсэн байсан дээрх орлогоо эргээд ХАМО нарын хууль бус үйл ажиллагааг зогсооход зарцуулаад таарсан. Хэрвээ эдгээр алт олборлогч иргэдийн үйл ажиллагааг зохицуулах хууль батлаад зохион байгуулалтанд оруулбал ашигт малтмал олборлосон орлогын татвар орон нутгийн хөгжилд үнэтэй хувь нэмэр оруулж чадна гэж бодож явдаг. Гол нь энд зөвхөн орон нутгийн иргэд л ажилласан тохиолдолд илүү үр дүнтэй ажил болно.

М, эрэгтэй, байгаль орчны байцаагч

Судалгаанд хамрагдсан Бигэр суманд хувиараа алт олборлож буй иргэдийн дунд алт олборлолтын орлогоос орлогын албан татвар төлдөг хүн нэг ч байгаагүй бөгөөд үүний шалтгааны талаарх мэдээллийг Зураг 5.2-т харуулав.



ХАМО нарын алтны орлогоос орлогын албан татвар төлдөггүй шалтгаанууд дотор “төлөх аргаа мэдэхгүй” (41.3 хувь), “алтны орлогоосоо тийм төрлийн татвар төлөх шаардлагатай талаар мэдэхгүй” (37.7 хувь) гэсэн хариултууд хамгийн өндөр хувийг эзэлж байсан ба тэдний нийлбэр нийт хариулагчдын тавны дөрөв орчим хувьтай тэнцэж байв. Эдгээр хариултууд нь ХАМО нарын дийлэнх орлогын албан татвар төлөхөөс санаатайгаар зайлсхийгээгүй гэсэн утга санааг тод илэрхийлж байна. Өөрөөр хэлбэл, хэдийгээр ХАМО нар одоогоор орлогын албан татвар огт төлөөгүй байгаа ч цаашид энэ талаар зөв мэдээлэл, ухуулга сурталчилгааг хийвэл, алт олборлолтын орлогоосоо албан татвар төлөхөөс тэр болгон зайлсхийхгүй байхаар байна гэж дүгнэхэд буруудахгүй болов уу.

5.5 Алт олборлолтын ашиг ба өрхийн амьжиргаанд гарсан өөрчлөлт

ХАМО нарын мэдээлсэн ажлын хоног, хөдөлмөрийн бүтээмж, ажлын зардал зэрэг мэдээллүүдийн тусламжтайгаар тэдний алт олборлох үйл ажиллагааны эцсийн үр дүн болох цэвэр орлого буюу ашиг ямар байдгийг тооцож, үр дүнг Хүснэгт 5.7-д харуулав.

Алт олборлолтоос олдог орлогоос алт олборлолтын урсгал ба капитал зардлын дүнг хасаж, ХАМО нарын хоног, сар, улирал, жилд олдог ашгийг тооцож үзэхэд ажлын нэг хоногт дунджаар 31,316 төгрөг, ажлын нэг сард дунджаар 540,672 төгрөг, жилд ажилласан нийт хоногт дунджаар 2,212,740 төгрөгийн ашигтай ажилласан байна. ХАМО нарын ашгийг ердийн нэг хоног, сараар тооцож үзэхэд, 1 алт олборлогч жилийн ердийн нэг хоногт 6,062 төгрөг, жилийн ердийн нэг сард 184,395 төгрөгийн цэвэр орлого буюу ашгийг хувиараа алт олборлолтоос олдог гэсэн үр дүн гарчээ.

Хүснэгт 5.7 Судалгаанд хамрагдагчдын алт олборлолтоос олдог ашиг, улирлаар

Тухайн улиралд ажилладаг нэг ХАМО-ийн алт олборлолтын ашиг (төгрөгөөр)	Улирал				Жилийн дундаж (2009 оны 2-р сараас 2010 оны 2-р сарын хооронд ажилласан нийт хоногт)
	өвөл	хавар	зун	намар	
Хоногт алт олборлолтоос олсон ашиг*					
Ажилласан нэг хоногт	19 419.8	26 893.4	38 823.8	33 873.2	31 315.9¹
Улирал/жилийн ердийн нэг хоногт	5 251.6	12 939.5	18 396.0	14 490.3	6 062.3²
Сард алт олборлолтоос олсон ашиг					
Ажилласан нэг сард	280 908.8	516 679.7	731 888.2	581 377.9	540 671.5³
Улирал/жилийн ердийн нэг сард	157 549.0	396 810.7	564 144.5	439 538.9	184 395.0⁴
Улирал/жилд алт олборлолтоос олсон ашгийн дундаж хэмжээ	472 646.9	1 190 432.2	1 692 433.5	1 318 616.7	2 212 740.0
Тухайн улиралд ажилладаг ХАМО нарын тоо	48	40	145	264	300

* ажлын нэг хоногт алт олборлолтоос олдог орлогоос хоногт гаргадаг урсгал ба капитал зардлын нийлбэрийг хассан дүн

¹ улирал тус бүрд ажилласан хоногийн тоогоор жигнэсэн дундаж

² жилийн 365 хоногт харьцуулсан дундаж

³ улирал тус бүрд ажилласан сарын тоогоор жигнэсэн дундаж

⁴ жилийн 12 сард харьцуулсан дундаж

Алт олборлогчдыг алтнаас олдог ашгаар нь бүлэглэн харвал (Хавсралт 5.3), өнгөрсөн жилд нийт алт олборлогчдын 16.3 хувь нь алдагдалтай ажилласан, 31.0 хувь нь дунджаар 600,000 хүртэл төгрөгийн ашигтай, 29.0 хувь нь дунджаар 600,001-3,000,000 төгрөгийн ашигтай, үлдсэн 23.7 хувь нь жилд дунджаар 3,000,001 ба түүнээс дээш төгрөгийн ашигтай ажилласан гэсэн үр дүн гарчээ. Алдагдалтай ажилласан алт олборлогчдын ихэнх нь хувиараа алт олборлож эхлээд удаагүй, капитал зардал өндөр гаргасан хариулагчид байлаа.

ХАМО нар алт олборлолтоос олсон орлогоо амьдрал ахуйдаа хэрхэн зарцуулж байгаа мэдээллийг Хүснэгт 5.8-д харуулав. Хүснэгтээс харахад нийт алт олборлогчдын талаас илүү буюу 57.3 хувь нь алт олборлолтын орлогоо өрхийн өдөр тутмын хэрэглээнд зарцуулдаг гэсэн нь алт олборлогчдын өрхийн эдийн засгийн амьдрал хүнд байдалтай, өнөө, маргаашийн амьжиргаа нь алт олборлолтын орлогоос ихээхэн хамааралтай байдгийг баталж байна. Ийм хариултыг өгсөн хүмүүсийн хувийн жин залуу буюу 30-аас доош насны, эмэгтэй, ядуу болон 3-аас олон тооны насанд хүрээгүй хүүхэдтэй өрхийн хариулагчдын дунд бусад бүлгийнхнээс өндөр байв.

Хүснэгт 5.8 Судалгаанд хамрагдагчдын хувийн жин, алт олборлолтоос олсон орлогоо зарцуулдаг байдал, хариулагчийн шинж байдлаар

Хариулагчийн шинж байдал	Алт олборлолтоос олсон орлогын дийлэнхийг зарцуулдаг эх үүсвэр							Бүгд	ХАМО нарын тоо
	өрхийн өдөр тутмын хэрэглээнд	Хүүхдийн сургалт	Амьдралаа дээшлүүлэхэд	өр, зээлээ төлөхөд	Унаа, газар тариалангийн багаж, өвс гэжээл	эмчилгээнд	өөртөө хэрэгтэй зүйлс худалдан авахад		
Насны бүлэг									
18-30	69.3	8.0	5.7	8.0	4.5	0.0	4.5	100.0	88
31-40	66.7	8.8	12.3	0.9	7.9	0.9	2.6	100.0	114
41-60	35.7	33.7	5.1	11.2	4.0	8.2	2.0	100.0	98
Хүйс									
Эрэгтэй	57.0	18.3	6.1	8.3	6.5	1.7	2.2	100.0	230
Эмэгтэй	58.6	11.4	14.3	0.0	2.9	7.1	5.7	100.0	70
Өрхийн амьжиргааны түвшин									
Ядуу	58.9	15.0	6.7	8.3	5.0	3.9	2.2	100.0	180
Ядуу бус	55.0	19.2	10.0	3.3	6.6	1.7	4.2	100.0	120
Өрх дэх 0-16 насны хүүхдийн тоо									
0	48.3	41.4	3.4	1.7	3.4	1.7	0.0	100.0	58
1	53.8	10.3	12.8	2.6	3.8	9.0	7.7	100.0	78
2	59.3	8.0	7.1	13.3	9.7	0.9	1.8	100.0	113
3, түүнээс олон	68.6	17.6	7.8	2.0	2.0	0.0	2.0	100.0	51
Нийт алт олборлогчид	57.3	16.7	8.0	6.3	5.7	3.0	3.0	100.0	300

Хүүхдийн боловсролд алтнаас олсон орлогын дийлэнхийг зарцуулдаг гэж хариулагчид нийт ХАМО нарын 16.7 хувийг эзэлж байсан ба ийм хариултыг 40-өөс дээш насны, эрэгтэй, ядуу бус өрхийн, бага насны хүүхэдгүй өрхийн хариулагчид бусад бүлгийнхнээс түлхүү өгсөн байна. Дээрх хэрэглээнүүдээс гадна алтнаас олсон орлогын дийлэнхийг амьдралдаа чанарын өөрчлөлт гаргахуйц зүйлд зарцуулан, амьдралаа дээшлүүлдэг гэсэн хариулагчид нийт алт олборлогчдын 8.0 хувийг эзэлж байгаа ба бусад хариулагчид нь алт олборлож олсон орлогын дийлэнхийг өр зээлээ төлөх (6.3 хувь), унаа, газар тариалангийн багаж хэрэгсэл, өвс тэжээл авах (5.7 хувь), эмчилгээ (3.0 хувь) болон өөрт хэрэгцээтэй зүйлс худалдан авахад (3.0 хувь) зарцуулдаг гэжээ. Амьдралаа дээшлүүлэхэд алт олборлолтын орлогын дийлэнхийг зарцуулдаг гэсэн хариултыг өгөгчид 31-40 настай, эмэгтэй, ядуу бус, насанд хүрээгүй 1 хүүхэдтэй өрхийн алт олборлогчдын дунд бусдаас илүүтэй байсан. Бигэр суманд ажиллаж буй ХАМО нарын алтнаас олсон орлогоо зарцуулсан байдлаас ерөнхийд нь дүгнэхэд, амьдралын чанарт өөрчлөлт гарахуйц зүйлд орлогоо зарцуулсан байдал бага байгаа нь тэдний дийлэнх алт олборлож эхлээд удаагүй тул алт олборлолтын эдийн засгийн үр шимийг төдийлөн удаан хүртэж амжаагүйтэй холбоотой гэж үзэж болно.

Алтнаас олсон орлого тухайн өрхөд мөнгөн хуримтлал үүсгэж чаддаг эсэхийг харах зорилгоор бид судалгаандаа “Та алт олборлолтоос олсон орлогоосоо мөнгөн хуримтлал үүсгэж чадсан уу?” гэж асуухад, “тийм” хариултыг өгсөн хариулагчдын хувь 6.7 байсан нь нэлээн хангалтгүй үзүүлэлт байлаа.


Алт олборлолт өрхийнх нь амьжиргаанд хэр нөлөө үзүүлсэн талаарх ХАМО нарын сэтгэл ханамжийн мэдээллийг хариулагчийн шинж байдлаар задлан Хүснэгт 5.9-д харуулав.

Хүснэгт 5.9 Судалгаанд хамрагдагчдын хувийн жин, алт олборлож эхэлснээс хойш өрхийн амьжиргаанд гарсан өөрчлөлтөө дүгнэсэн байдал, хариулагчдын шинж байдлаар

Сонгосон үзүүлэлтүүд	Алт олборлож эхэлснээс хойш өрхийн амьжиргаанд гарсан өөрчлөлт		Бүгд	ХАМО нарын тоо
	Дээшилсэн	Хэвээрээ		
Насны бүлэг				
18-30	59.1	40.9	100.0	88
31-40	45.6	54.4	100.0	114
41-60	66.3	33.7	100.0	98
Хүйс				
Эрэгтэй	57.8	42.2	100.0	230
Эмэгтэй	51.4	48.6	100.0	70
Өрхийн амьжиргааны түвшин				
Ядуу	53.9	46.1	100.0	180
Ядуу бус	60.0	40.0	100.0	120
Өрх дэх 0-16 насны хүүхдийн тоо				
Байхгүй	67.2	32.8	100.0	58
1 хүүхэд	62.8	37.2	100.0	78
2 хүүхэд	47.8	52.2	100.0	113
3-6 хүүхэд	52.9	47.1	100.0	51
Алт олборлолтоос жилд олдог ашиг				
Алдагдалтай	30.6	69.4	100.0	49
600,000 хүртэл төгрөг	63.4	36.6	100.0	93
600,001-3,000,000 төгрөг	56.3	43.7	100.0	87
3,000,001+ төгрөг	64.5	35.5	100.0	71
Нийт алт олборлогчид	56.3	43.7	100.0	300

Судалгаанд хамрагдсан нийт ХАМО нарын дунд алт олборлож эхэлснээс хойш өрхийн амьжиргаа нь доошилсон гэж хариулагчид нэг ч байгаагүй ба амьжиргаа дээшилсэн гэж хариулагчид 56.3 хувь, хэвээрээ байгаа гэж хариулагчид 43.7 хувийг тус тус эзэлж байв. Хариулагчдын шинж байдлаар нь задлан харахад алт олборлож эхэлснээс хойш өрхийнхөө амьжиргааг дээшилсэн гэж үзэж буй хариулагчдын хувь хамгийн өндөр байгаа бүлгийнхэн нь 40-өөс дээш насны (66.3 хувь), эрэгтэй (57.8 хувь), ядуу бус өрхийн (60.0 хувь), өрхөд нь насанд хүрээгүй хүүхэд байхгүй (67.2 хувь), алт олборлолтын жилийн ашиг нь хамгийн өндөр байдаг бүлгийн (64.5 хувь) хүмүүс байв. Өөрөөр хэлбэл, хувиараа алт олборлох ажил нь эдгээр бүлгийн хүмүүсийн амьжиргаанд бусдаас илүүтэйгээр үр өгөөжөө өгсөн байна.

Алт олборлож эхэлснээс хойш өрхийнхөө амьжиргааг дээшилсэн гэж үзэж буй хариулагчдаас ямар байдлаар амьжиргаа нь дээшилсэн тухай бодитой жишээнүүдийг асуухад (Зураг 5.3, Шигтгээ 5.2, Шигтгээ 5.3) алт олборлолтын орлого өр зээлээ дарахад нь нэмэр болсон гэсэн хариулт бусад төрлийн хариултаас өндөр хувьтай (ядуу өрхийн хариулагчдын 43.3 хувь, ядуу бус өрхийн хариулагчдын 37.5 хувь) байв.



Шигтгээ 5.2

Манай банкнаас 9 сард хүүхдийн сургалтын төлбөр гэж зээл их авдаг байсан бол нутагт маань алт гарч ХАМО нар алт олборлож эхэлснээс хойш тийм төрлийн зээлийг авах нь багасч мөнгөн хуримтлал нэмэгдэж байгаа. Мөн өөр нутгийн иргэд мөнгө шилжүүлэх нь ихэссэн....

М, эр 28 настай, банкны ажилтан

Алт олборлолтын орлого ийнхүү тодорхой өрхүүдэд өр зээлийн дарамтнаас гарахад нь нэмэр болоод зогсоогүй, зарим өрхийн боловсрол, эрүүл мэндэд зарцуулагдах, зарим өрхийг байнгын бэлэн мөнгөтэй болгох, зарим өрхийг өдөр тутмын хэрэгцээгээ тогтвортой хангадаг болгох гэх мэтээр олон байдлаар амьдралыг нь дээшлүүлэхэд хувь нэмэр болжээ.

Шигтгээ 5.3

Намайг 8-р сард Бигэр суманд анх ирэхэд дэлгүүрүүд нь 10 мянган төгрөг задалж чадахгүй, хатсан ганц хоёрхон боорцогтой, бараа гэж бараг л байхгүй газар байсан шүү дээ. Одоо бол лангуу дүүрэн бараатай байх болсон....

Х, эрэгтэй 32 настай, ХАМО

БҮЛЭГ 6. ХУВИАРАА АЛТ ОЛБОРЛОГЧДЫН ЭРҮҮЛ МЭНД, ЭРҮҮЛ МЭНДИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХҮРТЭЭМЖ

Хувиараа алт олборлож байгаа иргэдийн хувьд эрүүл ахуйн шаардлагыг хангасан орчинд ажиллаж чаддаггүй, цаг уурын эрс тэрс уур амьсгалд ажилладаг, хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны нөхцлөө хангадаггүйгээс осол аварга өртөх, хууч ужиг өвчин нь сэдрэх зэрэг сөрөг нөхцөл байдал үүсэх нь олонтаа байдаг. Энэхүү бүлэгт хувиараа алт олборлож байгаа иргэд ямар төрлийн өвчин, осол гэмтэлд илүүтэй өртөж байгаа, хэрэгцээтэй үедээ эрүүл мэндийн үйлчилгээ авч чадаж байгаа эсэх, эрүүл мэндийн үйлчилгээ авахад нь ямар бэрхшээлүүд тулгарч байгаа эсэх, мөн тэдэнд ямар төрлийн үйлчилгээнүүд нэн шаардлагатай байгаа талаар авч үзэх болно.

6.1 Хувиараа алт олборлогчдын алт олборлож эхэлснээс хойшхи эрүүл мэндийн байдал

Судалгаанд оролцсон ХАМО нарын 19.3 хувь нь алт олборлож эхэлснээс хойш биед нь ямар нэг өвчний зовиур илэрсэн гэж мэдээлжээ (Хүснэгт 6.1). Шинж байдлаар нь авч үзвэл 30-аас дээш насны (22.4-24.6 хувь), эрэгтэй (20.0 хувь), алт олборлох ажлыг удаан хийж байгаа (39.4 хувь) ХАМО нарын дунд өвдсөн байдал илүүтэй илэрсэн байна.

Хүснэгт 6.1 Судалгаанд хамрагдагчдын хувийн жин, хувиараа алт олборлож эхэлснээс хойш эрүүл мэндийн зовиур илэрсэн эсэх, хариулагчийн шинж байдлаар

Хариулагчийн шинж байдал	Хувиараа алт олборлож эхэлснээс хойш эрүүл мэндийн зовиур илэрсэн эсэх		Бүгд	ХАМО нарын тоо
	тийм	үгүй		
Насны бүлэг				
18-30	9.1	90.9	100.0	88
31-40	24.6	75.4	100.0	114
41-60	22.4	77.6	100.0	98
Хүйс				
Эрэгтэй	20.0	80.0	100.0	230
Эмэгтэй	17.1	82.9	100.0	70
Алт олборлосон хугацаа				
1-2 сар	10.3	89.7	100.0	116
3-4 сар	16.8	83.2	100.0	101
5-аас дээш сар	34.9	65.1	100.0	83
Жилд хувиараа алт олборлодог хоног				
25 хүртэл хоног	4.0	96.0	100.0	99
26-61 хоног	13.4	86.6	100.0	97
62, түүнээс олон хоног	39.4	60.6	100.0	104
Нийт алт олборлогчид	19.3	80.7	100.0	300

Алт олборлож эхэлснээс хойш өвчний зовиур илэрсэн гэж хариулсан алт олборлогчдоос ямар төрлийн өвчин, зовиур илэрснийг асуухад (Хүснэгт 6.2), хамгийн түгээмэл илэрсэн нь бөөр, шээсний замын өвчин (51.7 хувь), үе мөч нурууны өвчин (41.4 хувь), гэдэс дотрын өвчин (27.6 хувь) зэрэг байна. Эдгээр нь хувиараа алт олборлож байгаа иргэдийн ажлын нөхцөл хүнд, хуурай тоос шороотой, хүйтэн газар олон цагаар ажиллах, хоолны дэглэм алдагдах зэрэг хүнд нөхцлүүдтэй холбоотой юм.

Хүснэгт 6.2 Алт олборлож эхэлснээс хойш эрүүл мэндийн зовиур илэрсэн хариулагчдын хувь, илэрсэн зовиур, өвчнөө нэрлэсэн байдал, хүйсээр

Илэрсэн зовиур, өвчнөө нэрлэсэн байдал	Хүйс		Эрүүл мэндийн зовиур илэрсэн нийт алт олборлогчид
	эрэгтэй	Эмэгтэй	
Бөөр, шээсний замын өвчин	47.8	66.7	51.7
Үе мөч, нурууны өвчин	32.6	75.0	41.4
Гэдэс, дотрын өвчин	32.6	8.3	27.6
Мэдрэл, ядаргаа	30.4	8.3	25.9
Амьсгалын замын өвчин	28.3	8.3	24.1
Арьсны өвчин	13.0	16.7	13.8
Нүдний өвчин	8.7	0.0	6.9
Чих, хамар, хоолойн өвчин	4.3	8.3	5.2
Зүрх, судасны өвчин	4.3	8.3	5.2
Эрүүл мэндийн зовиур илэрсэн ХАМО нарын тоо	46	12	58

* Хариулт олон сонголттой тул хувийн жингийн нийлбэр 100%-аас илүү

6.2 Хувиараа алт олборлогчдын осол гэмтэлд өртсөн байдал



Судалгаанд оролцсон нийт хувиараа алт олборлож байгаа иргэдийн осол гэмтэлд өртөж байсан эсэх талаар асуухад (Хүснэгт 6.3), 13.7 хувь нь өртөж байсан, 86.3 хувь нь үгүй гэж хариулжээ. Осол гэмтэлд өртсөн байдал ахимаг насны, эрэгтэй, алт олборлох ажлыг удаан хийсэн хүмүүсийн дунд бусад алт олборлогчдынхоос өндөр байна.

Хүснэгт 6.3 Судалгаанд хамрагдагчдын хувийн жин, хувиараа алт олборлох үедээ осол гэмтэлд өртөж байсан эсэх, сонгосон үзүүлэлтүүдээр

Сонгосон үзүүлэлтүүд	Хувиараа алт олборлох үедээ осол гэмтэлд өртөж байсан эсэх		Бүгд	ХАМО нарын тоо
	тийм	үгүй		
Насны бүлэг				
18-30	10.2	89.8	100.0	88
31-40	14.9	85.1	100.0	114
41-60	15.3	84.7	100.0	98
Хүйс				
Эрэгтэй	13.9	86.1	100.0	230
Эмэгтэй	12.9	87.1	100.0	70
Алт олборлосон хугацаа				
1-2 сар	12.1	87.9	100.0	116
3-4 сар	7.9	92.1	100.0	101
5-аас дээш сар	22.9	77.1	100.0	83
Жилд хувиараа алт олборлодог хоног				
25 хүртэл хоног	9.1	90.9	100.0	99
26-61 хоног	9.3	90.7	100.0	97
62, түүнээс олон хоног	22.1	77.9	100.0	104
Нийт алт олборлогчид	13.7	86.3	100.0	300

Тохиолдсон осол, гэмтлийн төрлүүдийг авч үзвэл (Зураг 6.1), шороонд дарагдах (69.8 хувь), нүхэнд унах (37.71 хувь), бэхэлгээний олс тасарч унах (16.7 хувь) зэрэг ослоуд

байгаа нь аюулгүй ажиллагааны дүрмийг мэдэхгүй болон мэдэж байсан ч баримталж ажилладаггүй хайхрамжгүй байдлаас голлон болсон (Зураг 6.2) байна.



Дээрхээс гадна алт олборлож буй газрын орчимд хүмүүсийн архидалт их байдаг ба түүнээсээ болж осол гэмтэлд өртөх тохиолдол их болсон талаар ХАМО нар төдийгүй нутгийн алт олборлодоггүй иргэд, эмнэлгийн ажилчид мэдээлж байв.


Шигтгээ 6.1:

.... Нинжа нарын дунд архидалт маш их байдаг. Саяхан нэг нинжа согтуугаар мотоциклтой явж байгаад унаж ухаан алдан ирсэн. Мөн алт ухаж байгаа газартаа архи уусан нинжа нар хоорондоо зодолдож, ухсан нүх рүүгээ унаж, хөл гараа гэмтээгээд ирдэг. Ер нь мөнгө л олж байвал хүний амь эрсдэх нь энгийн үзэгдэл болсон. Алт дагаад хүн чанар байхгүй болж, муу муухай зүйлүүдийг дагуулж байна...


Б эмэгтэй, сумын эмнэлгийн ажилтан

6.3 Эрүүл мэндийн үйлчилгээнд хамрагдалт ба хамрагдах боломж

Нийт судалгаанд оролцсон эрэгтэйчүүдийн 70.9 хувь, эмэгтэйчүүдийн 78.9 хувь нь эрүүл мэндийн талаар ямар нэгэн хүндрэл гарахад хамгийн түрүүнд эмнэлгийн байгууллагад ханддаг (Зураг 6.3) гэсэн нь зөв эх үүсвэртээ ханддагийг харуулж байна.



Харин хувиараа алт олборлож байх үед эмнэлгийн зүйлсийн хэрэгцээ гарвал, шаардлагатай эм тариагаа эрэгтэйчүүдийн 36.1 хувь нь, эмэгтэйчүүдийн 27.1 хувь нь сумын төвөөс авдаг гэсэн нь бусад төрлийн хариултаас өндөр хувьтай байна (Зураг 6.4). Түүнээс гадна, алт олборлогчдын гуравны нэг орчим (эрэгтэйчүүдийн 34.7 хувь, эмэгтэйчүүдийн 31.4 хувь) нь эмнэлгийн зүйлсийн хэрэгцээ гарахад гэр дэлгүүр, хамт ажиллагсад, явуулын хүмүүс зэрэг баталгаагүй эх үүсвэрүүдээс хэрэгцээ хангадаг нь анхаарал татаж байв.



Эрүүл мэндийн тусламж үйлчилгээг авахад ямар нэг саад бэрхшээл тулгардаг эсэхийг асуухад нийт судалгаанд оролцогчдын 33 хувь нь тулгардаг, 53.7 хувь нь үгүй, 13.3 хувь нь эрүүл мэндийн тусламж авах хэрэгцээ гарч байгаагүй гэж хариулсан байна. Саад бэрхшээл

тулгардаг гэж хариулагчдын хувь ахимаг насны, явуулын, эмэгтэй ХАМО нарын дунд илүүтэй байв.

Хүснэгт 6.4 Судалгаанд хамрагдагчдын хувийн жин, эрүүл мэндийн тусламж авахад бэрхшээл тулгардаг эсэх, хариулагчийн шинж байдлаар

Хариулагчийн шинж байдал	Эрүүл мэндийн тусламж авахад бэрхшээл тулгардаг эсэх			Бүгд	ХАМО нарын тоо
	Тийм	Үгүй	Тусламж авах хэрэгцээ гарч байгаагүй		
Насны бүлэг					
18-30	29.5	55.7	14.8	100.0	88
31-40	33.3	50.9	15.8	100.0	114
41-60	35.7	55.1	9.2	100.0	98
Хүйс					
Эрэгтэй	30.9	56.1	13.0	100.0	230
Эмэгтэй	40.0	45.7	14.3	100.0	70
Шилжилтийн байдал					
Явуулын	43.4	45.8	10.8	100.0	83
Суурин	29.0	56.7	14.3	100.0	217
Нийт алт олборлогчид	33.0	53.7	13.3	100.0	300

Эрүүл мэндийн тусламж авахад бэрхшээл тулгардаг гэж хариулсан алт олборлогчдоос ямар төрлийн бэрхшээлүүд тулгардгийг тодруулахад, эрүүл мэндийн тусламж авах зай хол (47.5 хувь), орон нутгийн харъяалалгүй (14.1 хувь), тээврийн хэрэгсэл дутмаг (12.1 хувь), эрүүл мэндийн даатгалд хамрагдаагүй (11.1 хувь), холбоо харилцаа хангалтгүй (10.1 хувь), мөнгөгүй (5.1 хувь) гэсэн шалтгаануудыг дурьдсан.

Алт олборлогчдын алт олборлож байх үед хамгийн хурднаар эмнэлгийн тусламж авах боломжтой дундаж хугацаа нь тэдний мэдээлснээр 4 цаг байгаа нь харьцангуй урт хугацаа байна. Энэхүү хугацааг явуулын, суурин ХАМО нар эмнэлгийн тусламж үзүүлэх ялгаатай эх үүсвэрүүдээр бодож (тухайлбал, зарим явуулын ХАМО нар Бигэрт бүртгэлгүй учраас өөрсдийн орон нутгийн эмнэлэг рүү явж тусламж авдаг байсан) хариулсан бөгөөд яг Бигэр сумын төвийн эмнэлгийн байгууллагаас тухайн алт олборлож буй газарт хүрэхэд саад бартаа ихтэй замаар 80-90 гаруй километр замыг туулан 2 цаг орчим хугацаанд очдог талаар эмнэлгийн ажилтан ярьж байсан.

Шигтгээ 6.2:

Алт олборлож эхэлсэнээс хойш гэмтэл бэртлийн тоо эрс нэмэгдсэн. Ажлын нөхцөл хүнд, хувийн ариун цэвэр сахихгүй байх, хэвийн хооллох дэглэм алдагдсанаас хоолны хордлого болсон, мөн бохирдолтоос болж гэмтэл нь идээлж бугалсан, зодолдож байгаад гар хөлөө хутгалан цус алдсан зэрэг тохиолдолууд их ирдэг. Шороонд дарагдаж нас барсан дуудлага ирээгүй боловч нас барсан гэсэн тохиолдолууд дуудлаж байсан. Бэлгийн замын халдварт өвчин байгаа эсэх нь оношлогдоогүй боловч алт олборлож буй газарт хэрэглэсэн бэлгэвч чихрийн цаасны хог шиг их байна. Яаралтай дуудлага 2 цагийн дотор очиж байгаа боловч алт олборлолтын оргил үед иргэд байршилаа сайн хэлээгүй, бие биенээ танихгүйгээс болоод цаг алдах бэрхшээл их байдаг. Алт олборлож байгаа жирэмсэн эмэгтэйчүүдийн хувьд цус алдаж, зулбах тохиолдол их байна. Манай эмнэлэгт тийм 5 дахь жирэмсэн эмэгтэй эмчлүүлж байна.

Г эмэгтэй, сумын эмнэлгийн ажилтан

МУ-д иргэн бүр эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг авах эрхтэй бөгөөд эрүүл мэндийн даатгалтай, түүнийхээ шимтгэлийг төлсөн байх тохиолдолд холбогдох хууль, журманд заагдсан эрүүл мэндийн үндсэн үйлчилгээнүүдийг үнэ төлбөргүйгээр авах боломжтой байдаг. Судалгаанд хамрагдсан ХАМО нараас эрүүл мэндийн даатгал (ЭМД)-д хамрагдсан эсэх талаар асуухад 65.3 хувь нь хамрагдсан, 34.7 хувь нь хамрагдаагүй гэж хариулсан байна (Хүснэгт 6.5). Гэвч иргэн хүн зөвхөн эрүүл мэндийн даатгалтай байх нь хангалтгүй бөгөөд түүнийхээ шимтгэлийг бүрэн төлсөн тохиолдолд эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг үнэ төлбөргүй авах эрх нь баталгаажна. Иймд, ЭМД-д хамрагдсан гэсэн ХАМО нарын хариултыг шалгах зорилгоор сүүлийн нэг жилийн ЭМД-ийн шимтгэлээ төлсөн эсэхийг нь асуухад, нийт ХАМО нарын 54.3 хувь нь л сүүлийн нэг жилийн хураамж нь төлөгдсөн ЭМД-тай буюу эрүүл мэндийн үйлчилгээг үнэ төлбөргүйгээр авахад бэлэн байдалтай байв. Иймд, МУ-ын иргэн бүр ЭМД-д заавал даатгуулах шаардлагатай гэсэн МУ-ын Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 6 дугаар зүйлийн хэрэгжилт ХАМО нарын дунд хангалтгүй байна. Даатгалд хамрагдаагүй алт олборлогчид ахимаг насны, эрэгтэй, явуулын, ядуу, алт олборлох ажлыг удаан хийсэн хүмүүсийн дунд бусдаас өндөр хувьтай байна.

Хүснэгт 6.5 Судалгаанд хамрагдагчдын хувийн жин, эрүүл мэндийн даатгалд хамрагдсан эсэх, сонгосон үзүүлэлтүүдээр

Сонгосон үзүүлэлтүүд	Эрүүл мэндийн даатгалд хамрагдсан эсэх		Бүгд	ХАМО нарын тоо
	Тийм	Үгүй		
Насны бүлэг				
18-30	64.8	35.2	100.0	88
31-40	62.3	37.7	100.0	114
41-60	69.4	30.6	100.0	98
Хүйс				
Эрэгтэй	66.1	33.9	100.0	230
Эмэгтэй	62.9	37.1	100.0	70
Шилжилтийн байдал				
Явуулын	50.6	49.4	100.0	83
Суурин	71.0	29.0	100.0	217
Өрхийн амьжиргааны түвшин				
Ядуу	60.0	40.0	100.0	180
Ядуу бус	73.3	26.7	100.0	120
Алт олборлосон хугацаа				
1-2 сар	73.3	26.7	100.0	116
3-4 сар	60.4	39.6	100.0	101
5, түүнээс дээш сар	60.2	39.8	100.0	83
Нийт алт олборлогчид	65.3	34.7	100.0	300

Эрүүл мэндийн даатгалд хамрагдаагүй хүмүүсээс даатгалд хамрагдаагүй шалтгааныг асуухад, мөнгөгүй, иргэний бичиг баримтгүй, яаж хамрагдахаа мэдэхгүй, завгүй, надад хэрэггүй гэсэн хариултуудыг өгчээ.

БҮЛЭГ 7. ХУВИАРАА АЛТ ОЛБОРЛОГЧДЫН НИЙГМИЙН ДААТГАЛД ХАМРАГДАЛТ, НИЙГМИЙН ХАЛАМЖИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХҮРТЭЭМЖ

Хувь хүний нийгмийн хамгааллын баталгаа болдог өөр нэг зүйл нь нийгмийн даатгалд хамрагдалт байдаг. Эдийн засгийн албан бус салбарт үйл ажиллагаа явуулж байгаа орлогыг нь тодорхойлох боломжгүй хувиараа алт олборлогчид нь хөдөлмөрийн чадвартай үедээ нийгмийн даатгалын төрөл бүрийн хэлбэрүүдэд сайн дураар даатгуулснаар, насан өтөл болох, үйлдвэрлэлийн осол, гэмтэлд өртөн хөдөлмөрийн чадвараа алдах, жирэмсэн болон амаржих, цаашилбал ажилгүй болохдоо ч төрөөс тэтгэвэр тэтгэмж авч амьжиргаагаа залгуулах боломжтой болдог. Энэхүү бүлэгт хэрэгцээтэй үедээ нийгмийн халамж, үйлчилгээг авах дээрх баталгаа хувиараа алт олборлогчдын дунд хэр бэлтгэгдсэн байгаа, түүнчлэн тэдний өрхөд нийгмийн халамж, үйлчилгээний ямар төрлүүд нэн шаардлагатай байгааг авч үзэх болно.

7.1 Хувиараа алт олборлогчдын нийгмийн даатгалд хамрагдалтын байдал

Бигэр суманд хувиараа алт олборлож буй нийт иргэдийн дунд алтнаас олсон орлогоос нийгмийн даатгалын шимтгэл төлдөг хүмүүсийн хувь маш хангалтгүй буюу дөнгөж 1.0 хувь (3 хүн) байна. Энэ үүднээсээ хувиараа алт олборлож буй иргэд нь аливаа эрсдэл тохиолдоход төрөөс нийгмийн дэмжлэг, халамж авах боломж хомс, бэлтгэгдээгүй байна. Тэрхүү 1.0 хувьд багтаж буй хүмүүс нь эрэгтэй, 41-ээс дааш насны, бүрэн дунд ба түүнээс дээш түвшингийн боловсролтой, суурин, алт олборлолтоос жилд олдог ашгийн хэмжээ нь өндөр бүлэгт багтах хүмүүс байгаа ба тэд сард дунджаар 16000 төгрөгийг нийгмийн даатгалын шимтгэлд төлдөг гэжээ.

Нийгмийн даатгалд хамрагдаагүй алт олборлогчдын нийгмийн даатгалын шимтгэл төлдөггүй шалтгааныг тодруулж үр дүнг хариулагчдын шинж байдлаар задлан Хүснэгт 7.1-д харуулав. Нийт хариултууд дотор өндөр хувь эзэлж байгаагаар нь дараалуулбал, хувиараа алт олборлогчдын нийгмийн даатгалын шимтгэл төлдөггүй шалтгаанууд нь мөнгөний боломжгүй (30.3 хувь), төлөх аргаа мэдэхгүй байгаа (30.0 хувь), нийгмийн даатгалд хамрагдахын ач холбогдлыг мэддэггүй (26.9 хувь), надад хэрэггүй (6.4 хувь), даатгалын байгууллагын үйлчилгээний хүнд суртлаас (5.1 хувь) болон завгүй (1.3 хувь) зэрэг болж байна. Эдгээрээс дүгнэхэд алт олборлогчдод нийгмийн даатгал, түүний ач холбогдол, түүнд хэрхэн хамрагдаж ашиглах зэрэг мэдлэг, мэдээллүүд маш хангалтгүй байгаа нь харагдаж байна.

Хариулагчдын шинж байдлаар харвал, нийгмийн даатгалын ач холбогдлыг мэдэхгүй хүмүүс эрэгтэй, боловсролын түвшин доогуур, явуулын хүмүүсийн дунд бусдаас илүүтэй байгаа ба шимтгэл төлөх аргаа мэдэхгүй байгаа хүмүүс 30-аас доош насны, эмэгтэй, суурин, ядуу өрхийн алт олборлогчдын дунд бусад бүлгийнхнээс өндөр хувьтай байдаг нь тус тус анхаарал татаж байна. Нийгмийн даатгал төлөх шаардлагатайг мэддэг ч мөнгөний боломжгүйгээсээ төлж чадахгүй байгаа хүмүүс голдуу 41-ээс дээш насны, эрэгтэй, явуулын, ядуу өрхийн, жилд алт олборлолтоос олдог ашиг нь бага бүлэгт багтах алт олборлогчид байлаа.

Хүснэгт 7.1 Нийгмийн даатгалд хамрагдаагүй алт олборлогчдын хувийн жин, нийгмийн даатгалын шимтгэл төлдөггүй шалтгаанаа нэрлэсэн байдал, хариулагчийн шинж байдлаар

Хариулагчийн шинж байдал	Нийгмийн даатгалын шимтгэл төлдөггүй шалтгаан						Бүгд	ХАМО нарын тоо
	Мөнгөний боломжгүй	НД-д хамрагдахын ач холбогдлыг мэдэхгүй	Төлөх аргаа мэдэхгүй	Даатгалын байгууллагын үйлчилгээний завгүй	Надад хэрэггүй			
Насны бүлэг								
18-30	19.5	28.7	37.9	5.7	0.0	8.0	100.0	87
31-40	29.8	21.9	28.1	8.8	3.5	7.9	100.0	114
41-60	40.6	31.3	25.0	0.0	0.0	3.1	100.0	96
Хүйс								
Эрэгтэй	31.7	28.6	27.3	6.2	1.3	4.8	100.0	227
Эмэгтэй	25.7	21.4	38.6	1.4	1.4	11.4	100.0	70
Боловсролын түвшин								
Бага/боловсролгүй	30.0	32.0	28.0	2.0	0.0	8.0	100.0	50
Бүрэн бус дунд	29.3	26.7	29.3	5.3	4.0	5.3	100.0	75
Бүрэн дунд	31.0	23.8	35.7	4.0	0.0	5.6	100.0	126
Тусгай мэргэж./дээд	30.4	30.4	17.4	10.9	2.2	8.7	100.0	46
Шилжилтийн байдал								
Явуулын	32.5	28.9	13.3	13.3	3.6	8.4	100.0	83
Суурин	29.4	26.2	36.4	1.9	0.5	5.6	100.0	214
Өрхийн амьжиргааны түвшин								
Ядуу	33.1	24.7	31.5	3.9	1.1	5.6	100.0	178
Ядуу бус	26.1	30.3	27.7	6.7	1.7	7.6	100.0	119
Алт олборлолтоос жилд олдог ашиг								
Алдагдалтай	28.6	10.2	55.1	0.0	0.0	6.1	100.0	49
600,000 хүртэл төгрөг	33.3	23.7	36.6	2.2	0.0	4.3	100.0	93
600,001-3,000,000 төгр	32.6	26.7	19.8	12.8	1.2	7.0	100.0	86
3,000,001+ төгрөг	24.6	43.5	15.9	2.9	4.3	8.7	100.0	69
Нийт алт олборлогчид	30.3	26.9	30.0	5.1	1.3	6.4	100.0	297

7.2 Хувиараа алт олборлогчдын өрхийн гишүүдийн нийгмийн даатгал, нийгмийн халамжийн үйлчилгээний эрэлт хэрэгцээ

Судалгаанд хамрагдсан ХАМО нараас өөрт нь болон өрхийн гишүүдэд нь нийгмийн даатгал, нийгмийн халамжийн ямар нэг үйлчилгээ хэрэгцээтэй байгаа эсэхийг асуухад нийт хариулагчдын 43.7 хувь нь “тийм” гэж хариулсан байна. Ийм үйлчилгээ хэрэгцээтэй байгаа ХАМО нар нь ахимаг насны, эмэгтэй, явуулын, насанд хүрээгүй олон хүүхэдтэй өрхийн, алт олборлолтоос өнгөрсөн жилд ашиг олж чадаагүй, алдагдалтай ажилласан алт олборлогчдын дунд бусад бүлгийнхнээсээ өндөр хувьтай байв.

Чухам ямар төрлийн нийгмийн даатгал, нийгмийн халамжийн үйлчилгээнүүд дээрх алт олборлогчдод болон тэдний өрхөд хэрэгцээтэй байгааг Зураг 7.1-д харуулав.





Зургаас харахад, хувиараа алт олборлогчид өөртөө болон өрхдөө хамгийн их хэрэгцээтэй байгаа гол 3 нийгмийн үйлчилгээнүүдэд эх, хүүхдийн мөнгөн тэтгэмж (ядуу өрхийн алт олборлогчдын 33.3 хувь, ядуу бус өрхийн алт олборлогчдын 47.2 хувь); ажилгүйдлийн тэтгэмж (ядуу өрхийн алт олборлогчдын 33.3 хувь, ядуу бус өрхийн алт олборлогчдын 26.4 хувь); эмзэг бүлгийн амьжиргаанд дэмжлэг үзүүлэх тэтгэмж (ядуу өрхийн алт олборлогчдын 21.8 хувь, ядуу бус өрхийн алт олборлогчдын 24.5 хувь)-үүдийг нэрлэжээ. Эдгээр 3 төрлийн тэтгэмж нь алт олборлогчийн өрхийн амьжиргааны түвшингээс онц хамааралгүйгээр аль аль өрхийнх нь хувьд нэн хэрэгцээтэй үйлчилгээнүүд аж. Дээрхээс гадна хөдөлмөрийн чадвар түр алдсаны, үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалах өвчний, өндөр настны, жирэмсний ба амаржсаны, тэжээгчээ алдсаны зэрэг тэтгэмжүүдэд хамрагдах шаардлагатай боловч хамрагдаж чадаагүй байгаа хүмүүс хувиараа алт олборлогчдын өрхүүдэд байгаа юм байна. Эндээс дүгнэхэд нийгмийн даатгал, нийгмийн халамжийн үйлчилгээний хүртээмж хувиараа алт олборлогчдын өрхүүдэд төдийлөн бүрэн гүйцэт хүрдэггүй нь харагдлаа.

БҮЛЭГ 8. ХУВИАРАА АЛТ ОЛБОРЛОГЧДЫН ХӨДӨЛМӨРИЙН ОРЧИН

Энэхүү бүлэгт Бигэр суманд хувиараа алт олборлож буй иргэдийн ажиллаж буй газарт ямар хүрээний “жигжиг зах зээл” бий болоод байгаа, мөн тэр орчин дахь гэмт хэрэг, зөрчлийн байдал, хувиараа алт олборлогчид ба бусад талуудын хоорондын харилцааны талаар авч үзэх болно.

8.1 Хувиараа алт олборлож буй газар дахь үйлчилгээнүүд

Иргэд олон тоогоороо бөөгнөрөн ажиллах болсноор ХАМО нарын ажилладаг газрын орчимд алт олборлогчдод үйлчилдэг тодорхой үйлчилгээнүүд дагалдан бий болсон байна. Зураг 8.1-д Бигэр сумын хувиараа алт олборлолт явагдаж буй газрын орчимд байдаг үйлчилгээнүүдийг төрлөөр нь харуулав.



Жич: Хариулт олон сонголттой тул хувийн жингийн нийлбэр 100%-аас илүү

Хувиараа алт олборлогчдын мэдээлснээр алт олборлож буй газрын орчимд дэлгүүр/ТҮЦ ажиллуулах (70.3 хувь), шатахуун нийлүүлэх (30.3 хувь), хүн тээвэрлэх (13.7 хувь), хоол

хийж зарах (10.7 хувь), багаж хэрэгсэл засварлах /түрээслэх (8 хувь), задгай наймаа хийх зэрэг хүмүүст ил тодоор үйлчилдэг олон төрлийн үйлчилгээнүүд бий болсон байна.

Баянхонгор аймгаас алт олборлогчид хүн тээврийн үйлчилгээгээр Бигэрт ирсэн байгаа нь...



Эх үүсвэр: ОБЕГ, ЗДТГ БОАЖГ 2009 он

Үүний зэрэгцээгээр далд байдлаар, өөрөөр хэлбэл цагдаа, эмч нарт мэдэгдэхгүйгээр тэнд ажиллагчдад хувийн үйлчилгээ буюу биеэ үнэлэх үйлчилгээ үзүүлдэг хүмүүс мөн байдаг тухай судалгаанд хамрагдсан алт олборлогчдын 24.7 хувь мэдээлсэн нь анхаарал татаж байна. Алт олборлогчдын ярьж байснаар тэдгээр нь хувиараа алт олборлогчдын олборлосон алтаар төлөөс аван биеэ үнэлдэг эмэгтэйчүүд байв. Ийм үзэгдэл түгээмэл байх нь алт олборлогчдын гэр бүлийн тогтвортой байдал алдагдах, түүнчлэн бэлгийн замын халдварт өвчин хүмүүсийн дунд тархах зэрэг олон сөрөг үр дагаврууд бий болоход хүргэж болох тул энэ асуудлыг зохих мэргэжлийн хүмүүс анхаарал хяналтандаа авч зохицуулах нь зүйтэй юм.

Шигтгээ 8.1:

Манай суманд алт гарснаасаа хойш олон муу зүйлийг дагуулж байна. Үүний нэг нь биеэ үнэлэгчид их ирсэн. Тэд “лангийн”, “цэнгийн”, “пунгийн” гэж ангилагддаг юм байна лээ. Ямар хүүхнүүд байдгийг нь сонирхоод харсан чинь “хөөрхөн” л охидууд байна лээ. Тэд үнэ ханииндаа таарсан машиин, унаанд суух жишээтэй. Хүмүүс энд бэлгэвч их хэрэгцээтэй байдаг юм гэдэг шүү дээ. Хаясан хогны дийлэнх нь л савласан усны сав, бэлгэвч байдаг ш дээ...

Х, эрэгтэй, 38 настай, алт олборлогч

Зураг 8.2-т ХАМО нарт ажиллаж буй газарт нь хамгийн их хэрэгцээтэй байгаа зүйл/үйлчилгээнүүд юу байдгийг гаргаж харууллаа. Зургаас, өнөөгийн нөхцөлд Бигэр

суманд хувиараа алт олборлолт явагдаж буй газрын орчимд хүмүүст ундны усны асуудал хамгийн бэрхшээлтэй байдаг нь харагдаж байна. Өөрөөр хэлбэл, нийт хариулагчдын талаас илүү хувь нь ундны ус нийлүүлэх үйлчилгээг хамгийн хэрэгцээтэй байна гэж мэдээлжээ. Үүнээс гадна, жорлон, хогийн цэг (42.3 хувь), халуун ус (32 хувь), цахилгаан (31.7 хувь) зэргийг харьцангуй олон алт олборлогчид хэрэгцээтэй байна гэж мэдээлсэн нь хувиараа алт олборлолт явагдаж буй газарт ариун цэврийн асуудал мөн нэн хүнд байдгийг харуулж байна.

Шигтгээ 8.2:

Манай нутаг говийн бүсэд багтдаг, хур бороо багатай, гол, нуур, цөөрөм цөөн бөгөөд нутгийн иргэд ахуйн хэрэгцээгээ цөөн тооны хэдэн худгийн усаар хангадаг. Ялангуяа хүмүүсийн хувиараа алт ухаж байгаа Сэрхийн нуруу орчимд ус гээд байх юм бараг байхгүй. Иймд, зарим хүмүүс тийшээ ус аваачиж зардаг ба алтны газарт хүн их байх үед худгийн ус литр нь 1500 төгрөг хүрэх тохиолдол байсан. Үйлдвэрийн савласан ус нь бүүр ч үнэтэй зарагддаг.

М, эрэгтэй, байгаль орчны байцаагч

Говь-Алтай аймгийн Бигэр сумын алт олборлож буй газар дахь ахуйн хог хаягдал...



Эх үүсвэр: ОБЕГ, ЗДТГ БОАЖГ 2009 он

Алт олборлох явцад осол гэмтэл гарахад тэр дор нь ядаж анхны тусламж үзүүлэх мэргэжлийн нэгж тухайн газарт байгаагүй ба ийм нэгж болон эмийн сан зэргийг оролцуулан эмнэлгийн чиглэлийн үйлчилгээний цэг байгаасай гэж алт олборлогчдын 30.3 хувь нь мөн хүсч байв.

Дээрх зүйлсээс гадна багаж хэрэгсэл засварлах, түрээслэх үйлчилгээ, дэлгүүр, хоолны цэг, тогтмол хэвлэл, банкны үйлчилгээ, тээврийн үйлчилгээ зэргийг алт олборлож буй газрын орчимд хамгийн хэрэгцээтэй зүйлс гэж алт олборлогчид үзэж байна.

8.2 Хувиараа алт олборлож буй газар дахь гэмт хэрэг, зөрчлийн байдал

Олон хүн нэг дор цуглан ижил үйл ажиллагаа явуулж байгаа хувиараа алт олборлож буй газруудад гэмт хэрэг, зөрчил гарах нь элбэг. Бигэр суманд алт олборлож буй газруудад элдэв гэмт хэрэг, зөрчил хэр түгээмэл гардагийг авч үзэхэд (Хүснэгт 8.1), нийт алт олборлогчдын 37.3 хувь нь байнга, 48 хувь нь заримдаа, 11.3 хувь нь ховор гардаг, 3.3 хувь нь гардаггүй гэж мэдээлэв.

Тухайн алт олборлогчдыг жилд хичнээн хоног алт олборлох газарт ажилладгаар нь ялгаж, дээрх асуултад хариулсан байдлыг харвал, алт олборлодог газарт олон хоног (жилийн 62-оос дээш)-ийг өнгөрөөдөг хүмүүс цөөн хоног ажилладаг хүмүүсээс илүүтэйгээр гэмт хэрэг, зөрчил байнга гардаг гэж хариулсан нь Бигэрийн алт олборлож буй газарт гэмт хэрэг, зөрчил их гардаг болохыг баталгаажуулж байна.

Хүснэгт 8.1 Судалгаанд хамрагдагчдын хувийн жин, алт олборлож буй газар дахь гэмт хэрэг, зөрчлийн талаар мэдээлсэн байдал, жилд алт олборлодог хоногоор

Алт олборлож буй газар дахь гэмт хэрэг, зөрчлийн талаар мэдээлсэн байдал	Жилд алт олборлодог хоног			Нийт алт олборлогчид
	25 хүртэл хоног	26-61 хоног	62+ хоног	
Гэмт хэрэг зөрчил хэр түгээмэл гардаг эсэх				
Байнга	23.2	35.1	52.9	37.3
Заримдаа	61.6	52.6	30.8	48.0
Ховор	11.1	10.3	12.5	11.3
Огт гардаггүй	4.0	2.1	3.8	3.3
Бүгд	100.0	100.0	100.0	100.0
ХАМО нарын тоо	99	97	104	300
Гардаг гэмт хэрэг, зөрчлийн төрөл				
Хулгай	62.1	56.8	65.0	61.4
Хэрүүл маргаан, зодоон цохион	36.8	43.2	56.0	45.5
Дээрэм	12.6	15.8	53.0	27.6
Биеэ үнэлэлт	13.7	13.7	31.0	19.7
Гэмт хэрэг, зөрчил гардаг гэж мэдээлсэн ХАМО нарын тоо *	95	95	100	290

* Хариулт олон сонголттой тул хувийн жингийн нийлбэр 100%-аас илүү

Алт олборлож буй газарт элбэг гардаг гэж мэдээлсэн гэмт хэрэг, зөрчлүүдийн төрлийг авч үзвэл, давхардсан тоогоор хариулагчдын 61.4 хувь нь хулгай, 45.5 хувь нь хэрүүл маргаан, зодоон цохион, 27.6 хувь нь дээрэм, 19.7 нь биеэ үнэлэх гэмт хэргүүд гардаг гэжээ. Эдгээр төрлийн гэмт хэргүүдийг хамгийн их гардаг гэж мэдээлэгчдийн хувийн жин жилд олон хоногоор алт олборлох газарт ажилладаг хүмүүсийн дунд цөөн хоногоор ажиллагсдынхаас илүү өндөр байна.

Алт олборлогчид нь зөвхөн алт олборлож буй газарт гэмт хэрэг зөрчил гаргаад зогсохгүй, сумын бусад нутаг дэвсгэрт ч зөрчил гаргах байдал нэмэгдэж байгаа талаар нутгийн иргэдтэй хийсэн ярилцлагын явцад хүмүүс мэдээлж байв.

Шигтгээ 8.3:

Манайх урьд нь их тайван сум байлаа. Ганц нэг орон гэрийн, малын хулгай гарсан гэж сонсогддог байсан. Алт олборлолт эхэлсэнээс хойш айлуудын мотоцикль хулгайд алдагдах, айлын амбаар сав, өвөлжөө ухан, хатаасан борц хулгайлах тохиолдол их гарах болсон. Мөн архи их уусан хүнд алт олддог гэсэн нинжа нарын дундах буруу ойлголтоос болж архидалт маш их болсон. Мөн алт олохоороо тэрийгээ тэмдэглэж архи ууна. Хэдэн тонноор нь архи ачиж ирнэ, тэр нь ямар ч баталгаагүй архи байдаг. Хууль дүрмэнд захирагдах гэсэн юм бараг байхгүй.

Э, эрэгтэй 42 настай, нутгийн иргэн

8.3 Хувиараа алт олборлогчид ба бусад талуудын хоорондын маргаан, зөрчилдөөн

Зөвшөөрөгдөөгүй газар нутагт зохион байгуулалтад оролгүйгээр үйл ажиллагаа явуулж байгаа ХАМО нар нийгмийн янз бүрийн бүлгийнхэнтэй маргаан зөрчилдөөнтэй байх тохиолдол элбэг. Говь-Алтай аймгийн Бигэр суман дахь ХАМО нарын хувьд ийм асуудал хэр түгээмэл гардаг талаар бид судалгаандаа асуусан ба үр дүнг Хүснэгт 8.2-т харуулав.

Хүснэгт 8.2 Судалгаанд хамрагдагчдын хувийн жин, алт олборлогчид болон бусад талуудын хоорондох маргаан зөрчилдөөнийг мэдээлсэн байдал, жилд алт олборлодог хоногоор


Алт олборлогчид болон бусад талуудын хооронд маргаан зөрчилдөөн хэр түгээмэл гардаг эсэх	Жилд алт олборлодог хоног			Нийт алт олборлогчид
	25 хүртэл хоног	26-61 хоног	62+ хоног	
Байнга	31.3	39.2	60.6	44.0
Заримдаа	49.5	45.4	27.9	40.7
Ховор	13.1	8.2	9.6	10.3
Огт гардаггүй	0.0	1.0	0.0	0.3
Мэдэхгүй	6.1	6.2	1.9	4.7
Бүгд	100.0	100.0	100.0	100.0
ХАМО нарын тоо	99	97	104	300
Алт олборлогчидтой маргаан, зөрчилдөөнтэй байдаг байгууллага, хүмүүс				
Цагдаа, харуул хамгаалалтын ажилтнууд	88.2	77.8	84.3	83.5
Засаг захиргаа	50.5	42.2	31.4	41.1
Нутгийн малчид	32.3	24.4	33.3	30.2
Алт олборлогчид хоорондоо	25.8	20.0	31.4	26.0
Маргаан, зөрчилдөөн гардаг гэж мэдээлсэн ХАМО нарын тоо *	93	90	102	285

* Хариулт олон сонголттой тул хувийн жингийн нийлбэр 100%-аас илүү

Судалгаанд хамрагдсан нийт ХАМО нар бараг бүгдээрээ буюу 95 хувь нь Бигэр суманд ажиллаж буй хувиараа алт олборлогчид болон бусад талуудын хооронд тодорхой маргаан, зөрчилдөөн гардаг гэж хариулжээ. Маргаан зөрчилдөөн байнга гардаг гэж хариулагчид 44 хувийг эзэлж байгаа нь “заримдаа гардаг”, эсвэл “ховор гардаг” гэсэн хариултыг өгсөн хүмүүсээс 3.3-13.7 пунктээр илүү байгаа, түүнчлэн жилд бусдаасаа олон хоногоор алт олборлох газарт ажиллаж өнгөрөөдөг хүмүүсийн 60.6 хувь нь маргаан, зөрчилдөөн “байнга гардаг” гэснээс дүгнэхэд Бигэрт иймэрхүү маргаан, зөрчилдөөн нэлээд их гардаг гэж үзэж болохоор байна.

Хувиараа алт олборлогчид ямар бүлгийнхэнтэй илүүтэй маргаан, зөрчилдөөнтэй байдгийг авч үзэхэд, давхардсан тоогоор хариулагчдын 83.5 хувь нь цагдаа, харуул хамгаалалтын ажилтнуудтай, 41.1 хувь нь засаг захиргааны байгууллагатай, 30.2 хувь нь нутгийн малчидтай, түүнчлэн 26.0 хувь нь алт олборлогчид хоорондоо бас маргаан, зөрчилдөөн гаргах нь их гэж хариулсан байна.

Дээрх бүлгүүдийн хооронд эрх, үүрэг, ашиг, сонирхлын чухам ямар маргаан зөрчилдөөн түгээмэл болдог талаарх мэдээллийг Зураг 8.3-т харуулав.



Давхардсан тоогоор, алт олборлогчид бусад бүлгүүдтэй ямар нэгэн байдлаар маргаан, зөрчилдөөнтэй байдаг гэж мэдээлсэн нийт хариулагчдын 41.1 хувь нь бүлгүүдийн хоорондох маргаан, зөрчилдөөн “байгаль орчны сүйдэл, нөхөн сэргээлт”-ийн асуудалтай холбоотой, 41.1 хувь нь “хувиараа алт олборлох зөвшөөрөл”-ийн асуудалтай, 40.4 хувь нь “бэлчээр”-ийн асуудалтай холбоотой гэж хариулсан нь бусад төрлийн маргаан зөрчилдөөнийг мэдээлсэн хариулагчдаас өндөр хувьтай байна.

Шигтгээ 8.4:

Хаа сайгүй газар ухаж, зам гаргаж, заг бутлаг ургамал, бэлчээр байхгүй болж ус бохирдуулж, хог хаягдал асар их, хулгай туйлдаа хүрч байна. Заг гэдэг ургамал ургахаа больсноос цөлжилт явагдаж, айлын мал ХАМО нарын ухсан нүхэнд нь унаж үхэж, хүн шороонд дарагдэж үхвэл сумын цагдаад мэдэгдэхгүй чимээгүй аваад л явдаг гэх мэтээр хүн чанар үгүй болж байна. Цаад хор хохирлыг нь бодож байгаа хүн нэг ч алга, сумын иргэд дунд нь хохирч байна. Нутгийн иргэд бид амар тайван амьдармаар байна.

М, эрэгтэй, 40 настай, малчин

Дээрх маргаан, зөрчилдөөний үед ХАМО нарын хувь хүний эрх ихээхэн зөрчигддөг тухай ХАМО нар олноор мэдээлж байсан.

Шигтгээ 8.5:

Би Өвөрхангай аймгийн Нарийнтээл сумаас ирсэн. Энд хамгаалалтын албаныхан машин эвдэж, хүн гарт нь өртөх юм бол эр, эм хайхрахгүйгээр зоддог, дэндүү боловсролгүй, утсаа гаргаад ир гэж байгаад, гаргахаар нь симийг нь зажлуулдаг, утсыг нь дэвсдэг, толгой дундуур нь бороохойддог. Би гэхэд 9-н удаа баригдаж, 3-н удаа зодуулж байсан..

С, эрэгтэй, 52 настай, ХАМО

Шигтгээ 8.6:

Би Баянхонгор аймгаас өвчтэй хүүхдийнхээ эмчилгээний мөнгийг олохоор ирсэн. Гэтэл харуул хамгаалалтын ажилчид эр, эмгүй зодож, хөөдөг учраас тэднээс зугтаж өдрийн цагаар эргүүл хийгээд ирэхэд нь уулын аманд машин явж хүрэхээргүй газар нуугдаж байгаад бүрэнхий болох үед алтны гарцтай газар руу явдаг. Зарим тохиолдолд тэр газраа хүрэх гэж 4 км ч хүртэл алхах ч олонтой шүү дээ. Нэг бодлын бид чинь хулгайч хүн шиг л байх юм.

Э, эмэгтэй, 38 настай, ХАМО

Маргаан, зөрчилдөөний үеэр зөвхөн ХАМО нар төдийгүй, албан үүргээ гүйцэтгэж яваа харуул хамгаалалтын ажилтнуудын эрх ч багагүй зөрчигддөг талаар биднийг судалгааны мэдээлэл цуглуулах үед мөн албаны хүмүүс ярьж байв.

Шигтгээ 8.7:

Саяхан, 2-р сард ажил үүргээ гүйцэтгэж явсан цагдаагийн ажилтанд алт олборлож байгаа иргэд эсэргүүцэл үзүүлж, чулуу шидэн, нүдэнд нь хүнд гэмтэл учруулсан тохиолдол гарсан. Тэр цагдаа аймагт эмчлүүлэхээр очсон ч аймгийн түвшинд эмчлэх боломжгүй гээд, хот руу явуулсан байна лээ... Мөн хууль бусаар алт олборлогч иргэдийг хөөж тарааснаар алтаа ухуулсангүй гэж тус аймгаас Улаанбаатар хот руу явж байгаа хүн тээврийн машины цонхыг хагалах, жолооч болон зорчигчдыг нь айлган сүрдүүлэх, зодох зэрэг үйлдлүүд хэд хэдэн удаа гарсан

Н. эмэгтэй, нутгийн захиргааны ажилтан

Дээрхээс дүгнэхэд, бичил уурхай эрхлэх хууль эрх зүйн орчныг нэн яаралтай бүрдүүлэхгүй бол иргэд, хууль хяналтын байгууллагын хооронд томоохон хэмжээний үймээн гарах эрсдэл өндөр байгаа нь ХАМО иргэд болон аймаг, сумын удирдах албан тушаалтнуудын аль алинтай уулзсан уулзалт, ярилцлагуудаас ажиглагдаж байлаа.

Нэг талаас авч үзэхэд орон нутгуудад ажлын байр хомс, хүмүүсийн цалин орлогын түвшин доогуур, ядуурал их учраас амьжиргаандаа нэмэр болгох үүднээс аргагүйн эрхэнд хийж байгаа хувиараа алт олборлогчдын ажлыг буруутгах аргагүй. Гэвч тэд өөрсдийн ашиг сонирхлыг хангахдаа хүрээлэн буй орчин, нийгмийн бусад бүлгийнхний эрх ашгийг хөндөж эрхгүй тул алт олборлох ажиллагаагаа зохион байгуулалтад оруулж, тодорхой хариуцлага хүлээж байж үйл ажиллагаа явуулах нь зүйтэй гэж үзэж байна.

БҮЛЭГ 9. ХУВИАРАА АЛТ ОЛБОРЛОГЧДЫН ЗОХИОН БАЙГУУЛАЛТ, ХАМТЫН АЖИЛЛАГАА

Хувиараа алт олборлох үйл ажиллагааг зохицуулах талаар Монгол улсын төрөөс явуулж буй арга хэмжээнүүдийн нэг нь тэднийг нөхөрлөлийн зохион байгуулалтад оруулах үйл ажиллагаа⁷ бөгөөд ингэснээр хувиараа алт олборлолтын эерэг үр нөлөөг хуулиар баталгаажуулан дэмжиж, сөрөг үр нөлөөг багасгах боломжтой гэж үзэж байгаа юм. Өнөөгийн байдлаар алт олборлогчдыг нөхөрлөл хэлбэрээр зохион байгуулан ажиллуулах явдал эхлэл төдий чанартай байгаа ба хувиараа алт олборлолт явагдаж байгаа Монгол улсын нутаг дэвсгэрүүдэд ажил хэрэг болгож чадаагүй байна. Энэхүү бүлэгт Бигэрт ажиллаж буй хувиараа алт олборлогчдын ажлын зохион байгуулалт, эрх ашгийн хамгаалалт, хувиараа ашигт малтмал олборлогч иргэдийн үйл ажиллагааг зохицуулах түр журмын талаарх мэдээлэл авсан байдал зэргийг дэлгэрэнгүйгээр авч үзэх болно.


9.1 Хувиараа алт олборлогчдын ажлын зохион байгуулалт

Бигэр суманд хувиараа алт олборлож буй иргэд албан байдлаар зохион байгуулалтад ороогүй ч гэсэн тэдний 85.3 хувь нь алт олборлохдоо хэн нэгэнтэй хамтран бүлэг болж ажилладаг болох нь судалгаанаас харагдлаа. Нийт хариулагчдын 14.7 хувь нь алт олборлохдоо бусадтай бүлэг бололгүй ганцаараа ажилладаг гэсэн ба үүнийхээ шалтгааныг хамтрах санаа нийлсэн хүмүүс байхгүй (63.6 хувь), олуулаа ажиллахад ашгаа хуваах тал дээр асуудалтай (36.4 хувь) гэж тайлбарласан байна.

Алт олборлохдоо бусадтай хамтардаг хариулагчдын хэнтэй хамтран ажилладгийг харвал, 55.1 хувь нь гэр бүлийн гишүүд, хамаатнуудтайгаа, 23 хувь нь найзуудтайгаа, 19.9 хувь нь нутгийн хүмүүстэйгээ, үлдсэн 2 хувь нь өөртөө хамааралгүй, танил хүмүүстэй баг болон хамтарч ажилладаг гэжээ. Гэр бүл, хамаатантайгаа ажиллахыг илүүд үзэх байдал эмэгтэйчүүдийн дунд эрэгтэйчүүдийнхээс өндөр (эмэгтэйчүүдийн 79.3 хувь, эрэгтэйчүүдийн 48.0 хувь) байхад найзуудтайгаа хамтран ажиллах сонирхол эрэгтэйчүүдийн дунд эмэгтэйчүүдийнхээс өндөр (эрэгтэйчүүдийн 27.7 хувь, эмэгтэйчүүдийн 6.9 хувь) байв.

Алт олборлохдоо бусадтай хамтран ажилладаг хариулагчдын хамтарч олсон ашгаа хэрхэн хуваадгийг сонирхоход 96.5 хувь нь тэгш хуваадаг (Зураг 9.1) гэсэн ба ашиг хуваах аргадаа хэн нэгэнтэй хамтран ажилладаг нийт хариулагчид бүгд (100 хувь) сэтгэл хангалуун байдаг гэж мэдээлсэн байна. Эндээс харахад, хувиараа алт олборлогчдыг албан ёсны нөхөрлөлийн зохион байгуулалтад оруулахад тэдний хөдөлмөр хуваарилалт, ашгаа хуваах асуудалд бэрхшээл гарахгүй байж болох нь харагдаж байна.

⁷ МУ-ын засгийн газраас хувиараа ашигт малтмал олборлож байгаа иргэдийн үйл ажиллагааг зохицуулах чиглэлээр хэд хэдэн эрх зүйн актыг батлан гаргасан ба тэдгээрээс *Хувиараа ашигт малтмал олборлож байгаа иргэдийн үйл ажиллагааг зохицуулах түр журам* (ЗГ-ийн 2008 оны 72-р тогтоол) –аар ХАМО иргэдийг бүртгэгдээгүй нөхөрлөл-ийн зохион байгуулалтад оруулах асуудлыг зохицуулж байна.



Зураг 9.2-г судалгаанд хамрагдагчдын алт олборлоход бусадтай хамтран ажиллахын давуу талын талаарх үзэл бодлыг харуулав.



Хувиараа алт олборлогчдын үзэж байгаагаар, алт олборлохдоо хүмүүстэй гал болон хамтран ажиллах нь нэн түрүүнд хөдөлмөр хөнгөвчилдөг (75.3 хувь), багаж хэрэгслээ дундаа хэрэглэж болдог (27 хувь), аюулгүй байдал сайжирч (12.7 хувь), орлого нэмэгддэг (12.3 хувь) зэрэг олон давуу талтай байна. Үүнээс гадна, давуу тал байхгүй гэж судалгаанд оролцогчдын 9.7 хувь нь хариулсан ч алт олборлогчдын дийлэнх нь сул талаасаа илүү давуу талтай гэсэн үнэлгээг гаргасан байна.

9.2 Хувиараа алт олборлогчдын эрх ашгийн хамгаалалт

Хувиараа алт олборлогчид хэдийгээр албан бус салбарт үйл ажиллагаа явуулж байгаа ч өрхийн амьжиргаагаа залгуулахын тулд явж байгаа, мөн нийгмийн иргэн хүн гэдэг утгаараа нийгэм, эдийн засаг, улс төрийн хамгаалуулбал зохих бүх эрхээ эдлэх эрхтэй. Судалгаагаар бид алт олборлогчдын ямарваа нэг эрх ашгийг хамгаалан, тэдэнд хүрч ажилладаг байгууллага, хувь хүн байгаа эсэхийг асуухад нийт алт олборлогчдын 95 хувь нь бидний эрх ашгийг хэн ч хамгаалдаггүй гэж хэлжээ. Эрх ашгийг нь хэн нэгэн хамгаалдаг гэж үзэж буй хариулагчид тухайн эрх ашгийг нь хамгаалагч байгууллага, хүмүүст иргэний хөдөлгөөн (2.7 хувь), төрийн бус байгууллага (1.0 хувь), сумын засаг захиргааны байгууллага (1 хувь), улс төрийн нам (0.3 хувь) зэргийг багтаасан байна.

Дээрх байгууллага, хүмүүс алт олборлогчдод хэрхэн хүрч ажилладгийг тодруулбал, Хувиараа ашигт малтмал олборлогч (ХАМО) иргэдийн дуу хоолойг дэмждэг, эрүүл мэндийн үйлчилгээнд хамрагдахад тусалдаг, нийгмийн асуудлыг шийдэхэд тусалдаг, өрхийн орлого нэмэгдүүлэхэд тусалдаг, сургалт, сурталчилгааны ажил явуулдаг зэрэг мэдээллийг өглөө.

9.3 Хувиараа ашигт малтмал олборлогч иргэдийн үйл ажиллагааг зохицуулах түр журмын талаарх мэдээлэл авсан байдал

Бигэр суманд ажиллаж байгаа хувиараа алт олборлогчдоос 2008 онд МУ-ын Засгийн газраас батлагдан хэрэгжиж буй “Хувиараа ашигт малтмал олборлох үйл ажиллагааг зохицуулах Засгийн газрын түр журам” (цаашид “Түр журам” гэж нэрлэсэн)-ын талаар болон түүнд өгүүлсэн ХАМО иргэдийн бүртгэгдээгүй нөхөрлөлийн талаар сонссон эсэхийг бид судалгаагаараа асуусан ба үр дүнг хариулагчдын шинж байдлаар ялган Хүснэгт 9.1-д харуулав.

Хүснэгт 9.1 Судалгаанд хамрагдагчдын хувийн жин, ХАМО үйл ажиллагааг зохицуулах ЗГ-ын түр журамын талаар сонссон эсэх, хариулагчийн шинж байдлаар

Хариулагчийн шинж байдал	Түр журмын талаар сонссон эсэх		Бүртгэгдээгүй нөхөрлөлийн талаар сонссон эсэх		Бүгд	ХАМО нарын тоо
	тийм	үгүй	тийм	үгүй		
Насны бүлэг						
18-30	67.0	33.0	64.8	35.2	100.0	88
31-40	67.5	32.5	72.8	27.2	100.0	114
41-60	77.6	22.4	75.5	24.5	100.0	98
Хүйс						
Эрэгтэй	73.5	26.5	72.6	27.4	100.0	230
Эмэгтэй	61.4	38.6	67.1	32.9	100.0	70
Шилжилтийн байдал						
Явуулын	62.7	37.3	66.3	33.7	100.0	83
Суурин	73.7	26.3	73.3	26.7	100.0	217
Алт олборлосон хугацаа						
1-2 сар	67.2	32.8	69.8	30.2	100.0	116
3-4 сар	71.3	28.7	72.3	27.7	100.0	101
5 буюу түүнээс дээш сар	74.7	25.3	72.3	27.7	100.0	83
Нийт	70.7	29.3	71.3	28.7	100.0	300

Хүснэгтээс харахад, давхардсан тоогоор нийт хувиараа алт олборлогчдын 70.7 хувь нь *Түүр журам*-ын талаар ямар нэг байдлаар сонссон байсан ба асуултыг “нөхөрлөл”-ийн талаар сонссон уу гэсэн өөр хэлбэрээр тавихад 71.3 хувь нь сонссон гэж хариулжээ. Эдгээрийн талаар мэдээлэл авсан байдал хариулагчдын нас ахих тусам нэмэгдэж байгаа ба эрэгтэйчүүдийн хувьд эмэгтэйчүүдээс илүү, суурин хүмүүс явуулын хүмүүсээс илүү, хувиараа алт олборлох ажлыг удаан хийсэн хүмүүс алт олборлоод удаагүй байгаа хүмүүсээсээ илүү мэдээлэлтэй байлаа. Ийнхүү Бигэрт ажиллаж байгаа ХАМО нарын дунд нөхөрлөлийн талаар сонссон хувь өндөр байгаа нь сум, орон нутгийн удирдлагуудын зүгээс уг асуудлыг ХАМО нарт таниулах үйл ажиллагааг эртнээс буюу хувиараа алт олборлолт явагдаж эхлэх үеэс хийж эхэлсэн байсантай холбоотой болов уу.

Шигтгээ 9.1:

Манай суманд хүмүүс хувиараа алт олборлож эхлэх үеэс бид нутаг орныхоо байгаль, экологийг хамгаалах, байдлыг хүндрэхээс сэргийлэх үүднээс алт олборлолт хийгдэж байгаа Баянхонгор гэх мэт аймгуудын туршилагыг судалж, ЗГ-ын “Түүр журам”-ын талаар олж мэдсэн. Ингээд алт олборлож буй иргэдийг цуглуулж, уг журмын талаар ойлгуулах, танилцуулах яриаг хэд хэдэн удаа хийсэн. Бид нутгийнхаа алт олборлож буй иргэдтэй санал бодлыг нь солилцож, нөхөрлөл байгуулах зарим бэлтгэл ажлуудыг хийж эхлээд байгаа...

М, эрэгтэй, сумын захиргааны ажилтан

БҮЛЭГ 10. ХУВИАРАА АЛТ ОЛБОРЛОГЧДЫН ЦААШДЫН ХАНДЛАГА

Энэ бүлэгт хувиараа алт олборлож буй иргэд цаашид алт олборлох ажлаа үргэлжлүүлэх эсэх, алт олборлох ажлыг орхих нөхцөл бүрдвэл ямар ажил хөдөлмөр эрхэлж амьжиргаагаа залгуулах боломж, чадвартай байгаа эсэх, мөн хувиараа алт олборлогчдын нөхцөл, байдлыг хэрхэн сайжруулж болох талаар ямар үзэл бодолтой байдгийг авч үзэх болно.

10.1 Ирээдүйн ажил эрхлэлт

Бигэр суманд хувиараа алт олборлож буй иргэдээс цаашид алт олборлох ажлыг үргэлжлүүлэн хийх эсэх, хийвэл ямар хугацаагаар үргэлжлүүлэн хийх гэж байгааг асуусан мэдээллийн үр дүнг Хүснэгт 10.1-д хариулагчийн шинж байдлаар задлан харуулав.

Хүснэгт 10.1 Судалгаанд хамрагдагчдын хувийн жин, цаашид алт олборлохоо үргэлжлүүлэн хийх эсэх, хариулагчийн шинж байдлаар

Хариулагчийн шинж байдал	Цаашид алт олборлохоо үргэлжлүүлэх эсэх			Бүгд	ХАМО нарын тоо	
	Тийм		Үгүй			
	1-23 сар	2 жилээс дээш				Тодорхойгүй хугацаагаар
Насны бүлэг						
18-30	35.2	47.8	7.9	9.1	100.0	88
31-40	52.6	29.8	9.7	7.9	100.0	114
41-60	41.8	38.8	14.3	5.1	100.0	98
Хүйс						
Эрэгтэй	40.4	42.6	9.56	7.4	100.0	230
Эмэгтэй	55.7	22.9	14.3	7.1	100.0	70
Шилжилтийн байдал						
Явуулын	50.6	36.1	6.1	7.2	100.0	83
Суурин	41.5	38.7	12.4	7.4	100.0	217
Өрхийн амьжиргааны түвшин						
Ядуу	47.2	41.7	7.2	3.9	100.0	180
Ядуу бус	39.2	32.5	15.8	12.5	100.0	120
Алт олборлолтоос жилд олдог ашиг						
Алдагдалтай	28.6	63.3	2.0	6.1	100.0	49
600,000 хүртэл ₮	44.1	36.5	14.0	5.4	100.0	93
600,001-3,000,000₮	43.7	31.0	13.8	11.5	100.0	87
3,000,001+ ₮	54.9	31.0	8.5	5.6	100.0	71
Нийт	44.0	38.0	10.7	7.3	100.0	300

Судалгаанд хамрагдсан нийт ХАМО нарын дийлэнх буюу 92.7 хувь цаашид хувиараа алт олборлохоо үргэлжлүүлэн хийх бодолтой байгаа ба 7.3 хувь нь л уг ажлаа зогсоох хандлагатай байна. Ажлаа үргэлжлүүлнэ гэсэн 92.7 хувийн 44 хувь нь уг ажлаа 2 жил хүртэлх хугацаагаар, 38 хувь нь 2 жилээс дээш буюу удаан хугацаагаар үргэлжлүүлэх хүсэлтэй байгаа ба 10.7 хувь нь тодорхойгүй хугацаагаар үргэлжлүүлэн хийх хандлагатай байна.

Цаашид удаан хугацаагаар алт олборлолтоо үргэлжлүүлэх хүсэлтэй байгаа алт олборлогчид нь 30 хүртэлх насны (47.8 хувь), эрэгтэй (42.6 хувь), суурин (38.7 хувь), ядуу өрхийн (41.7 хувь), алт олборлолтоос жилд олдог ашиг нь бага, эсвэл алдагдалтай ажилласан (36.5-63.3

хувь) хариулагчдын дунд бусад бүлгээсээ өндөр хувьтай байна. Эндээс дүгнэхэд, ялангуяа ядуу ба алтнаас өнгөрсөн жилд орлого бага олсон алт олборлогчид ирээдүйд алт олборлолтоос боломжийн орлого олно гэсэн хүлээлттэй байгаа аж.

Цаашид алт олборлохоо үргэлжлүүлэх бодолтой хариулагчдын нөхөрлөл болон хувиараа ажиллахын алийг эрхэмлэж байгааг сонирхоход 86.3 хувь нь нөхөрлөл хэлбэрээр, 13.7 хувь нь хувиараа ажиллана гэсэн бодолтой байлаа.

Хүснэгт 10.2-т алт олборлох ажлаа цаашид зогсоох бодолтой байгаа хариулагчдын үргэлжлүүлэн алт олборлохгүй гэж бодож байгаа шалтгааныг хүйсээр ялган харуулав.

Хүснэгт 10.2 Цаашид алт олборлохоо үргэлжлүүлэх бодолгүй хариулагчдын хувийн жин, ажиллахгүй шалтгаанаа мэдээлсэн байдал, хүйсээр


Цаашид алт олборлохоо үргэлжлүүлэхгүй шалтгаан	Хүйс		Нийт
	эрэгтэй	эмэгтэй	
Хангалттай мөнгө олсон	17.6	0.0	13.6
Эрүүл мэнд муудсан	29.4	20.0	27.3
Цаг агаарын хүндрэл	5.9	0.0	4.5
Ажлын нөхцөл хүнд	35.3	40.0	36.4
Хяналт шалгалтын дарамт их	11.8	40.0	18.2
Бүгд	100.0	100.0	100.0
ХАМО нарын тоо	17	5	22

Алт олборлолтоо зогсоох бодолтой байгаа хариулагчдын ажлаа зогсооход нөлөөлж буй гол шалтгаанууд нь ажлын нөхцөл муу (36.4 хувь), эрүүл мэнд муудсан (27.3 хувь), хяналт шалгалтын дарамт их (18.2 хувь) зэрэг болж байгаа аж.


10.2 Хувиараа алт олборлогчдын нөхцөл, байдлыг сайжруулах талаарх үзэл бодол

Судалгаанд хамрагдагчдыг алт олборлох ажлаас хөндийрүүлэн эдийн засгийн албан салбарт оруулахад тухайн алт олборлогчид ямар үйл ажиллагаа явуулж чадахаар байгааг харах зорилгоор бид судалгаандаа “Амьжиргаагаа дээшлүүлэхүйц боломжийн мөнгө/эх үүсвэртэй болвол яаж зарцуулах сонирхолтой байна вэ” гэсэн асуултыг оруулсан ба үр дүнг Зураг 10.1-ээр харуулав.

Бигэр суманд хувиараа алт олборлож байгаа судалгаанд хамрагдсан иргэд хэрэв боломжийн мөнгөн эх үүсвэртэй болвол, мал худалдаж авах (эмэгтэйчүүдийн 32.9 хувь, эрэгтэйчүүдийн 40.9 хувь), үйлдвэрлэл эрхлэх (эмэгтэйчүүдийн 20.0 хувь, эрэгтэйчүүдийн 25.7 хувь), наймаа хийх (эмэгтэйчүүдийн 28.6 хувь, эрэгтэйчүүдийн 17.0 хувь), газар тариалан, хувийн аж ахуй эрхлэх, эсвэл зээлдүүлэх буюу банкинд хадгалуулж орлого олох гэх мэт эдийн засгийн үр дүнтэй ажлуудыг хийж амьжиргаагаа залгуулах боломжтой гэж үзэж байна.



Зураг 10.2-оор ХАМО иргэдийн байдлыг сайжруулахын тулд ямар үйл ажиллагаа явуулах шаардлагатай талаарх хариулагчдын үзэл бодлыг харууллаа.



Алт олборлогчдын бодлоор, тэдний байдлыг сайжруулахад олон төрлийн үйл ажиллагаа явуулах боломжтой байгаа ба тэдгээрээс хамгийн чухал нь ХАМО иргэдэд зориулсан тусгай төсөл хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлэх, тэднийг хөдөлмөр хамгааллын багаж хэрэгслээр хангах, алт олборлолттой холбоотой хууль, эрх зүйн орчинг бүрдүүлж, сайжруулах, эсвэл тэдний эрхийг хамгаалах байгууллагатай болох, хөдөө орон нутгуудад ажлын байруудыг бий болгох зэрэг арга хэмжээнүүд байна.

Шигтгээ 10.1:

Төр засаг зоригтой алхам хийх хэрэгтэй. Нэг бол нөхөрлөл байгуулахыг дэмжиж алтнаас орсон орлогоос нь татвар хурааж орон нутгаа хөгжүүлэх хэрэгтэй. Сум болон иргэд нь дорвитой хөгжихгүй байна. Одоог хүртэл 24 цагаар тог гэрэл нь асахгүй л байгаа шүү дээ. Хэрэв тогтой болвол нутгийн иргэд үйлдвэрлэл явуулж, ажлын байртай болох боломж байна шүү дээ. Бас ухсан газруудад нь нөхөн сэргээлт хиймээр байна.

Эрэгтэй, 36 настай, ХАМО

БҮЛЭГ 11. ХУВИАРАА АЛТ ОЛБОРЛОЛТ БА НУТГИЙН ЗАХИРГААНЫ ОРОЛЦОО

Энэхүү бүлэгт Бигэр суманд явагдаж буй хувиараа алт олборлох үйл ажиллагааг зохицуулах талаар орон нутгийн засаг захиргаа ямар байр суурьтай байж, ямар үйл ажиллагаа явуулж байгаа талаар аймаг, сумын засаг захиргааны ажилтнуудтай хийсэн, уулзалт ярилцлагуудын мэдээлэлд үндэслэн тойм дүгнэлт хийлээ.

Бигэр сумын нутагт иргэд олноороо цуглан хувиараа алт олборлож эхэлсэн үеэс аймаг, сумын захиргааны ажилтнууд байгаль орчин, нийгэмд учирч болох хор хохирол, сөрөг үр дагавруудаас урьдчилан сэргийлэх үүднээс олон арга хэмжээнүүдийг хэрэгжүүлж иржээ. Юуны түрүүнд тэд асуудлыг хяналтандаа байлгах үүднээс ХАМО иргэдийн бүртгэл судалгааг гаргахыг оролдсон боловч богино хугацаанд олон аймгаас алт олборлогчид ирж ажиллах болсон нь тодорхой тоо мэдээллүүдийг нарийвчлан гаргахад хүндрэл, бэрхшээлтэй учирдаг талаар аймаг, сумын удирдагууд ярьж байсан. Биднийг судалгааны мэдээлэл цуглуулах үед засаг захиргааны ажилтнуудад байгаа ХАМО нарын тоо мэдээлэл нь ихэвчлэн аймаг орон нутгийн захиргаа, байгаль орчны болон мэргэжлийн хяналтын байгууллага, цагдаагийн байгууллага зэрэг олон байгууллагуудын хамтарсан шалгалт, хяналтын үеэр гаргасан тоо баримтууд байсан юм.

Шигтгээ 11.1:

2009 онд манай аймагт хууль бусаар алт олборлогч иргэд монгол улсын бараг л бүх аймаг сумаас тэр бүү хэл Улаанбаатараас ч ирсэн. Баянхонгор аймгаас хот хоорондын хүн тээвэрт явдаг унаанууд маршрутынхаа дагуу явахаа болиод Бигэр рүү явдаг болсон. Нийт 5-6 сумын цагдаагийн хүчээр хууль бус үйлдлийг таслан зогсоох зорилгоор иргэдийг нутаг буцаах үйл ажиллагааг зохион байгуулж байхад тэнд байгаа нийт хүний тоо гаргахад маш хүндрэлтэй байсан. Ойролцоогоор нэг машин гаргахад дотор нь хамгийн багаар бодоход 5-6 хүн байж байдаг, ихэнх тээврийн хэрэгсэл дугаар, номер байдаггүй...

Говь-Алтай аймгийн ЗДТГ-ын ажилтан

Судалгааны багийнхан мэдээлэл цуглуулах явцад нутгийн засаг захиргааны удирдах ажилтнууд асуудалд хоёрдмол байр сууринаас хандаж байгааг ажигласан. Тэдгээр нь, нэг талаас, алт олборлогчдын үйл ажиллагаа нь ерөнхийдөө хууль бус, албан ёсны зөвшөөрөлгүй хийгдэж байгаа гэдэг үүднээс ХАМО нарын үйл ажиллагааг хязгаарлах, зогсоох байр суурь; нөгөө талаас ард иргэдийн амьжиргааны хүнд байдлыг харгалзан үзэж тэднийг тодорхой зохион байгуулалттайгаар, байгаль орчин, нийгэмд хор хохирол багатайгаар алт олборлон амьжиргаагаа залгуулахыг нь хүлээн зөвшөөрөх байр суурь байв.

Засаг захиргааны ажилтнуудын өөрсдийн ажил, үүргийн дагуу хийсэн ажлууд нь ихэвчлэн ХАМО нарын үйл ажиллагааг хязгаарлах чиглэлийн арга хэмжээнүүд байсан. Тэд улсын болон аймгийн мэргэжлийн байгууллагуудын гаргасан тушаал зааврууд⁸-ын хүрээнд, сумандаа бусдын эзэмшил зөвшөөрөлтэй газар болон дархан цаазтай бүс нутагт алт олборлож буй ХАМО нарыг албадан тараах, багаж хэрэгслийг хураах, байгаль орчноо

⁸ Тухайлбал, Говь-Алтай аймгийн засаг даргын 2009 оны 7 дугаар сарын 17-ны өдрийн “Хууль бусаар ашигт малтмал олборлох үйл ажиллагааг зогсоож, хяналт тавих тухай” 204 дүгээр захирамж, аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2009 оны 09 сарын 30-ны өдрийн хуралдаанаас гаргасан “Хууль бусаар алт олборлох үйл ажиллагааг таслан зогсоох талаар авах арга хэмжээний тухай” 74 дүгээр тогтоол

хамгаалах ухуулга сурталчилгаа хийх зэрэг арга хэмжээнүүдийг хэрэгжүүлсэн байна. Тэдгээр арга хэмжээнүүдээс, томоохныг нь дурьдвал:

- 2009 оны 7 дугаар сараас эхлэн Бигэр сумын нутагт орших Агуйт гэдэг газарт алт олборлох үйл ажиллагаа эхэлж, 08 сарын 13-15-нд 2000 гаруй хүн, 500 орчим тээврийн хэрэгсэл цугласныг аймгийн БОАЖГ, МХГ, Цагдаагийн хэлтэс, Онцгой байдлын хэлтсээс томилогдон ажилласан 40 хүн 6 тээврийн хэрэгсэл ашиглан тараажээ.
- Гэвч 9 сард уг газарт хууль бусаар алт олборлох үйл ажиллагаа дахин явагдаж Улаанбаатар, Дархан, Эрдэнэт, Өвөрхангай, Баянхонгор, Өмнөговь, Дорнод, Сэлэнгэ, Булган, Завхан, Ховд, Хөвсгөл зэрэг аймгуудаас 25000 орчим хүн, 8500 гаруй тээврийн хэрэгсэл цуглаж, архидан согтуурах, хулгай дээрэм хийх зэрэг хэрэг зөрчил удаа дараа гарч гэмт хэргийн нөхцөл байдал хүндрэх хандлагатай болсон тул 9 сарын 14-21-ний хооронд аймгийн ЗДТГ, БОАЖГ, МХГ, Цагдаагийн хэлтэс, Онцгой байдлын хэлтсийн нийлсэн 50 албан хаагч ажиллаж алт олборлогчдыг бүрэн тарааж уг газарт байнгын эргүүлийг томилон ажиллуулсан байна.
- Үүний дараа 2009 оны 9 сарын 26-27-нд хууль бусаар алт олборлож буй иргэд зөвшөөрөгдөөгүй газарт дахин дайрч орсныг тараахаар Цагдаагийн хэлтсээс 22 хүний бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг ажилласан боловч хууль бусаар алт олборлогч иргэд эсэргүүцэл үзүүлж тодорхой хугацаагаар ажиллуулахыг шаардсаны дагуу харилцан тохиролцож 3 хоног ажиллуулахаар шийдвэр гаргасан байна.
- Мөн Улаанбаатар хотын харуул, хамгаалалтын “Топ бүлэг” ХХК-тай аймгийн ЗДТГ гэрээ байгуулан 11 сарын 04-ний өдрөөс эхлэн Бигэр сумын нутагт хууль бусаар алт олборлож байсан Агуйт, Дөрөлж орчмын газар нутгийг хамгаалуулах ажлыг эхэлсэн байна. Гэвч хувиараа алт олборлогч иргэд шөнийн цагаар дайран орж харуул хамгаалалтын ажилтнуудыг чулуугаар цохиж биед нь гэмтэл учруулах явдал гарсаар байна.
- 2009 оны 7 сараас хойш хувиараа алт олборлож буй иргэдээс нийт 325 ширхэг мотор, 49 ширхэг металл хайгч мэдрэгч, 1 ш компрессор, 9 ширхэг бага оврын цахилгаан үүсгүүр, 39 ширхэг баригчийг хурааж авсан байна.

Бигэр сумын хэмжээнд ийнхүү ХАМО нарын үйл ажиллагааг таслан зогсоох оролдлогууд хийгдэж байгаа ч эвдэрсэн газарт нөхөн сэргээлт хийх ажил огт хийгдэж эхлээгүй байна. Говь-Алтай аймгийн ЗДТГ-ын уул уурхайн асуудал хариуцсан мэргэжилтний ярьснаар, 2009 оны 11 сарын байдлаар аймгийн хэмжээнд ХАМО нарын үйл ажиллагаанд өртөн эвдрэлд орсон нийт 615 га газрын 74.1 га газарт нь техникийн нөхөн сэргээлт хийсэн байгаа ч уг нөхөн сэргээлтийн ажилд Бигэр суман дахь эвдэрсэн газар хараахан хамрагдаагүй байв.

Бигэр суманд цугларсан хувиараа алт олборлогчдыг албадан тараах ажиллагаа...



Эх үүсвэр: ОБЕГ, ЗДТГ БОАЖГ 2009 он

Бигэр суманд ХАМО нарын алт олборлох багаж хэрэгслийг хураах арга хэмжээний үеэр



Эх үүсвэр: ОБЕГ, ЗДТГ БОАЖГ 2009 он

Хуулийг мөрдүүлэх баг ухуулга сурталчилгаа хийж байгаа нь




Эх үүсвэр: ОБЕГ, ЗДТГ БОАЖГ 2009 он

Дээрх байдлаар хувиараа алт олборлолтын хууль бус үйлдлүүдийг хязгаарлахыг оролдохын зэрэгцээ, ХАМО нарын амьжиргааны хүнд байдлыг харгалзан үзэж, асуудлыг зүй зохистойгоор шийдэх шийдэл олох хүрээнд аймаг болон сумын засаг захиргаанаас мөн зарим арга хэмжээг хэрэгжүүлжээ. Тухайлбал,

- Хувиараа алт олборлогчдын хууль эрх зүйн орчинг боловсронгуй болгох, үүсч буй нөхцөл байдалтай уялдуулан шаардлагатай арга хэмжээг авах хүсэлтийг УИХ-ын дарга, УИХ-ын Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороо, Монгол улсын Шадар сайд, ХЗДХ-ийн сайд, БОАЖ-ын сайд, Эрдэс баялаг, эрчим хүчний сайд, Гадаад хэргийн сайд нарт хүргүүлсэн байна.
- ХАМО нарыг албан ёсоор зохион байгуулалтад оруулж, бүртгэлжүүлэхийн тулд 2009 оны 9 сарын 27-оос хойш хувиараа алт олборлогчдын асуудлаар сумын ИТХ, ЗДТГ, БО-ны байцаагч зэрэг хүмүүсийн бүрэлдэхүүнтэй өргөтгөсөн хуралдааныг 4-5 удаа зохион байгуулж, хувиараа алт олборлогчдыг “Хувиараа ашигт малтмал олборлох үйл ажиллагааг зохицуулах Засгийн газрын түр журам” (цаашид *Түр журам* гэж нэрлэнэ)-д заагдсан бүртгэгдээгүй нөхөрлөл-ийн зохион байгуулалтад оруулах албан шийдвэр гаргасан. Уг шийдвэрээ хэрэгжүүлэх шатанд сумынхаа 5 баг тус бүрт 70-100 хүнтэй нөхөрлөл байгуулж, түүнд орох хүмүүсийн нэрсийн жагсаалт, гарын үсэг, иргэний үнэмлэхийн хуулбаруудыг цуглуулан, нөхөрлөлд орохоор бүртгүүлсэн иргэдэд хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны дүрэм, насанд хүрээгүй хүүхэд ажиллуулахгүй байх, хэв журмыг баримталж ажиллах, байгаль орчинд хүлээх хариуцлагын тухай зэрэг олон асуудлаар эрх, үүргийг танилцуулж, ойлгуулах ажлууд хийгдсэн байна. Ийнхүү бүртгэгдээгүй нөхөрлөл байгуулах идэвхи санаачилга байгаа ч орон нутгийн удирдлагуудад хувиараа ашигт малтмал олборлох үйл ажиллагааг зохицуулах хууль эрх зүйн мэдлэг, мэдээлэл болон энэ чиглэлийн үйл ажиллагааг зохион байгуулах туршлага дутмагаас тэдний байгуулсан гэж үзэж буй нөхөрлөл нь яг бүрэн утгаараа 2008 оны *Түр журам*-д заагдсан бүртгэгдээгүй нөхөрлөлийн хэмжээнд хүрч чадаагүй байна. Тухайлбал, *Түр журам*-д заагдсан шаардлагатай гэрээнүүд бүрэн хийгдээгүй, ХАМО нарт ашиглуулах газрын асуудал шийдэгдээгүй⁹ байсан.

Бигэр суманд хувиараа алт олборлогчдын нөхөрлөл байгуулах тухай хурлын тэмдэглэл, нөхөрлөлд орох гишүүдийн жагсаалт...



Эх үүсвэр: Бигэр сумын “Бурхан буудай” нөхөрлөлийн ахлагчийн тэмдэглэл

⁹ Сумын захиргааны ажилтнууд ашигт малтмалын хайгуулын лицензтэй компанитай ХАМО иргэдэд ашиглуулж болох газрын асуудлаар тохиролцоонд хүрэхээр ажиллаж байгаа

БҮЛЭГ 12. ДҮГНЭЛТ, ЗӨВЛӨМЖ

Говь-Алтай аймгийн Бигэр сумын нийгэм, эдийн засгийн суурь судалгаанаас судалгааны баг дараах ерөнхий дүгнэлтүүдийг хийж байна. Үүнд:

- Бигэр сум нь нийт 635 өрх, 2197 хүн амтай, 5 баг, 20 гаруй аж ахуйн нэгж байгууллага үйл ажиллагаа явуулдаг манай улсын баруун бүсийн алслагдмал сумуудын нэг юм. Сумын төв нь нийслэлээс 1050 км зайд алслагдсан, төвийн эрчим хүчний шугамд холбогдоогүй, жижиг, дунд үйлдвэрлэл, дэд бүтэц, ахуйн үйлчилгээний салбар сул хөгжсөн, барилга, бүтээн байгуулалтад хөрөнгө оруулалт хийгдээгүй, үндсэндээ төрөөс үзүүлдэг санхүүгийн дэмжлэгээр үйл ажиллагаа явуулдаг сум юм. Сумын нийт өрхийн 80 орчим хувийг малчин өрхүүд эзэлдэг ба сүүлийн жилүүдэд байгалийн гамшигт үзэгдлүүдийн улмаас мал нь ихээр хорогдож байна. Ийнхүү, дэд бүтцийн хөгжил сул, ажлын байр ховороос гадна эдийн засгийн үндсэн салбар болох мал аж ахуй нь байгалийн гамшигт ихээр өртөж байгаагаас хүн амынх нь амьжиргааны түвшин улам доройтож, сумын иргэдийн дунд алт олборлох үйл ажиллагаанд оролцох сонирхол их болжээ.
- Бигэр сумын нутаг дэвсгэрт алт олборлож буй хүмүүсийн дийлэнх нь Сэрхийн нурууг тойрсон алтны гарц бүхий 6-7 амуудад алт олборлож буй хүмүүс байгаа ба бүгд албан ёсны газрын зөвшөөрөлгүйгээр алт олборлож байна.
- Бигэр суманд хувиараа алт олборлож байгаа судалгаанд хамрагдсан иргэдийн шинж байдлыг дүгнэхэд, дийлэнх нь 26-40 насны, эрэгтэй, гэр бүлтэй, дунд боловсролтой, 4-өөс олон ам бүлтэй, ядуу өрхийн хүмүүс байгаа ба тэдний өрхийн ажил хийдэг 1 хүнд ногдох эдийн засгийн ачаалал өндөр, өрхөд нь тогтвортой орлогын эх үүсвэр цөөн бөгөөд орлого бүрдэлтэд алт олборлолт томоохон үүрэг гүйцэтгэдэг байна. Хүйсийн хувьд ажиглагдсан зарим анхаарал татахуйц үр дүнгүүд нь хувиараа алт олборлож буй эмэгтэйчүүд эрэгтэйчүүдтэй харьцуулахад арай ахимаг насны, гэр бүлтэй, боловсрол илүү, олон хүүхэдтэй, давхар ажил эрхэлдэггүй, суурин, эрхлэх мал аж ахуй байхгүй хүмүүс байлаа.
- Хувиараа алт олборлож буй иргэдийн өрхийн амьжиргааг харвал, 60 хувь нь ядуу өрх, үүнээс 23 хувь нь нэн ядуу гэсэн ангилалд байгаа нь ядуурал бол хувиараа алт олборлолтын нэг үндсэн шалтгаан гэдгийг баталж байна. Алт олборлодог хүнтэй өрхүүдийн орлогын бүтцэд алт олборлолт дунджаар 55.4 хувийг эзэлж байгаа нь тэдгээр өрхүүдийн амьжиргаа алт олборлолтоос нэлээд хараат гэдгийг харуулж байна.
- Судалгаанд хамрагдсан ХАМО нар Бигэр суманд дунджаар 3 сар алт олборлох ажил хийж байгаа иргэд байсан ба ХАМО нарын хувиараа алт олборлох болсон шалтгаануудыг авч үзэхэд, өрхдөө нэмэлт орлого олох (50.0 хувь), өөр ажил олдохгүй байсан (43.0 хувь), амьжиргаагаа залгуулах (42.7 хувь) зэрэг хүмүүсийн амьдралын наад захын хэрэгцээ, ядууралтай шууд холбоотой шалтгаанууд хамгийн өндөр хувь эзэлж байна.
- ХАМО нарын 57.0 хувь нь жилийн зөвхөн нэг л улиралд хувиараа алт олборлох ажил хийдэг хүмүүс байсан ба 2-3 улиралд ажиллагчид 32.7 хувь, жилийн бүх улиралд ажиллагчид 10.3 хувийг тус тус эзэлж байв. Олон буюу жилийн 4 улиралд ажилладаг эрэгтэйчүүдийн хувь эмэгтэйчүүдийнхээс 2 дахин өндөр байгаа нь эрэгтэйчүүд

эмэгтэйчүүдийг бодвол илүүтэйгээр хувиараа алт олборлох ажлыг байгаль, цаг уурын нөхцөл харгалзахгүйгээр, удаан хугацаагаар хийдэг болохыг харуулж байна.

- Судалгаанд хамрагдсан эрэгтэй ХАМО нар өнгөрсөн жилд дунджаар 64-65 хоног, эмэгтэй ХАМО нар дунджаар 52-53 хоног алт олборлох ажил хийсэн ба өвлөөс бусад бүх улирлуудад тэдний дийлэнх нь хоногт 9 ба түүнээс дээш цаг ажилласан нь МУ-ын *Хөдөлмөрийн тухай* хуулинд заагдсан ердийн ажлын өдрийн үргэлжлэх цагийн заалтаас өндөр үзүүлэлт байна. Ийнхүү *Хөдөлмөрийн тухай* хуулинд заагдсан эрхээ эдэлж чадахгүй байгаа байдал эмэгтэйчүүдийн хувьд эрэгтэйчүүдийнхээс илүү байв.
- Хувиараа алт олборлох ажлын хамгийн хүнд бэрхшээлтэй нөхцлүүдэд Бигэрийн алт олборлогчид тоос ихтэй (72.0 хувь), ил задгай гадаа ажилладаг (55.0 хувь), байгаль, цаг агаарын хэт халуун, хүйтэн үе, эсвэл ширүүн бороо, цас, шороон шуурга тааралдах (49.3 хувь) зэрэг нөхцлүүдийг хамгийн түгээмэл нэрлэсэн.
- Бигэр суманд хувиараа алт олборлож буй нийт ХАМО нарын хөдөлмөр хамгааллын хувцас, хэрэгслийн хэрэглээг авч үзэхэд бээлий, амны хаалт төдийхнөөр хязгаарлагдаж байсан ба нийт хариулагчдын 88 хувь нь хөдөлмөр хамгааллын хувцас хэрэгсэл олох, ашиглахад ямар нэг бэрхшээл тулгардаг гэж хариулжээ. Тэдэнд хамгийн их тохиолддог бэрхшээл нь зориулалтын дэвшилтэт ямар хувцас хэрэгсэл байдгийг мэддэггүй (49.3 хувь), хаанаас олж авахаа мэддэггүй (37.3 хувь), олдоц муу (22.3 хувь) зэрэг байна. Эдгээрээс, ХАМО нарт хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны арга барил эзэмшүүлэх, хөдөлмөр хамгааллын хувцас хэрэгслийг таниулах сургалтууд, мөн хувийн хөдөлмөр хамгааллын хувцас, хэрэгслийг нийлүүлдэг тохиромжтой эх үүсвэр нэн шаардлагатай байгаа нь харагдаж байна
- Хувиараа алт олборлогчдын зах зээл дээр өнгөрсөн жилд нэг алт олборлогч жилд дунджаар 61.5 хоног алт олборлох ажил хийж, ажлын нэг хоногт дунджаар 1.19 грамм алт олборлон, олборлосон алтаа 1 граммыг нь дунджаар 39,368.87 төгрөгөөр борлуулж, ажлын хоногт дунджаар 47,009.7 төгрөг, ажлын сард дунджаар 770,982.3 төгрөг, жилийн ажилласан бүх хоногт дунджаар 2,957,430.1 төгрөгийн орлого олсон байна. Эдгээр үзүүлэлтийг жилийн ердийн хоног, сард ногдох байдлаар авч үзвэл, ХАМО иргэн жилийн ердийн нэг хоногт дунджаар 0.2 грамм алт олборлон 8,102.5 төгрөгийн орлого, нэг сард дунджаар 6.15 грамм алт олборлон 246,452.5 төгрөгийн орлого олсон байна.
- Судалгаанд хамрагдсан ХАМО нар олборлосон алтаа 100 хувь албан бус, хэн нь тодорхойгүй эх үүсвэрүүд буюу хувь ченжүүдэд борлуулж байна. Тэд албан зах зээл (банк)-д алтаа борлуулсан бол, хүн тус бүрийн алт олборлолтоос олох боломжтой байсан орлого буюу *алдагдсан боломжийн өртөг* нь ажлын нэг хоногт дунджаар 56,061.0 төгрөг, жилд дунджаар 3,410,363.0 төгрөг болж байгаа нь ХАМО нарын алдагдсан боломжийн өртөг өнөөгийн орлогоос нь өндөр байгааг харуулж байна. Судалгаагаар, хэрэв тохиромжтой нөхцөл бүрдвэл ХАМО нарын тавны гурав нь албан зах зээлд алтаа борлуулах хүсэлтэй байгаагаа илэрхийлсэн.
- Алт олборлохдоо ХАМО нар өнгөрсөн жилийн ажлын нэг хоногт дунджаар 15,806 төгрөг, ажлын нэг сард дунджаар 231,190 төгрөг, жилийн ажилласан нийт хоногт дунджаар 751,169 төгрөгийн зардал гаргасан ба үүнийг жилийн ердийн хоног, сард

шилжүүлэн харвал, хоногт 2,058 төгрөг, сардаа 62,597 төгрөгийн зардлыг алт олборлоход гаргасан байна.

- Алт олборлолт хүмүүсийн эдийн засгийн амьдралд хэрхэн нөлөөлснийг авч үзэхэд, судалгаанд хамрагдсан ХАМО нарын дунд алт олборлож эхэлснээс хойш амьжиргаа нь доошилсон гэж хариулагчид нэг ч байгаагүй. Харин 56.3 хувь нь амьжиргаагаа дээшилсэн гэж хариулсан ба үүнийгээ алт олборлосны үр дүнд өр зээлээ дарсан, боловсрол, эрүүл мэнддээ хөрөнгө оруулалт хийсэн, байнгын бэлэн мөнгөтэй болсон, өдөр тутмын хэрэгцээгээ тогтвортой хангадаг болсон гэх мэтээр тайлбарлажээ.
- Алт олборлож эхэлснээс хойш ХАМО иргэдийн 19.3 хувьд нь ямар нэгэн өвчний зовиур илэрсэн ба бөөр шээсний замын өвчин, үе мөчний өвчингөөр тус тус 40-өөс дээш хувь нь өвчилсөн байна. Түүнчлэн ХАМО нарын 13.7 хувь нь осол гэмтэлд орсон ба түгээмэл тохиолдсон ослуудад шороонд дарагдах, нүхэнд унах зэрэг орж байна.
- Хувиараа алт олборлож буй нийт иргэдийн дунд эрүүл мэндийн даатгалд хамрагдан, сүүлийн 1 жилийн хураамжаа төлсөн ХАМО нар 54.3 хувь, нийгмийн даатгалд хамрагдсан ХАМО нар 1 хувь байсан ба хүн амын орлогын албан татвар төлөлт 0 хувьтай байгаа нь ихээхэн хангалтгүй үзүүлэлтүүд байлаа.
- Судалгаанд хамрагдсан хувиараа алт олборлож буй иргэдийн дөнгөж 1 хувь нь нийгмийн даатгалын шимгэл төлсөн байгаа нь тэдний дунд нийгмийн даатгалын ач холбогдол, хэрхэн хамрагдах талаар ойлголт мэдлэг дутмаг байгаа нь тодорхой байлаа.
- Судалгаанд хамрагдсан ХАМО нарын талаас илүү хувь нь хувиараа алт олборлолт явагдаж буй газарт ундны ус нийлүүлэх үйлчилгээг хамгийн хэрэгцээтэй байна гэж мэдээлжээ. Үүнээс гадна жорлон, хогийн цэг (42.3 хувь), халуун ус (32 хувь), цахилгаан (31.7 хувь) зэргийг харьцангуй олон алт олборлогчид хэрэгцээтэй байна гэж мэдээлсэн нь хувиараа алт олборлолт явагдаж буй газарт ариун цэврийн асуудал нэн хүнд байдгийг харуулж байна.
- Бигэр суман дахь хувиараа алт олборлолт явагдаж буй газарт гэмт хэрэг зөрчил гардаг эсэхийг асуухад нийт ХАМО нарын 96.7 хувь нь “тийм” гэж хариулсан ба архидалт, хулгай, хэрүүл маргаан, зодоон цохион, дээрэм, биеэ үнэлэлт зэрэг гэмт хэрэг, зөрчлүүд гардаг байна.
- Судалгаанд хамрагдсан нийт алт олборлогчдын 95 хувь нь Бигэр суманд ажиллаж буй хувиараа алт олборлогчид болон бусад талуудын хооронд тодорхой маргаан, зөрчилдөөн гардаг гэж хариулж байлаа. ХАМО нар ямар бүлгийнхэнтэй илүү маргаан, зөрчилдөөнтэй байдгийг авч үзэхэд, давхардсан тоогоор, хариулагчдын 83.5 хувь нь цагдаа, харуул хамгаалалтын ажилтнууд, 41.1 хувь нь засаг захиргааны байгууллага, 30.2 хувь нь нутгийн малчдыг нэрлэсэн байна. Үүнээс гадна ХАМО нарын 26.0 хувь нь алт олборлогчид хоорондоо бас маргаан, зөрчилдөөн гаргах нь их гэж хариулжээ. Эдгээр бүлгүүдийн хооронд гардаг маргаан, зөрчилдөөний гол сэдвүүд нь байгаль орчны сүйдэл, нөхөн сэргээлт, бэлчээр, алт олборлох газрын зөвшөөрлийн асуудлууд байсан ба маргааны үеэр ХАМО нарын болон хууль сахиулагчдын аль алины хувь хүний эрх багагүй зөрчигдөж байна.

- Бигэрт алт олборлож буй иргэд албан байдлаар зохион байгуулалтад ороогүй ч тэдний 85.3 хувь нь алт олборлохдоо хүмүүстэй бүлэг болж ажилладаг ба тэд бүгд (100 хувь) бүлгийнхээ ашиг хуваадаг аргад сэтгэл хангалуун байдаг гэжээ. Мөн нийт ХАМО нарын 90.3 хувь алт олборлохдоо хүмүүстэй хамтран ажиллах нь ганцаараа ажилласнаас илүү давуу талтай гэсэн байна. Эдгээрээс харахад, ХАМО нарыг албан ёсны зохион байгуулалтад оруулахад тэдний хөдөлмөр хуваарилалт, ашгаа хуваах асуудалд онцын бэрхшээл гарахгүй байж болохоор байна.
- Бигэрт алт олборлож байгаа иргэдийн 71.3 хувь нь 2008 оны “Хувиараа ашигт малтмал олборлох үйл ажиллагааг зохицуулах Засгийн газрын түр журам”-д өгүүлсэн “бүртгэгдээгүй нөхөрлөл”-ийн талаар ямар нэг байдлаар сонссон байна.
- Судалгаанд хамрагдсан нийт ХАМО нарын 92.7 хувь цаашид хувиараа алт олборлохоо үргэлжлүүлэн хийх бодолтой, 7.3 хувь нь зогсоох хандлагатай байна. Цаашид алт олборлохоо үргэлжлүүлэх бодолтой хариулагчдын нөхөрлөл болон хувиараа ажиллахын алийг эрхэмлэж байгааг сонирхоход 86.3 хувь нь нөхөрлөл хэлбэрээр, 13.7 хувь нь хувиараа ажиллана гэсэн бодолтой байлаа.
- “Амьжиргаагаа дээшлүүлэхүйц боломжийн мөнгө/эх үүсвэртэй болвол яаж зарцуулах сонирхолтой байгаа”-г асуухад, ХАМО нарын дийлэнх нь мал худалдан авах, үйлдвэрлэл эрхлэх/ажлын байр бий болгох, наймаа хийх, газар тариалан/хувийн аж ахуй эрхлэх, эсвэл зээлдүүлэх буюу банкинд хадгалуулж орлого олох гэх мэт удаан хугацаанд эдийн засгийн үр өгөөж нь үргэлжилж болох ажлуудыг нэрлэлээ.
- ХАМО иргэд өөрсдийн байдлыг сайжруулахын тулд шаардлагатай гэж үзэж байгаа арга хэмжээнүүд дотор хамгийн өндөр хувь эзэлж байгаа хариултууд нь ХАМО нарт чиглэсэн тусгай төсөл/хөтөлбөр хэрэгжүүлэх, алт олборлох хууль эрх зүйн орчинг сайжруулах, хөдөлмөр хамгааллын багаж зэвсгээр хангах, ХАМО нарын эрхийг хамгаалах байгууллагатай болох зэрэг орж байна.
- Орон нутгийн удирдлагуудад бичил уурхайг хөгжүүлэх чиглэлийн мэдээлэл, туршлага дутмаг байгаа ба ХАМО нарт чиглүүлэн хэрэгжүүлсэн арга хэмжээнүүд нь ихэвчлэн тэднийг *хязгаарлах/зогсоох* арга хэмжээнүүд байна.

Дээрх гол үр дүнгүүдэд үндэслэн судлаач бид дараах бодлогын ба үйл ажиллагааны зөвлөмжүүдийг гаргаж байна. Үүнд:

1. Нийгэм, хууль эрх зүйн хүрээнд бүрэн утгаараа хүлээн завшөөрөгдөөгүй “хууль бус” хэмээн нэрлэгдэж, дарамт шахалтанд ажиллаж, амьдарч байгаа хэдий ч хувиараа алт олборлогчид гэр бүлийнхээ өмнө, цаашилбал орон нутаг, аймаг, улсын хэмжээнд төр, засгийн газрын хүлээх ёстой үүрэг, хариуцлагыг үүрэлцэж, эдийн засгийн хөгжилд тодорхой хувь нэмэр оруулж байгааг харгалзан тэдний байгаль орчин, нийгэмд хор хохиролгүйгээр ажиллах хууль эрх зүйн орчинг нэн яаралтай бүрдүүлж, засгийн газрын холбогдох журмын дагуу зөвшөөрөлтөй газар олгон зохион байгуулалтанд оруулан ажиллуулах хэрэгтэй байна. Хувиараа алт олборлож байгаа иргэдийг ойрын ирээдүйд нөхөрлөл, цаашдаа бичил уурхайн зохион байгуулалтанд оруулснаар микро болон макро түвшинд дараах эерэг үр дүнгүүд гарна гэж үзэж байна. Үүнд:

- Нөхөрлөлийн зохион байгуулалтанд орж ажилласнаар ХАМО иргэдийн хөдөлмөр хуваарилалт сайжирч, нэг хүнд ногдох ажлын ачаалал болон ажлын багаж хэрэгслийн зардал буурч, орлого нь нэмэгдэнэ
 - Нөхөрлөлд орсноор ХАМО иргэд бүртгэлтэй болж, үүрэг хариуцлага нь нэмэгдэн, байгалийн нөөцийг ашигласны болон орлогын албан татвар төлөх боломж бүрдэж, нутаг орныхоо эдийн засагт хувь нэмэр оруулах ач холбогдолтой. Түүнчлэн ХАМО иргэдийн нөхөрлөлөөр ажиллах дүрмээр дамжуулан тэдний эрүүл мэнд, нийгмийн даатгалд хамрагдалтад хяналт тавих боломжтой
 - Алт олборлогчдод албан ёсоор ажиллах зөвшөөрөл олгогдсоноор одоогийн Бигэр суманд гарч байгаатай адил хүний эрхийн зөрчлүүд багасах боломжтой
 - Урт хугацаанд, хамтын нэгдсэн зохион байгуулалтанд орж, байгалийн нөөцийн хамтын, тогтвортой менежментийг эрхэлснээр байгалийн нөөц зохистойгоор ашиглагдаж, хувиараа алт олборлогч иргэдийн амьжиргаа тогтвортой болно
 - Мөн олон иргэд орлоготой болсноор ажилгүйдэл, ядуурал буурч, хөдөөгийн тогтвортой хөгжилд хувь нэмрээ оруулна
2. Хувиараа ашигт малтмал олборлогч иргэдийн өвчлөх, осол аваарьт өртөх өндөр эрсдэлийг бууруулах, ХАОАТ, эрүүл мэнд болон нийгмийн даатгалд хамрагдалтуудыг нэмэгдүүлэхийн тулд дараах арга хэмжээг нэн түрүүнд хэрэгжүүлэх хэрэгтэй байна. Үүнд:
- Нөхөрлөлөөр дамжуулан ХАМО нарт төрөл бүрийн сургалтуудыг, ялангуяа хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны арга барил эзэмшүүлэх, хөдөлмөр хамгааллын хувцас хэрэгслийг таниулах, эрүүл мэнд болон нийгмийн даатгал, орлогын албан татвар зэргийн ач холбогдлыг ойлгуулах, хэрхэн ашиглах талаар мэдлэг мэдээлэл олгох сургалтуудыг зохион байгуулах
 - Хувиараа ашигт малтмал олборлогч иргэдэд хувийн хөдөлмөр хамгааллын хувцас, хэрэгслийг нийлүүлдэг тохиромжтой эх үүсвэрийг судлан бий болгох
 - Хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны шаардлага хангасан, бүтээмж өндөртэй, гар багаж хэрэгсэл, тоног төхөөрөмжийн загварыг боловсруулан олборлолтын үйл ажиллагаанд нь нэвтрүүлэх
3. Байгаль орчны тулгамдсан асуудлуудыг шийдвэрлэх хүрээнд дараах арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэх шаардлагатай байна. Үүнд:
- ХАМО нарын байгаль орчинд хүлээх үүрэг, хариуцлагыг хуулийн хүрээнд тодорхой болгож, мөрдүүлэх
 - Бигэр сумын Сэрхийн нурууны орчим уурхайн чиглэлээр үйл ажиллагаа эрхэлж байгаа иргэд, аж ахуйн нэгжүүдээр техникийн болон биологийн нөхөн сэргээлт хийлгэх ажлыг орон нутгийн болон мэргэжлийн байгууллагууд анхааралдаа авч нөхөн сэргээлтийн ажлын явцад хяналт тавих, стандарт шаардлагын дагуу хүлээн авч нийтэд мэдээлж хэвших

- Бигэрийн хувиараа алт олборлолт хийгдэж байгаа газарт орчны ариун цэврийн асуудалд анхаарал тавьж дор хаяж төвлөрсөн хогийн цэг, жорлон, муу ус зайлуулах нүх зэргийг байгуулж, ард иргэдэд энэ талын мэдээ, мэдээллээр хангах ажлыг холбогдох байгууллагууд зохион байгуулах
4. ХАМО нарын алтаа борлуулдаг албан бус зах зээл (ченжүүдэд алт худалдаалах, худалдан авах)-ийн цаана хувь хүн хөдөлмөрөө дутуу үнэлүүлэх, эсвэл орлогын албан татвар тооцогдохгүй үлдэх, алт олборлогчдын үйлдвэрлэл эдийн засагт тооцогдохгүй хоцрох, ашигт малтмалын нөөц зүй бусаар ашиглагдах зэрэг микро болон макро түвшний олон сөрөг асуудлууд оршиж байдаг тул хувиараа алт олборлогчдын алт борлуулалтын асуудлыг анхаарч, зохих арга хэмжээ авах шаардлагатай байна. Үүнийг нөхөрлөлөөр дамжуулан шийдвэрлэх боломжтой байж болох юм. Тухайлбал, өнөөгийн практикт алтыг Монголын албан зах зээл буюу банкинд борлуулахад мэргэжлийн байгууллагаар сорьц тодорхойлуулахаас авахуулаад зардал чирэгдэл их бөгөөд хувь хүмүүс олборлосон бага хэмжээний алтаа байнга тэгж борлуулах боломж манай нөхцөлд хомс байна. Иймд нөхөрлөлийн зохион байгуулалтад орвол, багахан хэмжээний алтаа хувь хүн нэг бүр банк руу барьж явах биш, нөхөрлөлийн хүрээнд цуглуулан, албан байдлаар сорьцыг тодорхойлуулж, эдийн засгийн албан зах зээлд борлуулан орлогоо нэмэгдүүлэх боломжтой. Ингэж чадвал, микро түвшинд алт олборлогчдын орлого нэмэгдэж, макро түвшинд хувиараа алт олборлолттой холбоотой алтны далд наймаа, сүүдрийн/далд эдийн засаг хумигдах зэрэг давуу талууд бий болох боломжтой.
 5. Орон нутгийн удирдлагууд болон ХАМО иргэдэд бичил уурхайг хөгжүүлэх чиглэлийн мэдлэг, мэдээлэл олгох сургалтуудыг системтэйгээр зохион байгуулах, бичил уурхайг амжилттай хөгжүүлж байгаа гадаад, дотоодын туршлагаас суралцах боломжийг олгох, энэ чиглэлийн хууль эрх зүйн орчинг боловсронгуй болгоход тэдний оролцоог дэмжих хэрэгтэй байна.
 6. Үүнээс гадна, хувиараа алт олборлолт нь хүн амын ажилгүйдэл, ядуурлаас үүдэлтэй байгааг харгалзан сум, орон нутгийн захиргааныхан боломжтой олон талуудын хөрөнгө оруулалтыг татаж, орон нутгаа хөгжүүлэх, ажлын байруудыг бий болгоход анхаарал тавих хэрэгтэй байна.

Ашигласан материал:

1. Говь-Алтай аймгийн ЗДТГ, 2008. *Говь-Алтай аймгийн засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн биелэлт*, Алтай хот
2. Говь-Атай аймгийн ЗДТГ, 2010. *Говь-Алтай аймгийн эдийн засаг, нийгмийн байдлын 2009 оны жилийн эцсийн мэдээлэл*
3. Говь-Атай аймгийн ЗДТГ-ын Статистикийн хэлтэс, 2010. *Говь-Алтай аймгийн 2009 оны улирлын эцсийн мэдээлэл*
4. Говь-Алтай аймгийн засаг даргын 2008-2012 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөр
5. Говь-Алтай аймгийн Бигэр сумын нийгэм эдийн засгийг хөгжүүлэх дунд хугацааны мастер төлөвлөгөө, 2009 он
6. ИТХ, 2009. *Бигэр сумыг хөгжүүлэх мастер төлөвлөгөө*
7. Манфред Балле 2007. *Далд бичил уурхайн олборлолтын аюулгүй үйл ажиллагаа ба эрүүл ахуй*, Улаанбаатар хот
8. МУЗГ, 2002. *Эрүүл мэндийн даатгалын тухай хууль*
9. МУЗГ, 2008. *“Хувиараа ашигт малтмал олборлож байгаа иргэдийн үйл ажиллагааг зохицуулах түр журам”*
10. Үндэсний Статистикийн хороо. *Монгол Улсын Статистикийн эмхэтгэл 2005, 2008*, УБ хот
11. Статистикийн хэлтэс 2010. *Говь-Алтай аймгийн эдийн засаг, нийгмийн байдлын 2009 оны жилийн эцсийн мэдээлэл*
12. ТоБУ төсөл, 2007. *Монголын хувиараа ашигт малтмал олборлогчдын техник, технологийн үнэлгээ*, УБ
13. ТоБУ төсөл, 2008. *Бичил уурхай, хэтийн төлөв, зохицуулалт*, УБ
14. ТоБУ төсөл, 2009. *Бичил уурхайн аюулгүй ажиллагааны нэгдсэн дүрэм, заавар*, ШХА, УБ
15. *“Хувиараа ашигт малтмал олборлогчдын нөхөрлөлийн дүрэм”*, АМГТХЭГ-ын даргын 2008 оны 04 сарын 14-ний өдрийн 149 дүгээр тушаалын 4 дүгээр хавсралт
16. *Socio-economic situation of informal gold miners in Mongolia (survey report)*, joint: UNFPA, Government of Japan, School of public health, health sciences university of Mongolia; UB, 2007
17. T.Navch, Ts.Bolormaa, B.Enkhtsetseg, D.Khurelmaa, B.Munkhjargal. *Informal gold mining in Mongolia: A Baseline Survey Report Covering Bornuur and Zaamar Soums, Tuv aimag, Bangkok, International Labour Office, 2006*

ХАВСРАЛТ- 1

Хавсралт хүснэгт 5.1 Судалгаанд хамрагдагчдын хувийн жин, олборлодог алтны хэмжээ ба алт олборлолтын орлогоо мэдээлсэн байдал, улирлаар

Олборлодог алтны хэмжээ ба алт олборлолтын орлого	Улирал				Жилд
	өвөл	хавар	зун	намар	
Ажлын нэг хоногт олборлодог алтны хэмжээ					
тухайн улиралд ажилладаггүй	84.0	86.7	51.7	12.1	-
0.1429-0.6667 грамм	7.3	4.7	16.3	28.3	33.7
0.6668-1.000 грамм	6.7	6.3	12.3	29.3	33.0
1.001+ грамм	2.0	2.3	19.7	30.3	33.3
Улирал/жилд олборлосон нийт алтны хэмжээ (грамм)					
тухайн улиралд ажилладаггүй	84.0	86.7	51.7	12.0	-
2.5-17.0 грамм	8.6	3.3	14.6	30.0	31.4
17.1-65.0 грамм	6.7	8.0	20.7	40.7	35.3
65.1+ грамм	0.7	2.0	13.0	17.3	33.3
Ажлын нэг хоногт хувиараа алт олборлолтоос олдог орлого					
тухайн улиралд ажилладаггүй	84.0	86.7	51.7	12.0	-
5 714 - 27 200 төгрөг	7.3	4.7	15.0	27.0	33.3
27 201 – 45 000 төгрөг	5.4	5.6	15.0	30.0	33.7
45 001+ төгрөг	3.3	3.0	18.3	31.0	33.0
Улирал/жилд хувиараа алт олборлолтоос олдог нийт орлого					
тухайн улиралд ажилладаггүй	84.0	86.7	51.7	12.0	-
86 665-1 000 000 төгрөг	11.6	4.3	21.3	42.7	42.7
1 000 001-3 000 000 төгрөг	3.7	7.0	16.3	29.0	26.3
3 000 001+ төгрөг	0.7	2.0	10.7	16.3	31.0
Бүгд	100.0	100.0	100.0	100.0	100.0
ХАМО нарын тоо	300	300	300	300	300

Хавсралт хүснэгт 5.2 Судалгаанд хамрагдагчдын хувийн жин, алт олборлолтын зардлаа мэдээлсэн байдал, улирлаар

Хувиараа алт олборлолтын зардал	Улирал				Жилд
	өвөл	хавар	зун	намар	
Ажилласан нэг хоногт гаргасан урсгал зардал					
Тухайн улиралд ажилладаггүй	84.0	86.7	51.7	12.0	-
2 800-9 999 төгрөг	1.7	4.3	21.0	25.3	31.3
10 000-11500 төгрөг	2.7	4.3	17.3	30.7	34.0
11 501 + төгрөг	11.6	4.7	10.0	32.0	34.7
Улирал/жилд гаргасан урсгал зардал					
Тухайн улиралд ажилладаггүй	84.0	86.7	51.7	12.0	-
43 000-247 000 төгрөг	7.0	3.7	19.0	40.3	34.0
247 001-637 000 төгрөг	6.7	7.0	22.3	36.0	33.0
637 001+ төгрөг	2.3	2.6	7.0	11.7	33.0
Ажилласан нэг хоногт гаргасан капитал зардал**					
Тухайн улиралд ажилладаггүй	84.0	86.7	51.7	12.0	-
0 төгрөг	0.0	0.0	1.3	2.6	3.3
45-1 700 төгрөг	9.3	8.3	20.3	28.7	33.0
1 701-3 850 төгрөг	4.0	3.0	19.4	27.7	32.3
3 851+ төгрөг	2.7	2.0	7.3	29.0	31.3
Улирал/жилд гаргасан капитал зардал **					
Тухайн улиралд ажилладаггүй	84.0	86.7	51.7	12.0	-
0 төгрөг	0.0	0.0	1.3	2.7	3.3
500-100 000 төгрөг	15.6	12.3	40.0	52.9	35.7
100 001-160 000 төгрөг	0.4	0.3	4.0	21.7	31.0
160 001+ төгрөг	0.0	0.7	3.0	10.7	30.0
Ажилласан нэг хоногт гаргасан нийт зардал					
Тухайн улиралд ажилладаггүй	84.0	86.7	51.7	12.0	-
4 000-11 700 төгрөг	4.0	7.0	25.3	30.0	33.3
11 701-16 000 төгрөг	4.3	3.0	14.7	27.0	33.4
16 001+ төгрөг	7.7	3.3	8.3	31.0	33.3
Улирал/жилд гаргасан нийт зардал					
Тухайн улиралд ажилладаггүй	84.0	86.7	51.7	12.0	-
40 000-300 000 төгрөг	8.0	3.7	16.7	31.6	26.0
300 001-550 000 төгрөг	4.7	5.0	13.0	27.7	26.3
550 001-1 000 000 төгрөг	3.0	4.0	17.3	25.7	22.7
1 000 001+ төгрөг	0.3	0.6	1.3	3.0	25.0
Бүгд	100.0	100.0	100.0	100.0	100.0
ХАМО нарын тоо	300	300	300	300	300

Хавсралт хүснэгт 5.3 Судалгаанд хамрагдагчдын хувийн жин, алт олборлолтоос олдог ашиг, улирлаар

Алт олборлолтын ашиг	Улирал				Жилийн дундаж
	өвөл	хавар	зун	намар	
Ажлын ердийн хоногт хувиараа алт олборлолтоос олдог ашиг*					
Тухайн улиралд ажилладаггүй	84.0	86.7	51.7	12.0	-
Алдагдалтай ажилласан	2.3	0.9	6.3	12.7	16.7
20 000 хүртэл төгрөг	6.7	5.0	12.3	24.0	29.7
20 001-50 000 төгрөг	5.0	5.7	15.0	29.3	29.3
50 001, түүнээс дээш төгрөг	2.0	1.7	14.7	22.0	24.3
Улирал/жилд хувиараа алт олборлолтоос олдог нийт ашиг (төгрөг)					
Тухайн улиралд ажилладаггүй	84.0	86.7	51.7	12.0	-
Алдагдалтай ажилласан	2.3	1.0	6.3	12.7	16.3
600 000 хүртэл төгрөг	10.3	4.3	15.0	33.3	31.0
600 001-3 000 000 төгрөг	2.7	7.0	18.7	30.0	29.0
3 000 001, түүнээс дээш төгрөг	0.7	1.0	8.3	12.0	23.7
Бүгд	100.0	100.0	100.0	100.0	100.0
ХАМО нарын тоо	300	300	300	300	300

* ажлын ердийн хоногт алт олборлолтоос олдог орлогоос хоногт гаргадаг урсгал ба капитал зардлын нийлбэрийг хассан дүн

¹ улирал тус бүрд ажилласан хоногийн тоогоор жигнэсэн дундаж

ХАВСРАЛТ - 2: Судалгааны баг

Судалгааны багийн ахлагч	
В.Бэрцэцэг	“Хөгжлийн эзэд” ТББ-ийн гүйцэтгэх захирал
Тоон ба чанарын судалгааны мэдээлэл цуглуулсан:	
Д.Отгончимэг	“Хөгжлийн эзэд” ТББ-ийн ахлах судлаач
В.Алтанцэцэг	“Хөгжлийн эзэд” ТББ-ийн судлаач
Х.Отгонсүрэн	“Хөгжлийн эзэд” ТББ-ийн судлаач
Д.Жигэстэй	“Хөгжлийн эзэд” ТББ-ийн судлаач
Э.Батцэнгэл	“Хөгжлийн эзэд” ТББ-ийн судлаач
Д.Туяадэлгэр	“Хөгжлийн эзэд” ТББ-ийн судлаач
Нийгэм, эдийн засгийн мэдээлэл цуглуулсан:	
Д.Отгончимэг	“Хөгжлийн эзэд” ТББ-ийн ахлах судлаач
В.Алтанцэцэг	“Хөгжлийн эзэд” ТББ-ийн судлаач
Х.Отгонсүрэн	“Хөгжлийн эзэд” ТББ-ийн судлаач
Д.Жигэстэй	“Хөгжлийн эзэд” ТББ-ийн судлаач
Мэдээлэл боловсруулах программ бичиж, мэдээлэлд шинжилгээ хийсэн:	
Б.Мөнхжаргал	“Хөгжлийн эзэд” ТББ-ийн зөвлөх, МУИС-ийн ХАССТ-ийн багш, судлаач
Д.Отгончимэг	“Хөгжлийн эзэд” ТББ-ийн ахлах судлаач
В.Бэрцэцэг	“Хөгжлийн эзэд” ТББ, судалгааны багийн ахлагч
Судалгааны мэдээлэл компьютерт оруулсан:	
Д.Отгончимэг	“Хөгжлийн эзэд” ТББ-ийн ахлах судлаач
В.Алтанцэцэг	“Хөгжлийн эзэд” ТББ-ийн судлаач
Х.Отгонсүрэн	“Хөгжлийн эзэд” ТББ-ийн судлаач
Э.Батцэнгэл	“Хөгжлийн эзэд” ТББ-ийн судлаач
Д.Туяадэлгэр	“Хөгжлийн эзэд” ТББ-ийн судлаач
Тайлан бичсэн:	
Б.Мөнхжаргал	“Хөгжлийн эзэд” ТББ-ийн зөвлөх, МУИС-ийн ХАССТ-ийн багш, судлаач
В.Бэрцэцэг	“Хөгжлийн эзэд” ТББ-ийн гүйцэтгэх захирал
Д.Отгончимэг	“Хөгжлийн эзэд” ТББ-ийн ахлах судлаач
В.Алтанцэцэг	“Хөгжлийн эзэд” ТББ-ийн судлаач
Х.Отгонсүрэн	“Хөгжлийн эзэд” ТББ-ийн судлаач

ХАВСРАЛТ -3 Говь Алтай аймагт хууль бусаар алт олборлож буй газруудын судалгаа

1/19/2010

№	Сум, газрын нр	Газрын нэр	Ашигт малтмалын төрөл	Ашиглаж байгаа талбайн хэмжээ	Ашигт малтмал олборлож эхэлсэн он	Зохион байгуулалтанд орсон нөхөрлөийн тоо	ХАМО иргэдийн тоо			Үүнээс:						Цианит , мөнгөн ус хэрэглэдэг эсэх	Ил аргаар алт олборлодог	Далд аргаар олборлодог	Бичил уурхай эрхэлж байгаад эндсэн хүний тоо	Улсын болон орон нутгийн тусгай хамгаалаттай газар нутагтай давхцсан эсэх	ИТХ-ийн тэргүүлэгчдийн тогтоол нь улсын бүртгэлд орсон эсэх	Лицензийн дугаар	Лиценз эзэмшигчийн нэр
Эр	Эм	нийт	Байнга	Улирлын чанартай	Орон нутгийн иргэд	Бусад нутгийн иргэд	Эвдрэлд өртсөн талбай	Металхайгчын тоо	Ил аргаар алт олборлодог	Далд аргаар олборлодог	Бичил уурхай эрхэлж байгаад эндсэн хүний тоо												
1	Алтай	Шувуутайн сайр	Алт	4	2008	1	9	4	13	-	10	10	3	4	1	-	-	-	-	Үгүй		7560X	Эм өү ай си өү ХХК
2	Халиун	Чацрай	Алт	25	2009	-	650	350	1,000	-	800	766	234	20	33	-	+	-	-	Үгүй		11959X	Гоби гоулд эрержи ХХК
3	Чандмань	Самдандамба	Алт	30	2006	1	60	20	80	30	50	48	32	10	3	-	-	+	1	Үгүй		Байхгүй	
4	Есөн булаг	Ялаат	Алт	0.6	2009	-	110	40	150	-	34	113	37	0.6	23	-	+	-	-	Есөн булаг сумын ИТХ-ын тэргүүлэгчдийн тогтоолоор орон нутгийн тусгай хамгаалалтад авсан газар нутаг	үгүй	9067 X	Шин шинг пайпс ХХК
		Дөтийн даваа	Алт	1.5	2006	-	25	5	30	20	10	30	-	0.5	0	-	+	-	-			14028 X	Арган алтай ХХК
		Шаврын гол	Алт	3	2005	-	150	50	200	30	60	146	54	1.2	16	-	+	-	-			Байхгүй	
		Наран/Иххудаг	Алт	15	2009	-	1,000	640	1,640	200	50	1,000	640	15	75	-	-	-	-			Байхгүй	
		Рашаант	Алт	3	2009	-	400	200	600	20		250	350	1.3	60	-	-	-	-			Байхгүй	
5	Тайшир	Баянгол	Алт	1.2	2008	-	18	12	30	30	-	30	-	1.2	-	-	+	-	-	Үгүй		13274 X	Идэр гоулд
		Мөрөнгийн эх	Алт	4	2008	-	70	30	100	20	80	86	14	4	3	-	+	-	-	Үгүй		12702 X	Афро Азия минералз ХХК
		Далан/гашууны ам	Алт	20	2009	-	1,200	900	2,100	-	-	1,800	300	20	80	-	-	-	-	Үгүй		11961 X	Гоби гоулд эрержи ХХК
6	Шарга	Цахир худаг	Алт	15	2008	-	450	150	600	-	466	468	132	5	9	-	+	-	-	Үгүй		10910 X	Форс констракшн ХХК
		Хөх хад	Алт	10	2005	-	155	45	200	60	84	163	37	1	6	-	+	-	-	Үгүй			
		Сондуулт	Алт	5	2009	-	130	80	210	30	60	80	50	3.2	9	-	-	-	-	Үгүй		Байхгүй	
7	Тонхил	Шар хоолой, Бөөрөг, шандан нуур	Алт	120	2003	-	40	10	50	23	27	34	16	45	8	-	+	-	-	Үгүй		Байхгүй	
8	Бугат	Хар толгой	Алт	11	2009	-	56	14	70	50	20	70	-	11	4	-	+	-	-	Үгүй		Байхгүй	

Говь-Алтай аймгийн Бигэр сумын нийгэм-эдийн засгийн суурь судалгаа

		Баян сайр	Алт	0.4	2009	-	28	23	51	-	51	51	-	0.4	5	-	-	-	-	Үгүй		14578 X	Мандал Алтай ХХК
9	Эрдэнэ	Цагаан нүхэн,Алагын зоо	Аёд	1	2007	-	34	14	48	-	24	46	12	1	6	-	-	+	-	Үгүй		Байхгүй	
10	Бигэр	Агуйт,Олстой	Аёд	320	2009	-	3,300	1,700	5,000	-	1,000	1,000	4,000	10	200	-	+	-	-	Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2009 оны 77-р тогтоолоор орон нутгийн тусгай хамгаалатанд авсан	үг үй	Байхгүй Байхгүй	Маркополо ХХК
		Дөрөлж, Олон булаг	Аёд		2009	-	9,000	6,500	15,500	50	-	500	14,500	25	200	-	+	+	-				
		Сүүжийн бууц	Аёд	0.3	2009	-	40	35	75	5		56	14	0.3	6	-	+	+	-	Үгүй		11964 X	Гоби гоулд энерги ХХК
11	Цогт	Аргалын шанд	Аёд	25	2009	-	750	550	1,300	-	60	30	20	20	6	-	+	+	-	Үгүй		Байхгүй	
	Нийт			615			17,675	11,372	29,047	568	2,886	6,777	20,445	199.7	753								

*Эх үүсвэр:Говь Алтай аймгийн ЗДТГ-ын хөгжлийн бодлогын хэлтэс